СҮХБААТАР ДҮҮРГИЙН 2021 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН
ТОВЧОО

2021 оны 12 дугаар сарын 03 Улаанбаатар хот

<table>
<tr><th>№</th><th colspan="2">Агуулга</th><th>Бүгд</th><th>НЭГ.<br>“Ковид-19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого</th><th>ХОЁР.<br>Хүний хөгжлийн бодлого /эрүүл мэнд, боловсрол/</th><th>ГУРАВ.<br>Эдийн засгийн бодлого /өсөлтийг өрх бүрд/</th><th>ДӨРӨВ.<br>Засаглалын бодлого /нээлттэй хариуцлагатай дүүрэг/</th><th>ТАВ.<br>Ногоон хөгжлийн бодлого /амьдрахад таатай дүүрэг/</th><th>ЗУРГАА.<br>Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого</th></tr>
<tr><td>1</td><td colspan="2">Нийт заалтын тоо</td><td>256</td><td>4</td><td>93</td><td>9</td><td>97</td><td>40</td><td>13</td></tr>
<tr><td>2</td><td colspan="2">Хэрэгжилтийн хувь</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td rowspan="4">3</td><td rowspan="5">Засгийн газрын 206 дугаар тогтоол</td><td>(90-100 хүртэл)=100%</td><td>224</td><td>3</td><td>82</td><td>8</td><td>86</td><td>36</td><td>9</td></tr>
<tr><td>(50-89 хүртэл)=70%</td><td>17</td><td>1</td><td>5</td><td>1</td><td>5</td><td>2</td><td>3</td></tr>
<tr><td>(10-49 хүртэл)=30%</td><td>6</td><td>-</td><td>3</td><td>-</td><td>-</td><td>2</td><td>1</td></tr>
<tr><td>(0-9 хүртэл)=0%</td><td>9</td><td>-</td><td>3</td><td>-</td><td>6</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>4</td><td>Хугацаа болоогүй.</td><td></td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td colspan="3">Нийт хувь</td><td>92,8%</td><td>92,5%</td><td>92,9%</td><td>96,6%</td><td>92,2%</td><td>95%</td><td>87,6%</td></tr>
</table>

СҮХБААТАР ДҮҮРГИЙН 2021 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2021 оны 12 дугаар сарын 03 Улаанбаатар хот

<table>
<tr><th rowspan="2">Д/д</th><th rowspan="2">Дүүргийн ЗДҮАХ-ны заалт</th><th rowspan="2">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ</th><th rowspan="2">Хөрөнгийн хэмжээ /мянган төгрөг/</th><th rowspan="2">Санхүүгийн эх үүсвэр</th><th rowspan="2">Шалгуур үзүүлэлт</th><th rowspan="2">Хэмжих нэгж</th><th rowspan="2">Суурь түвшин</th><th>2021 он</th><th rowspan="3">хэлтэс</th><th rowspan="3">Хувь</th></tr>
<tr><th>Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td>16,433,628</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="10">НЭГ. "КОВИД-19" ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</td><td></td></tr>
<tr><td colspan="10">1.1 Иргэд олон нийтийг "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.</td><td></td></tr>
<tr><td rowspan="2">1</td><td rowspan="3">1.1.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгж байгууллагуудын орчинд ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл, сурталчилгаа хийж ажиллана.</td><td>Сургууль, цэцэрлэг, гэр хорооллын, айл өрх, нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй гудамж талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгэнэ.</td><td>700,000.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>19957 айл өрхийн жорлон, бохирын цооногт ариутгал халдваргүйтгэлийг ажлыг хэрэгжүүлэх</td><td>Тоо</td><td>Гэр хороололд 19957 айл өрхийн жорлон, бохирын цооног байна.</td><td>Хөрсний бохирдол багасаж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлсэн байна.</td><td>THAAX</td><td>70%</td></tr>
<tr><td colspan="9">Дүүргийн Засаг даргын Тамгын газартай 2021 оны 10 сарын 07-ны өдөр байгуулсан гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, бохирын цооногт ариутгал халдваргүйтгэл хийх ажил гүйцэтгэх гэрээний дагуу дүүргийн 9, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20-р дугаар хороодын 15,385 айл өрхийн нүхэн жорлон, бохирын цооногт лаг задлах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг 2021 оны 10-р сарын 11-ний өдрөөс 2021 оны 10-р сарын 22-ныг хүртэл өдрүүдэд “Баяндэмбэрэл” ХХК нь ариутгалын 10 баг томилон, 2 портер автомашин, 8 суудлын жижиг тэрэг, 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.</td></tr>
<tr><td>2</td><td>“Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.</td><td></td><td></td><td>2000 гаруй ААНБ-уудад цар тахлаас урьдчилан сэргийлэх, ариун цэвэр, халдваргүйн</td><td>Тоо</td><td>Нийслэл, дүүргийн Онцгой комиссын шийдвэр, нийслэлийн Засаг даргын захирамжуудын</td><td>Худалдаа, үйлчилгээний 2000 гаруй ААНБ-д “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар</td><td>ХХҮХ</td><td>100%</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | горимыг хангуулж ажиллана. | | биелэлт хангагдсан. | мэдээ, мэдээллийг хүргүүлсэн байна. | | |
| | | 1. Удирдах дээд байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийг худалдаа, үйчилгээний байгууллагуудад Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, хороод, мэргэжлийн холбоодын нийт 10 гаруй цахим хуудсаар худалдаа, үйлчилгээний 3000 гаруй цэгт мэдээллийг түргэн шуурхай хүргэсэн.<br>2. ДОК-ын шийдвэрийн хүрээнд Хүнсээр хангах багийн чиг үүргийн дагуу дүүргийн шуурхай штабт ажиллаж байгаа ажилтнуудын хоол хүнс, мөн дархлаажуулалтын цэгт ажилласан 5242 албан хаагчдын хоол хүнс, “Нэг хаалга-Нэг шинжилгээ” тандалт илрүүлгийн ажлын хүрээнд шинжилгээ авах суурин цэгүүдэд ажилласан 2985 албан хаагчдын хоолны асуудал, зорилтот бүлгийн иргэдэд олгох хүнсний тусламж зэрэг ажлуудыг зохион байгуулж, дүүргийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын нийт 9 удаагийн тушаалаар шийдвэрлэсэн.<br>3. НЗД, УБЗАА-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, ажлын байранд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг хангуулж, хоол үйлдвэрлэлийн газрууд болон саун, фитнес, интернэт, цахим тоглоомын газар, хүүхдийн тоглоомын газруудын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Хариуцлагын гэрээг 4 удаа шинэчлэн 2021 оны 06 дугаар сар, 10 дугаар сарууддад 464 газар, 11 дүгээр сард 205 газартай шинэчлэн гэрээ байгуулж, гэрээний үүргээ чанд биелүүлэн ажиллах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллалаа. Erp.ulaanbaatar.mn программын“Аж ахуйн нэгжийн бүртгэл” цэсэнд 2555 аж ахуйн нэгж, иргэнийг бүртгэн оруулсан.<br>4. УОК-ын даргын 2021 оны А/41 дүгээр тушаалаар баталсан “Түр журам”-ын хэрэгжилтийг хангах, УБЗАА, НЦУГ, НМХГ-ын даргын хамтран баталсан удирдамж, хуваарийн дагуу дүүргийн ЗДТГ, МХХ, ЦГ, дэргэдэх хэлтэс алба, хороодын албан хаагчид хяналт шалгалтын ажлыг 14:00-18:00, 21:00-01:00 цагийн хороонд явуулж, холбогдох заавар, зөвлөмж өгч, гарын авлага материал тарааж, нийт 3000 орчим байгууллагыг 15-20 удаа шалгаж, хүн хоорондын зай бариагүй, QR код болон гар бүртгэл, ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ хангалтгүй, хариуцлагын гэрээ зөрчсөн зэрэг нийтлэг 1500 гаруй зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулан ажилласан.<br>5. УОК-с өгсөн чиглэлийн дагуу дүүргийн ЭМТ-тэй хамтран дархлаажуулалтын 3-р тунд хүнс болон барааны төвлөрсөн худалдааны төвийн 1500 гаруй ажилчдыг хамруулсан. | | | | | | | | |
| 3 | 1.1.2 Цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг иргэдэд хүргэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, | Коронавируст халдвар (COVID-19)-ийн халдварын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд тодотгох, хэрэгжилтийг хханган ажиллана. | 80,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | Дүүргийн Засаг даргын 2020 оны А\33, 134-р захирамжаар 34,400.0 төгрөг шийдвэрлэж, ЭМТ-д эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, эм, бодис нийлүүлсэн. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90-ээс дээш хувьд хүргэсэн байна. | НХХ, ЭМТ, НЭМГ | 100% |

<table>
<tr>
<td></td>
<td>тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.</td>
<td colspan="9">-Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал эрсдэлийн улаан, улбар шар зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албаны бэлэн байдлыг хангах, коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, шуурхай, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 2020 онд 7 удаа 2021 онд 3 удаа тодотгол хийж, ажилласан.<br>-2020 оны 11 дүгээр сараас эхлэн дүүргийн Онцгой комиссын 14 удаагийн хурлаар үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах хөрөнгө, санхүүг шийдвэрлүүлсэн. Хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 30 удаагийн тушаал, 10 удаагийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүллээ. Холбогдох шатны байгууллагуудтай хамтран 5 удаагийн эрсдэлийн үнэлгээ зохион байгуулж, төлөвлөгөөг тухай бүр тодотгож ажилласан.<br>-Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2021 оны А/43, А45, А/91, А/113, А/152, А/159, А/160, А/404 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/35, А/36, А/43 дугаар тушаалаар нэг удаагийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн 499,751,170 төгрөгийн зардлыг шийдвэрлүүлэн, дүүргийн харьяа хэлтэс, аж, ахуй нэгж, албан байгууллага, 1-20 дугаар хорооны Засаг даргын ажлын алба, ӨЭМТ-үүдтэй хамтран коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, тандалт, шуурхай хариу арга хэмжээ авч, хэрэгжүүллээ.</td>
</tr>
<tr>
<td rowspan="2">4</td>
<td rowspan="2">1.1.3 Халдварт өвчний тандалт сэргийлэлт, бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан өвчний тархалтыг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.</td>
<td>Цочмог халдварт өвчин, шинэ сэргэж буй халдварт өвчний тандалт, сэргийлэлт, урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, өвчлөл голомтлон гарсан үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, чадавхыг тогтвортой бэхжүүлнэ.</td>
<td>30,000.00</td>
<td>Дүүргийн төсөв</td>
<td>Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч ажиллана.</td>
<td>Хувь</td>
<td>Дүүргийн Засаг даргын 2020 оны А\337-р захирамжаар 4,217.2 шийдвэрлэн, ӨЭМТ-дэд шаардлагатай ариутгалын бодис материал нийлүүлсэн. Нэмэлт дархлаажуулалт 90,7%-тай.</td>
<td>Шуурхай хариу арга хэмжээний багийг сургаж дадлагажуулах арга хэмжээ зохион байгуулж, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна.</td>
<td>НХХ, ЭМТ, НЭМГ</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="9">-Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, идэвхижил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 онд 2 удаа тодотгон ажилласан.<br>• Нэг хаалга - Нэг шинжилгээ арга хэмжээнд явуулын 30 баг 142 эмч, эмнэлгийн ажилтан, дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсийн нийт 246 албан хаагч ажиллаж, нийт 9280 өрх шинжилгээнд хамруулсан.<br>• 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдөр 11 суурин цэг, 75 явуулын багаар 588 эмч, эмнэлгийн ажилтан, төрийн албан хаагч ажиллаж, 22861 иргэнийг ПГУ шинжилгээнд хамруулав.<br>• Хүн амыг ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтад хамруулах 6 чиглэл 20 заалт бүхий төлөвлөгөө хэрэгжүүлж, дүүргийн 12-оос дээш насны 116963 иргэнээс 1-р тунд 93,7% 2-р тунд 84,3% 3-р тунд 22,6%-ыг тус тус хамруулаад байна.</td>
</tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | • 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр хүртэл ойрын болон дам хавьтлын хяналтад авбал зохих 9376 иргэнийг гэрийн тусгаарлалт, ажиглалтад хянаж, 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс дүүргийн хэмжээнд тандалт, шуурхай хариу арга хэмжээг өргөтгөн зохион байгуулсан.<br>• 2021 оны 11 дүгээр сарын 23-ны байдлаар тус дүүргийн батлагдсан нийт тохиолдол 35973, тусгаарлалтын хугацаа дуусч эдгэрсэн 32722 байна. 2021 оны 5 дугаар сараас 11 дүгээр сарын 23 хүртэлх хугацаанд ойрын хавьтлын 31964 иргэнийг шинжилгээнд хамруулсан.<br>• Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/228, А/257 тоот тушаалын дагуу Сүхбаатар Сувиллын газарт Ковид-19 халдвартай өвчтөнийг эмчлэх 60 ортой эмнэлэг дэлгэн ажилласан.<br>• Дүүргийн хөрөнгө оруулалтаар 9 нэр төрлийн 33,535,500 төгрөгний яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл олголоо.<br>• Дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын А/33 дугаар тушаалаар 2021 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн Эмнэлзүйн 2 багийн 18 эмч, эмнэлгийн ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа эхлүүлж, нийт 1222 өвчтөн хэвтүүлэн эмчлүүлсэн.<br>• Сүхбаатар Эрүүл мэндийн төвд Молекул биологийн лаборатори шинээр байгуулж, Эрүүл мэндийн яамнаас 475,681,977.22 төгрөгний шаардлагатай тоног, төхөөрөмж суурилуулж, 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлж, нийт 87300 ПГУ-ын шинжилгээ хийж, 2223 эерэг тохиолдол илрүүлсэн.<br>2021 онд 3, 31 дүгээр сургууль, 143 дугаар цэцэрлэг, ЭМТ-ийн оношилгооны цэгүүдээр 169906 иргэнийг ПГУ шинжилгээнд хамруулсан. | | | | | | | | |
| ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО /ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ/ | | | | | | | | | | |
| 2.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, "ИРГЭН ТӨВТ" үйлчилгээг нэвтрүүлнэ. | | | | | | | | | | |
| 5 | 2.1.1 Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийг дүүргийн төсвөөр шинээр барьж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | Нэгдсэн эмнэлгийн газрын асуудлыг шийдвэрлэж, барилгын зураг гарган, ажлыг эхлүүлнэ. | | | Дүүргийн Нэгдсэн эмнэлэг 2004 онд менежментийн хувьчлалд орсон. Шинээр Нэгдсэн эмнэлэгтэй болж, орны тоог нэмэгдүүлнэ. | Ажлын явц | 1970 онд Сүхбаатар Нэгдсэн эмнэлэг 50 ортой байгуулагдсан. 2004 оноос Нэгдсэн Эмнэлэг бие даан удирдлагын багаар үйл ажиллагаагаа явуулж байна. | Барилгын зураг төсөв хийлгэсэн байна. | НХХ | 30% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгөөр Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт 220 орны хүчин чадалтай, 5 давхар, (давхар бүр нь 3000 м2 талбай) 12,000 м2 барилгын талбайтай шинэ эмнэлгийн барилгын ажлыг “Ванхүү” ХХК гүйцэтгэж байна. Дүүргийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн А/294 захирамжаар тус эмнэлгийн барилгын ажлын явц, ашиглалтад хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Дэлхийн жишигт нийцсэн, орчин үеийн өнөдр хүчин чадалтай эмнэлэг нь туслах барилга буюу гадна орчны тохижилт, автомашины зогсоолыг иж бүрэн шийдэж, 500 м2 талбайтай нийтдээ 12.5 мянган м2 обьектууд баригдана. Барилгын А,Б блокийн ул бетон цутгалт, баганан суурийн ажил хийгдэж дууссан. Зоорийн давхрын хана, багана, лифтний армартурчлал болон хэв хавшмалын ажил хийгдэж байна. | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 2.1.2 Дүүргийн Эрүүл мэндийн төвийг эрүүл мэндийн салбарт шинээр нэвтэрсэн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний техник технологи, шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана. | Дүүргийн Эрүүл мэндийн төвийг эрүүл мэндийн салбарт шинээр нэвтэрсэн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний техник технологи, шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана. | 200,000.00 | Дүүргийн төсөв | Өндөр хүчин чадалтай эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо нэмэгдэж, оношилгоо, эмчилгээ сайжирна. | Мөнгөн дүн | Дүүргийн төсвөөс 2020 онд 167,257.85 төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл олгосон. | Шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг үе шаттайгаар хангасан байна. | НХХ, ЭМЯ, НЭМГ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2021 оны А/43, А45, А/91, А/113, А/152, А/159, А/160, А/404 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/35, А/36, А/43 дугаар тушаалын дагуу төсвөөс нийт 499,751,170 төгрөгийн нэг удаагийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг шийдвэрлүүлэн, дүүргийн харьяа хэлтэс, аж, ахуй нэгж, албан байгууллага, 1-20 дугаар хорооны Засаг даргын ажлын алба, ӨЭМТ-үүдтэй хамтран коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, тандалт, шуурхай хариу арга хэмжээ авч ажиллаж байна. | | | | | | | | |
| 7 | 2.1.3 Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг тооцож, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллана. | Дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай гүйцэтгэлийн 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана. | 12,000.00 | Дүүргийн төсөв | Гэрээний гүйцэтгэл | Гэрээний гүйцэтгэл | 2019 оны гүйцэтгэлийн гэрээгээр А үнэлэгдсэн ӨЭМТ-ийг шагнаж урамшуулахад 4,725.5 төгрөг зарцуулсан. | Гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэсэн байна. | НХХ, ЭМТ, СТСХ | 100% |
| | | -Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1333 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2020 оны А/420 дугаар захирамжаар Гүйцэтгэлийн гэрээгээр “Бүрэн хангалттай”, “Хангалттай” үнэлэгдсэн 1-20 дугаар хорооны 16 Өрхийн эрүүл мэндийн төвд 2020 оны санхүүжилтийн 5 хувийн мөнгөн дүнгээр буюу нийт 193,879,600 төгрөгийн урамшуулал олгогдсон. | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | | -Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн А/11 дүгээр тушаалын дагуу 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн 3 талт гэрээг байгууллаа.<br>-Өрхийн эрүүл мэндийн төвийн 3 талт гэрээний 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр А буюу бүрэн хангалттай 11, В буюу Хангалттай 5 Өрхийн эрүүл мэндийн төв байна. Дүүргийн Засаг даргын гүйцэтгэлийн гэрээний үнэлгээ 90.1%, Эрүүл мэндийн төвийн даргын гүйцэтгэлийн гэрээний үнэлгээ 94.7%, Өрхийн эрүүл мэндийн төвийн үнэлгээ 90.3% үнэлэгдсэн байна. | | | | | | | | |
| 8 | | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлэх зорилгоор үйлчлэх хүрээний хүн амын тоо, байршилд тулгуурлан 2-3 Өрхийн эрүүл мэндийн төв дунд стандартад нийцсэн Цогцолбор байр барих үйл ажиллагааг эхлүүлнэ. | 3,000.00 | Улс, Нийслэл төсөв | 20 хороонд 16 ӨЭМТ-тэй. Үүнээс 3 ӨЭМТ өөрийн байргүй байна. | Тоо | Нийслэлийн Эрүүл мэндийн газарт дүүргийн ТГХШХ-ээс судалгаа хүргүүлсэн. | Цогцолбор байрны зураг төсөв хийх, газрын асуудал шийдвэрлэж, төсөвт суулгасан байна. | НХХ, ЭМЯ, НЭМГ, ЭМТ | 100% |
| 8 | | -Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 02/502 дугаар албан бичгийн дагуу Өрхийн эрүүл мэндийн төвийн стандартад нийцсэн цогцолбор байр шинээр бариулах саналыг нэгтгэн, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 3/359 дүгээр албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>-Дүүргийн 1, 2 дугаар хорооны Ачит гар өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын ажил 85%, 6 дугаар хорооны Сайн наран өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын ажил 20%-ийн гүйцэтгэлтэй байна. | | | | | | | | |
| 9 | | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн урсгал засвар хийх, тогтмол зардлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 100,000.00 | Дүүргийн төсөв | Засвар хийсэн ӨЭМТ-ийн тоо | Тоо | Дүүргийн төсвийн 78,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14-р хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийг цэвэр усны шугамд холбох болон сантехник, | Шаардлагатай Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн урсгал засвар хийж, тогтмол зардлыг шийдвэрлэсэн байна. | НХХ, ЭМЯ, НЭМГ, ЭМТ | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цахилгаан засварын ажлыг гүйцэтгэсэн. | | | |
| | | -Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн 48,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 17 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн гадна авто машины зогсоол, ногоон байгууламж, явган хүний зам, шат бүхий 560,6 мкв талбайг тохижуулсан.<br>-Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хорооны Мандам Өрхийн эрүүл мэндийн төвийн гадна бохир усны шугамыг засварлан, шинэчилж хэвийн ажиллагааг хангасан.<br>-Дүүргийн төсвийн 53,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14-р хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд цэвэр усны шугамд холбох болон сантехник, цахилгаан засварын ажил хийгдсэн.<br>-Дүүргийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/360, А/361, А/362 дугаар захирамжаар 56,0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэн, 19-р хорооны цогцолбор барилгын дээвэр болон Гүн мэдрэмж Өрхийн эрүүл мэндийн төвийн цонх, хаалга, дотор засварын ажлыг гүйцэтгэсэн. | | | | | | | | |
| 10 | | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг лабораторийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана. | 50,000.00 | Дүүргийн төсөв | Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад шинжилгээ хийлгэн, иргэдэд чирэгдэлгүй, шуурхай үйлчлэх нөхцөл бүрдэнэ. | Чан ар | Дүүргийн Засаг даргын 2019 оны А/111 дугаар захирамжаар 9,626,000 төгрөгийн үнэ бүхий 3 төрлийн түргэвчилсэн оношлуураар хангасан. | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шээсний шинжилгээний бүрэн автомат анализатороор хангана. | НХХ, НЭМГ, ӨЭМТ | 70% |
| | | Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай шээсний шинжилгээний бүрэн автомат анализаторын судалгаа гарган, техникийн тодорхойлолтыг бэлтгэв. | | | | | | | | |
| 11 | 2.1.4 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлж, нэн шаардлагатай мэргэшлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад | Хүн амын өвчлөлийн бүтэц, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, эмчилгээний шинэ арга, үр дүнг хэлэлцүүлэх зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд Онол | 3,000.00 | Дүүргийн төсөв | Эмч, мэргэжилтний судалгааны ажлын чанар ахиж, оролцогчдын тоо нэмэгдэж, харилцан туршлага судлах нөхцөл бүрдэнэ. | Тоо | “Эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэл 2020” Онол практикийн хуралд нийт 31 илтгэл хэлэлцүүлж, шилдэг 6 илтгэл шалгаруулсан. | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд Онол практикийн хурал зохион байгуулсан байна. | НХХ, НЭМГ, ӨЭМТ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулж, чадавхжуулна. | практикийн хурал зохион байгуулна. | | | | | | | | |
| | | Дүүргийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/170 дугаар захирамжаар хүн амын өвчлөлийн бүтэц, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, эмчилгээний шинэ арга, үр дүнг хэлэлцүүлэх зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд Онол практикийн хурал зохион байгуулсан. Судалгааны судалгааны 17 илтгэл хэлэлцүүлэн 2021 оны Онол практикийн хурлын илтгэлийн хураангуй эмхтгэл хэвлүүлсэн. | | | | | | | | |
| 12 | 2.1.5 Эрүүл мэндийн төвийг түшиглэн “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг үе шаттай байгуулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Идэвхтэй дасгал хөдөлгөөн, иог, бясалгал, чийрэгжүүлэлт, эрүүл зөв хооллолтыг дэмжих, сурталчлах төвийг нээж, иргэдийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлнэ. | | Дүүргийн төсөв | Нийгмийн эрүүл мэндийн төв болон үйл ажиллагаа жигдэрсэн байна. | Тоо | | ЭМС-ын 2020 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан "Нийгмийн эрүүл мэндийн төвийн дүрмийг батлах тухай" тушаалын дагуу бүтэц, орон тоог шийдвэрлэсэн байна. | НХХ, НЭМГ, ӨЭМТ | 30% |
| | | Идэвхтэй дасгал хөдөлгөөн, иог, бясалгал, чийрэгжүүлэлт, эрүүл зөв хооллолтыг дэмжих, сурталчлах төв байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн төсөв нэгтгэн, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 3/549 дүгээр албан бичгийн дагуу Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах санал хүргүүлсэн. | | | | | | | | |
| 13 | 2.1.6 Иргэн бүрийг нас, хүйсийн бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, “ИРГЭН ТӨВТ” эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно. | "Иргэн төвт" арга хэмжээг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн мобайл технологийг түшиглэн зохион байгуулж, 0-5, 5-18 насны хүүхэд, Насанд хүрэгчдийн насны бүлгээр эрт илрүүлгийн үзлэгт хамруулж, илэрсэн өвчлөлийг | | | Үзлэгийн хамрагдалт | Тоо, хувь | | Зорилтот бүлгийн хүн амын 20-оос дээш хувийг хамруулсан байна. | НХХ, ЭМТ, ӨЭМТ, ОУБ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эмчилгээний хяналтад авна. | | | | | | | | |
| | | -Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1, 2, 27, 91-р тогтоолуудын дагуу дээрх үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.<br>-2021 оны 10 сарын байдлаар эрүүл мэндийн 4, 5-р бүлгийн 831 иргэнийг мобайл ЭКГ оношилгоонд хамруулж, 255 эмгэг илрүүлж, 162 тохиолдлыг даараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. | | | | | | | | |
| 2.2 Иргэн бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. | | | | | | | | | | |
| 14 | 2.2.1 Иргэдийг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд 1 удаа хамруулан эрүүлжүүлнэ. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэг шинжилгээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран жилд 1 удаа зохион байгуулах, эрүүлжилтийг хянана. | | | Багцын үзлэгт хамрагдсан хүний тоо | Тоо | Урьдчилан сэргийлэх багцын үзлэгт 1500 иргэн хамруулсан. | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтыг өмнө оноос 10%-иар нэмэгдүүлсэн байна. | НХХ, ЭМТ, ӨЭМТ, ОУБ | 100% |
| | | Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн багцын үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг хойшлуулсан.<br>-Эрүүл мэндийн сайдын А/145 дугаар тушаалын дагуу дүүргийн төр, хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 48 сургуулийн бага ангийн болон 64 цэцэрлэгийн багш, ажилтаныг 2021 оны 08 дугаар сарын 09-нөөс 08 дугаар сарын 29-ний хооронд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулав. Цэцэрлэгийн хамрагдвал зохих 1342 багш, ажилтанаас 1095 /81,5%/, ерөнхий боловсролын сургуулийн хамрагдвал зохих 3093 багш, ажилтанаас 1533 /49,5%/ хамрагдлаа.<br>-2021 оны 08 дугаар сарын 23-наас 08 дугаар сарын 29-ний хооронд хугацаанд дүүргийн төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 249 бүлгийн 4,5 настай 5744 хүүхдээс 2910 буюу 50,6% хүүхэд нь шинжилгээнд хамрагдсан.<br>-Коронавируст халдвараас сэргийлэх, төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, тэдний дархлааг дэмжих ажлын хүрээнд дүүргийн ЗДТГ-ын даргын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/87 дугаар тушаалаар 19,110,000 төгрөг шийдвэрлэж, нийт 147 ажилтан албан хаагчдын 62 албан хаагч СӨҮЛ эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц шинжилгээнд хамрагдаж, 85 албан хаагчдад дархлаа дэмжих бүтээгдэхүүн олгов.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар 4,415,000 төгрөг шийдвэрлэн, коронавируст халдвар илрүүлэх 250 ширхэг түргэвчилсэн оношлуур, эмнэлгийн яаралтай тусламжийн эм, тариа, хэрэгсэлийн нөөц авч, халдварын шинж тэмдэг илэрсэн давхардсан тоогоор 147 албан хаагчаас шинжилгээ авахад ковидын халдварын 24 эерэг тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулаа. | | | | | | | | |
| 15 | 2.2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амны | Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үзлэг, сургалтад хамрагдсан | Тоо, хувь | Үзлэгт хамрагдсан хүүхэд 4837, өвчлөл илэрсэн | Зорилтот насны хүүхдийн 30-аас доошгүй хувийг | НХХ, ЭМТ, БХ | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөндийн эрүүл мэндийг хамгаалах, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2-12 насны хүүхдийг жил бүр үе шаттай хамруулах, өвчилсөн хүүхдийг эрүүлжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээ зохион байгуулна. | | | хүүхдийн тоо, эрүүлжилтийн хувь | | 3491, эрүүлжилт 59.4% | урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчилсөн тохиолдлын 25-аас доошгүй хувийг эрүүлжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаанд 15%-ийг хамруулсан байна. | | |
| | | -Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрийн дагуу "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" арга хэмжээний 6 заалттай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, 2021 оны 10 сарын байдлаар 2-12 насны 2551 хүүхэд үзлэгт хамруулсан байна.<br>-Шүдний өвчлөлтэй 2112 хүүхдийн 64,7%-ийг эрүүлжүүлж, 416 эцэг эх, 867 хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Эрүүлжилт өмнөх оноос 4,7%-аар өссөн. | | | | | | | | |
| 16 | 2.2.3 Сүрьеэ өвчний эрт илрүүлгийг явуулын хэлбэрт шилжүүлж, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлнэ. | Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амыг сүрьеэгийн эрт илрүүлэгт явуулын хэлбэрээр хамруулж, эрт илрүүлгийн хувийг жил бүр нэмэгдүүлэх, оношлогдсон тохиолдлыг эмчилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ зохион байгуулна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн, илэрсэн өвчлөлийн тохиолдол, эмчилгээний хамралт | Тоо, хувь | Үзлэгт хамрагдсан хүний тоо 6541, илэрсэн өвчлөлийн 36 тохиолдлыг хяналтад авсан. | Өмнөх оноос эрт илрүүлэг 5%-иар нэмэгдсэн байна.Оношлогдсон тохиолдлыг эмчилгээнд бүрэн хамруулсан байна. | НХХ, ӨЭМТ, Хороод | 100% |
| | | -ХӨСҮТ болон Солонгосын сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран эрсдэлт бүлгийн нийт 234 иргэнийг сүрьеэ өвчин илрүүлэх үзлэгт хамруулж, үзлэгээр 39 хүүхдэд сорил тавьж, 19 иргэнийг цэрний шинжилгээнд хамруулж, батлагдсан 2 хүүхэд, 3 иргэнийг эмчилгээнд хамруулав. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -2021 оны 8 дугаар сард ерөнхий боловсролын 58, 71-р сургуулийн нийт 102 багш, ажилчдыг сүрьеэ илрүүлэх үзлэгт хамруулан, батлагдсан 1 ажилтан эмчилгээнд хамрагдсан.<br>-Дүүргийн харьяалалтай цэцэрлэг, сургуулийн 1768 багш, ажилчдыг Сүхбаатар Эрүүл мэндийн төвийн рентген үзлэгт хамруулаа.<br>-Сүхбаатар Эрүүл мэндийн төв, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран 2021 оны 6, 8 дугаар сард өөрийн гэр оронгүй болон СӨХ-ийн ажилчдын дунд сүрьеэгийн идэвхитэй илрүүлэг үзлэг зохион байгуулж, нийт 214 иргэн хамруулсан. Цээжний рентгенээр сүрьеэгийн сэжигтэй 21, цэрний шинжилгээгээр эерэг 2 тохиолдол илрүүлж, харъяаллын дагуу Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн хяналтад эмчлэгдэж байна.<br>-ХӨСҮТ, Сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран дүүргийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/143 дугаар захирамжийг хэрэгжүүлэн, 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 12 дугаар сарын 24-ний өдрүүдийн хугацаанд хуваарийн дагуу хороодын эрсдэлт бүлгийн иргэдийн дунд сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг зохион байгууллаа. Дүүргийн 1-20 дугаар хорооны Засаг даргын ажлын алба, Өрхийн эрүүл мэндийн төв хамтран ажиллаж, үзлэгт нийт зорилтот бүлгийн 3600 иргэн хамрагдахаас 2903 бүртгүүлж, асуумж, ярилцлагад 2897, рентген үзлэгт 2887, цэрний шинжилгээнд 45 хүн хамрагдаж, 5 иргэн сүрьеэгийн халдвартай оношлогдож, эмнэлгийн хяналтад эмчилгээнд илгээсэн байна. | | | | | | | | |
| 17 | 2.2.4 Сургуулийн ахлах ангийн сурагчид, 18-аас дээш насны залуучуудыг БЗДХ, ХДХВ, 45-аас дээш насны иргэдийг Хепатитийн В, С вирус зэрэг халдварт өвчний эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулж, “ЭРҮҮЛ ГЭР БҮЛ-ЭРҮҮЛ ХҮҮХЭД” хөдөлгөөн өрнүүлнэ. | “ЭРҮҮЛ ГЭР БҮЛ-ЭРҮҮЛ ХҮҮХЭД оюутан, залуучууд” арга хэмжээ зохион байгуулж, зорилтот насны хүн амыг БЗДХ, ХДХВ, ДОХ илрүүлэг шинжилгээнд хамруулан, эмчлэн эрүүлжүүлнэ. | 50,000.00 | Дүүргийн төсөв | Зорилтот хүн ам, үүнээс үзлэгт хамрагдалт, илэрсэн өвчлөл | Тоо, хувь | Зорилтот бүлгийн 61732 хүн амын 33651 буюу 54.5%-ийг үзлэгт хамруулж, 222 өвчлөлийн тохиолдол илрүүлсэн. | Тухайн жилийн зорилтод насны хүн амын 50%-ийг хамруулсан байна. | НХХ, НЭМГ, ХСҮТ, НХХ, ОУБ | 100% |
| | | -2021 оны эхний 10 сард тэмбүү 78 тохиолдол буюу 5,4, заг хүйтэн 37 тохиолдол буюу 2,6, трихомониаз 8 тохиолдол буюу 0,6 промиль байна. Өмнө оноос тэмбүү 10,1, заг хүйтэн 2,5, трихомониаз 3,3 промилиор тус тус буурсан.<br>-18-45 насны 5603 иргэний ХДХВ, тэмбүү өвчний илрүүлэг шинжилгээнд хамруулж, тэмбүүгийн өвчлөл 78 тохиолдол илрүүлж, эмчилгээнд 100% хамруулсан. Хавьтал илрүүлэлт 80,3%-тай байна.<br>-Сайн дурын зөвлөгөө шинжилгээнд 370 хүн хамрагдаж тэмбүүгийн 6 тохиолдол илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Хамрагдалт өмнө оны мөн үеэс 42%-иар буурсан байна.<br>-2021 оны эхний 10 сард “Элэг бүтэн Монгол“ үндэсний хөтөлбөрийн хүрээнд дүүргийн 15-аас дээш насны 3112 иргэнийг В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд хамруулсан.<br>Эрт илрүүлэг шинжилгээгээр 135 иргэн буюу 4.3%-д С вирус, 141 иргэн буюу 4.5%-д В вирус илэрч, С вирусийн ачаалал тоолох шинжилгээнд 336, В вирусын ачаалал тоолох шинжилгээнд 204 иргэнийг илгээж, С вирусын эсрэг эмчилгээнд 98, В вирусын эсрэг эмчилгээнд 29 иргэнийг тус тус хамруулсан. Эмчилгээний үр дүн 98,2%-тай байна. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | 2.2.5 Дархлаажуулалтын хамрагдалтыг сайжруулж, халдварт өвчний тохиолдлыг бууруулна. | Дүүргийн хэмжээнд халдварт өвчин, амьсгалын замаар дамжих халдварт өвчний эсрэг үндэсний товлолын болон нэмэлт дархлаажуулалтын хамралтыг сайжруулна. | | | Дархлаажуулалтын хамралт | Хувь | Үндэсний товлолын дархлаажуулалт 97%-тай хийгдсэн. | Товлолын дархлаажуулалтын хамралтыг 95%-иас доошгүй, нэмэлт дархлаажуулалтад зорилтот хүн амын 90%-иас доошгүй хамруулсан байна. | НХХ, ӨЭМТ | 100% |
| | | -Заавал хийх үндэсний товлолын дархлаажуулалтад 2021 оны 10 дугээр сарын байдлаар 35285 хүүхэд хамруулахаас 34149 хүүхэд буюу 96,7%-ыг хамруулж, өмнө оны мөн үеэс ижил түвшинд байна.<br>-Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл /ДДУХ/-ийн 6 тохиолдол бүртгэгдэж, ДДУХ-ын тохиолдол бүрийг Эрүүл мэндийн сайдын А/527 дугаар тушаалын дагуу мэдээлж, дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны А/21 дүгээр тушаалын дагуу байгуулагдсан дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн үед ажиллах мэргэжлийн багаар дархлаажуулалт хийгдсэн нэгжид шалтгаан хамаарлыг тогтоон, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. ДДУХ-ын тохиолдол өмнө оноос 2 тохиолдлоор буурсан.<br>-Пневмококкийн эсрэг вакцинд 2021 оны эхний 10 сарын байдлаар I тун 2054 хүүхэд хамрагдахаас 2049 буюу 99,6%, II тунд 2129 хүүхэд хамрагдахаас 2022 буюу 95%, III тунд 2108 хүүхэд хамрагдахаас 2044 буюу 97%-ыг хамруулсан. Нийт 6291 хүүхэд хамрагдахаас 6115 хүүхэд буюу 97,2%-ыг хамруулж, өмнө оны мөн үетэй ижил түвшинд байна.<br>-МУЗГ-ын 2020 оны 73-р тогтоол, УОК-ын даргын 2021 оны 05 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/33, А/69, А/108, А119, А/159, А/168, А/180, А/291, А296, А/297, А/308, А/310, А/368, А/391, А/404, А/436, А/539, А/564, А/642 дугаар тушаал, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/17, А/18 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/375 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган, Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны А/14, А/19, А/31, А80 дүгээр тушаалын дагуу хүн амыг ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтад хамруулах 6 чиглэл 20 заалт бүхий төлөвлөгөө хэрэгжүүлж, дүүргийн 12-оос дээш насны 116963 иргэнээс 1-р тунд 93,7% 2-р тунд 84,3% 3-р тунд 22,6%-ыг тус тус хамруулсан | | | | | | | | |
| 19 | 2.2.6 Ажил эрхэлдэггүй, дунджаас доогуур орлоготой иргэдэд эрүүл мэндийн даатгалд хамрагдах талаар сурталчилж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, “Хэнийг ч орхигдуулахгүй | "Иргэн төвт" арга хэмжээнд ажил эрхэлдэггүй, дунджаас доогуур орлоготой иргэдийг хамруулна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | Хамрагдсан хүн амын хувь | Хувь | Зорилтот бүлгийн 172 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. | Зорилтот бүлгийн хүн амын 5 хүртэлх хувийг ажил эрхэлдэггүй, дунджаас доогуур орлоготой иргэдийг хамруулсан байна. | НХХ, ЭМТ | 100% |
| | | -Өвчтөн нийгмийн төлөөлөл ТББ-тай хамтран эрүүл мэндийн даатгалгүй 2000 иргэнд хепатитийн В, С вирүс илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан зохион байгуулсан. Түргэвчилсэн шинжилгээгээр В вирүсийн 43, С вирүсийн 57 тохиолдол илрүүлэн дараагийн шатны тусламж үйлчилгээнд шилжүүлсэн. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байх” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | -2021 оны 10 сарын байдлаар Коронавируст халдвараар өвчилсөн эрүүл мэндийн даатгалгүй 2482 иргэнийг Өрхийн эрүүл мэндийн төвүүд гэрээр тусгаарлан, 10-14 хоногийн туршид хянаж ажилласан. | | | | | | | | |
| 20 | 2.2.7 Сүхбаатар сувиллын газрыг “Харвалтын дараах сэргээн засах төв” болгон өргөжүүлж, эмчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Сувиллын газар нь Сэргээн засахын төв болохтой холбогдуулан MNS 6801:2019 “Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагаа” стандартын дагуу хүний нөөц, тоног төхөөрөмж, эмчилгээ, оношилгоог үе шаттай нэмэгдүүлэн, хүртээмжийг сайжруулна. | 50,000.00 | Дүүргийн төсөв | Стандартын хэрэгжилт | Хувь | Дүүргийн төсвөөс чийрэгжилтийн тоног төхөөрөмж хэрэгсэл олгосон. 70% | Сувиллын газар нь Сэргээн засахын төв болохтой холбогдуулан MNS 6801:2019 “Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагаа” стандартад хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна. | НХХ, НЭМГ, ЭМТ | 100% |
| | | -Эрүүл мэндийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/228 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/257 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ЭМТ-ийн даргын 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Сувиллын газарт Коронавирусын халдвартай тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн бэлэн байдлыг хангаж, тусламж үйлчилгээг үзүүлэх тухай” А/33 дугаар тушаалаар 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Сувиллын газарт Коронавирусын халдвартай тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх эмнэлгээр ажиллуулж байна. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Сувиллын газарт Коронавирусын халдвартай тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн бэлэн байдлыг хангаж, тусламж үйлчилгээг үзүүлэх тухай” А/33 дугаар тушаалаар 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Эмнэлзүйн 2 багийн 18 эмч, эмнэлгийн ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа эхлүүлж, нийт 1222 өвчтөнг хэвтүүлэн эмчлүүлсэнээс 1103 өвчтөнг эрүүлжүүлж, эмнэлгээс гаргасан.<br>-Дүүргийн хөрөнгө оруулалтаар Сувилалын газарт коронавирус /ковид-19/ халдварын үед 9 нэр төрлийн 33,535,500 төгрөгний яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авч, эмчилгээ үйлчилгээнд ашиглаж байна. | | | | | | | | |
| 21 | 2.2.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар Комиссын үйл ажиллагааг дэмжин ажиллана. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Дэмжлэг үзүүлсэн хүүхдийн тоо | Тоо | Сард 2 удаа ХБХ-ийн асаргаа тогтоох, бэрхшээлийг тодорхойлон дүгнэлт гаргадаг. | Комиссын үйл ажиллагааг дэмжиж ажилласан байна. | НХХ, ХөХҮХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг дэмжин ажиллана. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байнгын асаргаа сунгах, тогтоох хурлыг холбогдох бичиг баримт, үзлэг, шинжилгээ, үнэлгээ, оношийн баталгаажилт бичилтийг үндэслэн цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллалаа.<br>18 удаагийн хурлаар 263 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: шинээр тогтоосон-50, сунгасан-199, цуцалсан-2, онош тодруулахаар-8, хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолтыг-4 хүүхдэд өгч ажилласан.<br>Өрхийн эрүүл мэндийн төвийн 20 эмчийг чадавхжуулах сургалтанд хамруулж, гарын авлага материалаар ханган, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.<br>16 дугаар хорооны 2 ихэр хүүхэд Одгийв, Азгийв нарын гэр бүлд жилийн хугацаанд кейсын үйлчилгээ үзүүлэх хөгжил, хамгааллын төлөвлөгөө гарган гарааны ажлыг эхлүүлсэн.<br>АШУҮИС-ийн Молекул эмнэлзүйн оношлогооны төвтэй хамтран 186 дугаар тусгай цэцэрлэгийн 15 хүүхдэд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх “Лолли поп” шүлсний ПГУ тандалтын шинжилгээг хийж, хяналтанд авлаа. | | | | | | | | |
| 22 | | Сургуулийг дэмжих зөвлөлөөр дамжуулан боловсролд тэгш хамруулан сургах ажлыг зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | Тоо | 300 | Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан байна. | НХХ, БХ, ЕБС | 100% |
| | | -Хөгжлийн бэрхшээлтэй эсвэл суралцахуйн хоцрогдол, зан үйлийн асуудалтай зэрэг боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургууль нийтээр дэмжлэг үзүүлэх зорилгоор Боловсролын хэлтсийн даргын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Дэмжлэгийн баг байгуулах тухай А/15 дугаар тушаал гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>-Ерөнхий боловсролын төрийн өмчийн сургуулийн дэргэд 3-5 хүний бүрэлдэхүүнтэй сургуулийг дэмжих зөвлөл байгууллаа.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа тогтоосон 414 хүүхдийн боловсролын байдлын судалгаанд тодотгол хийж ажилласан.<br>- Тус дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй 414 хүүхдээс цэцэрлэгт 44, ерөнхий боловсролын сургуульд 210, гэртээ болон гадаадад 160 хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших асуудлыг шийдвэрлэх зорилгоор 16, 35, 6 дугаар сургуулиуд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах 2-р шатны төсөлд хамрагдахаар сонгогдож, сургуулиудын удирдлагын багт зориулсан сургалтад оролцуулан 16 дугаар сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 16 суралцагч, 35 дугаар сургуульд 13 суралцагч суралцуулж байна.<br>- Иргэний зориулалттай барилгын орчин, дотоод орон зайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтийн MNS6055:2009 стандартын дагуу ерөнхий боловсролын 2, 3, 16, 25-р сургуулиуд гадна болон дотно орчноо тохижуулсан. -2021-2022 оны хичээлийн жилд 19 сургуульд 644 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсрлын сургуульд хамруулсан. | | | | | | | | |
| 23 | | Хүүхэдтэй ажиллах арга зүйд багшийг сургана. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Багшийн тоо | Тоо | 10 | Арга зүйд сургасан байна. | НХХ, БХ, ЕБС | 100% |
| | | -БШУЯ-наас Японы хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулсан “ Багш нар хүүхэдтэй эерэг аргаар харилцах арга зүй” сэдэвт онлайн сургалтанд 44 арга зүйч, 52 багш, нийт 96 хүнийг хамруулан сургагч багшаар бэлтгэн, цэцэрлэгийн бүх удирдлага, багш, ажилтанд түгээн дэлгэрүүлж ажилласан. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | - “Орон нутгийн дэмжлэгт түшиглэн хүүхдэд зөвлөн туслах үйлчилгээг хөгжүүлэх нь” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй монгол хүүхдэд зөвлөгөө өгөх, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлага, бүлгийн багш нарт дэмжлэг үзүүлэх зориолготой цуврал онлайн сургалтад төрийн өмчийн цэцэрлэгийн 4 эрхлэгч, 5 арга зүйч, 31 багшийг хамруулсан.<br>-“Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй, бага ангийн жишээн дээрх 172 шинэлэг санаа” гарын авлагад байгаа шууд турших болох сургалтын арга барилыг бага ангийн багш нарт цахимаар хүргүүлэн ажиллаж байна.<br>-“Хараагы бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулж сургах нь” сургалтад бүрэн хараагүй болон сул хараатай хүүхэдтэй ажиллаж буй анги удирдсан 8 багш, 6 мэргэжилтэн оролцуулж, бүрэн хараагүй 3 сурагчид “Дэйзи” уншигч төхөөрөмжийг олгосон.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газартай хамтран 2, 3, 4, 6, 16, 35, 45, 71, ЭХЦС, МУБИС-ийн 10 сургуулийн 100 багшийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, багшлах арга зүйг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчинг бүрдүүлэх цахим сургалтад хамруулсан.<br>-Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийг чадавхижуулах сургалтад 9 сарын 20-24 ний өдрүүдэд 1, 2, 16, 71, 35, 116 дугаар сургуулийн 9 багшийг оролцуулсан.<br>-2021 оны 10 сарын 1-ний өдөр Койкагийн “Тэгш хүртээмжтэй боловсрол түүний эргэн тойронд” мэдлэг хуваалцах цахим сургалтад 2, 6, 16, 45, 71 дүгээр сургуулийн сургалтын менежерүүд хамрагдсан.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад нийт 264 багш, ажилтан хамруулсан байна. | | | | | | | | |
| 2.3. Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана. | | | | | | | | | | |
| 24 | 2.3.1 Нийтийн биеийн тамир, спортын тэмцээн уралдааныг тогтмолжуулж, иргэдийн бие бялдрын хөгжлийг дэмжиж ажиллана. | Дүүргийн хэлтэс, албад, хороодын дунд спорт наадам, өдөрлөгүүд зохион байгуулна. | 23,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | Жил бүр дэргэдэх хэлтэс, албад, ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын спорт тэмцээнийг зохион байгуулж байна. | Уралдаан, тэмцээнд оролцогчдын тоог нэмэгдүүлж, нийслэлийн тэмцээнд амжилттай оролцуулсан байна. | НХХ, БТСХ | 100% |
| | | -Дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл чийрэг байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өглөө бүр ажлын цаг эхлэхээс 10 минутын өмнө дархлаагаа дэмжих дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвшсэн.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын дунд “Нөхөрсөг-2021” тэмцээнийг 2021 оны 11 дүгээр сарын 18,19,20-ны өдрүүдэд спортын /шатар, дартс, волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөг / 5 төрөлт тэмцээнийг 6 багийн 32 тамирчин хамруулан зохион байгууллаа. I байрт Аванжерс баг, II байрт Старс баг, III байрт Аваргууд багууд тус тус эхний 3 байр эзэллээ.<br>-Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Журам батлах тухай 45 дугаар тогтоол, 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай 176 дугаар тогтоол, 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 259 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Түр журам батлах тухай 18,20,21 дүгээр тушаал, 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу коронавирусийн халдвар тархалтаас сэргийлэн олон нийтийг хамарсан тэмцээн уралдаан зохион байгуулагдаагүй. | | | | | | | | |
| 25 | | Ахмадын хавар, намрын өдөрлөг, хөгжлийн | 15,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны | Тоо | 2019 онд ахмадын хавар, намрын спорт наадамд нийт | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй | НХХ, БТСХ, АХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэрхшээлтэй иргэдийн спорт өдөрлөг зохион байгуулна. | | | хэрэгжилт, хувиар | | 350 гаруй ахмад настан оролцсон. | иргэний идэвх санаачилга сайжирсан байна. | | |
| | | -Нийслэлийн граунд гольфийн аварга шалгаруулах тэмцээн 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдаж, дүүргийн 15 ахмад тамирчин оролцсоноос, Д.Хаш, Н.Баасандорж, О.Чимэдсамбуу, Н.Алтанцэцэг нар "Алтан бөмбөг"ийн эзэн шагналаар шагнуулсан.<br>-Ахмад настнуудыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт байрлах гадаа талбайд өглөөний дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвшүүлээд байна.<br>-Монголын Хийн дасгалын холбоотой хамтран гимнастрадагийн дасгал хөдөлгөөнийг 30 гаруй ахмад настанд сургаж, сургагч багш бэлтгэлээ. Биеийн тамир, спортын улсын хорооноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан "Цахимаар хөгжицгөөе шатрын тэмцээн"-ий удирдамжийг хороодод хүргүүлэн сурталчилав. | | | | | | | | |
| 26 | 2.3.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжиж ажиллана. | Өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр өргөтгөн зохион байгуулж, баг тамирчдыг хот, улс, олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | 15,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | Өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрөл /шатар, зуун буудалт даам, ширээний теннис, дугуй, хөлбөмбөг, сагсан бөмбөг, чөлөөт бөх, жүдо бөх, тэшүүр, гандбол/-өөр хичээллүүлсэн. | Олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцож, амжилт гаргасан байна. | НХХ, БТСХ | 100% |
| | | -Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих, баг тамирчдын бэлтгэлийн орчин нөхцлийг сайжруулах, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх таатай орчин бүрдүүлэх, зорилгоор дүүргийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/237 дугаар захирамжаар 69,472,111 төгрөгийн санхүүжилт шийдвэрлэн, Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хөл бөмбөгийн талбайн суурийг шинэчлэн засварлаж, Олон Улсын стандартад нийцсэн жижиг хөл бөмбөгийн талбайг тохижуулсан.<br>-Дүүргийн Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн гадна талбайн тохижилт, 3 дугаар сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтын ажлын зураг төсвийг 2022 оны төсөвт тусгахаар санал хүргүүлсэн.<br>-Дүүргийн Засаг даргын 2021 оны захирамжаар Өсвөрийн шигшээ багийн 3 төрөл (сагс, гар бөмбөг, хөл бөмбөг)-ийн баг тамирчдын тоглолтын өмсгөл хувцас шинээр хийлгэхэд 7,800,000 төгрөг шийдвэрлэсэн. | | | | | | | | |
| 27 | 2.3.3 Иргэд, зорилтот бүлгүүдийн дунд бүх ард түмний, хүүхдийн, үндэсний, оюутны спортын их | Хүүхдийн, Иргэдийн, Үндэсний, Оюутны Их наадмууд, Монголын | 35,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо, чанар | Спорт наадмуудад амжилттай оролцож байна. | Оролцогчдын тоог нэмэгдүүлж, уралдаан тэмцээнд амжилт гаргасан байна. | НХХ, БТСХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | наадмуудыг зохион байгуулж, дүүргийн баг тамирчдыг оролцуулна. | бүх ард түмний спартикад зохион байгуулна. | | | | | | | | |
| | | -Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Журам батлах тухай 45 дугаар тогтоол, 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай 176 дугаар тогтоол, 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 259 дүгээр тогтоол, 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Спортын наадам хойшлуулах тухай 268 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Түр журам батлах тухай 18, 20, 21 дүгээр тушаал, шийдвэрийн дагуу коронавирусийн халдвар тархалтаас сэргийлэн олон нийтийг хамарсан тэмцээн уралдаан зохион байгуулагдаагүй болно. /2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Спортын наадам хойшлуулах тухай 268 дугаар тогтоолоор хойшлуулсан.<br>-Нийслэлийн Иргэдийн спортын IX наадам болохтой холбогдуулан дүүргийн Засаг даргын 2021 оны захирамжаар иргэдийн дунд 2021 оны 12 дугаар сарын 04-нөөс 12 дугаар сарын 12-ны өдрүүдэд спортын 4 (олс таталт, ширээний шагаан наадгай, волейбол, сагсан бөмбөг) төрлөөр тэмцээн зохион байгуулахад шаардлагатай 14,303,500 төгрөгийг шийдвэрлэлээ. | | | | | | | | |
| 28 | 2.3.4 Иргэдэд амьдралын зөв дадал хэвшил олгох, “Зохистой хооллолт-идэвхтэй хөдөлгөөн” аян, бие бялдрын чийрэгжилтийн төвшин тогтоох сорил хөтөлбөрийг өрнүүлнэ. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Хүн амын бие бялдрын чийрэгжиилтийн түвшин тогтоох сорил"-д иргэдийг өргөнөөр хамруулна. | 2,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | Бүх нийтийн бие бялдрын чийрэгжилтийн түвшинг тогтоож, идэвхтэй дасгал, хөдөлгөөнд өргөнөөр хамруулан ажиллаж байна. | Хүн амын бие бялдрын түвшинг тогтоосон байна. | НХХ, БТСХ | 0% |
| | | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Журам батлах тухай 45 дугаар тогтоол, 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай 176 дугаар тогтоол, 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 259 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Түр журам батлах тухай 18,20,21 дүгээр тушаал, 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу коронавирусийн халдвар тархалтаас сэргийлэн олон нийтийг хамарсан тэмцээн уралдаан зохион байгуулагдаагүй болно. | | | | | | | | |
| 29 | | Бүх нийтийн спорт өдөрлөг, спорт явган аялал, марафон зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | | Уралдаан, тэмцээнд оролцогчдын тоог нэмэгдүүлсэн байна. | НХХ, БТСХ | 100% |
| | | -Ковид-19 халдварын үед биеийн дархлааг дэмжих “Эрүүл мэндийн цахим гүйлт - 2021” биеийн тамирын үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд улс орон даяар зохион байгуулсантай холбогдуулан дүүргийн хэмжээнд Сүхбаатарын гүйгчид 2021 цахим хаягаар “Цахим гүйлт 2021” арга хэмжээг сурталчилан, 350 иргэн нийт 3100 км гүйсэн байна. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | | -Биеийн тамир, спортын Улсын хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/28 дугаар тушаалын дагуу 2021 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан “Дасгал хөдөлгөөн хийцгээе” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяны хүрээнд “Алхах-Гүйх-Дугуй унах”, “Селфиний уралдаан”-д дүүргийн төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулан, шалгарсан иргэдэд Батламж гардуулсан.<br>-Дүүргийн Засаг даргын 2021.06.23-ны өдрийн А/190 дүгээр захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт биеийн тамир, спортын зориулалтаар ашиглаж байгаад иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад эзэмшил нь шилжсэн талбайг зориулалтын дагуу ашиглах, сэргээн засварлах, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Ажлын хэсэг ерөнхий боловсролын 18 сургууль, 3 ААНБ-аар хяналтаар явж, дүгнэлт гарган, нийслэлийн БТСХ-нд хүргүүлсэн. | | | | | | | | |
| | | “Спорт цогцолбор”-ын барилгын ажлын явцыг эрчимжүүлж, ашиглалтад оруулна. | | | Үйл ажиллагааны хэрэгжилт, ажлын явц | Ажлын явц | Барилгын ажлын гүйцэтгэгч ХХК одоогийн байдлаар нийт 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, барилгын ажил 40 хувьтай явагдаж байна. | Иргэд, хүүхэд залуучууд спортоор хичээллэж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдсэн байна. | НХХ, БТСХ | 100% |
| 30 | 2.3.5 “Спорт цогцолбор”-ын барилгын ажлын явцыг эрчимжүүлж, ашиглалтад оруулна. | -Дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэр, Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн хойд талд 1000 хүний суудалтай дүүргийн Спорт цогцолборын барилга барих ажил 2010 онд 7.4 тербум төгрөгөөр батлагдаж, 2020 онд хэрэгжүүлж дуусахаар улсын төсөвт тусгагдсан байдаг. Барилгын ажлын гүйцэтгэгчээр “Грийн ресус” ХХК шалгарч, 2015 онд Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, спортын яамтай гэрээ байгуулан ажиллаж, одоогийн байдлаар 3 блок барилгын спорт заалны зориулалттай 2 блокын карказ угсралтыг бүрэн хийж, дотор, гадна хананд тоосго, блок өрлөгө хийгдэж байгаа бөгөөд Усанбассейны зориулалттай 1 блокын ажил огт хийгдээгүй байна. Барилгын ажил гүйцэтгэгч “Грийн ресус” ХХК Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, спортын яамтай гэрээ байгуулан ажиллаж байсан ч, яаманд бүтцийн өөрчлөлт орж, Биеийн тамир, спортын Улсын хороонд эрх нь шилжсэн.<br>Спорт цогцолборын барилгын ажлын үйл явцтай 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдөр УИХ-ын гишүүн Х.Ганхуяг, П.Анужин, БТСУХ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, БТСУХ-ны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адъяасүрэн нар танилцаж, дүүргийн БТСХ-ны дарга Б.Мөнх-Эрдэнэ, МУИС-ийн санхүү хариуцсан дэд захирал болон гүйцэтгэгч "Грийн Ресурс Констракшн" ХХК-ын захирал Амарбаясгалан нартай уулзаж, барилгын ажлыг 2023 онд хүлээлгэн өгөх, заасан хугацаанд хүлээлгэж өгөөгүй тохиолдолд гүйцэтгэгч компанийг солих, үлдэгдэл төсөв болох 5,2 тэрбум төгрөгийг 2022 оны улсын төсөвт тусгах чиглэл өгсөн. Спорт цогцолборын барилгын ажил сүүлийн дүн мэдээгээр 4,5 тэрбумын санхүүжилт хийгдэж, 40%-ийн гүйцэтгэлтэй байна. | | | | | | | | |
| 2.4 Сургалтын чанарыг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | |
| 31 | 2.4.1 Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барих | Төрийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн | 1,000,000.00 | Улс, Нийслэл, Дүүргийн төсөв | Сургууль, цэцэрлэг шинээр барих | Тоо | 149 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл, 24 цэцэрлэгийг буулган дахин | Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн байна. | ТГХШХ НХХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ. | барилгыг мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтэд үндэслэн зураг, төсөв боловсруулж дахин төлөвлөх, өргөтгөх, шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлүүлнэ. | | | | | төлөвлөн шинээр барьж байсан. | | | |
| | | -2020-2024 онд шинээр төлөвлөх шаардлагатай 3 сургууль, 19 цэцэрлэгийн байршлын судалгаа гаргаж, нийслэлийн Хот төлөвлөлт, хөгжлийн газар хүргүүлсэн. 2021 онд 2, 234 дүгээр цэцэрлэгийг өргөтгөх зураг, төслийг дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн.<br>-Дүүргийн хэмжээнд 2018-2021 онд он дамжин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 11, 12, 13, 16, 18-р хороодод баригдаж буй 2960 хүүхдийн суудалтай 6 сургуулийн барилгын ажлын явц 53%, 54, 149, 281, 282 дугаар цэцэрлэгийн 710 хүүхдийн ортой 4 цэцэрлэгийн барилгын ажлын явц 65%-тай байна.<br>-2021 онд 4 /25, 68, 143, 299/ цэцэрлэгийн барилга ашиглалтад орж, орны тоо 580 нэмэгдэж, шинээр 200 хүүхэд цэцэрлэгт хамруулсан. Дүүргийн хэмжээнд цэцэрлэгт хамрагдалт 2020 онд 79%-д хүрсэн боловч, цар тахалтай холбогдуулан хамрагдалт 24% буурч, 55%-д хүрсэн. | | | | | | | | |
| 32 | 2.4.2 Цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх замаар сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын бохир жинг 89.0 хувьд хүргэнэ. | Хүүхэд харах үйлчилгээг дэмжин ажиллана. | | | Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй 10 эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж тоог нэмэгдүүлнэ. | Тоо | 50 | Үйл ажиллагааг дэмжин ажилласан байна. | НХХ, БХ, ХХҮХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт Тэгс, Бяцхан эрдэмтэд, Бужин, Гандирсын хүүхдүүд 4 төв хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан. Хүүхэд харах үйлчилгээнд хяналт тавих, зөвлөн туслахаар Боловсролын хэлтсийн даргын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, 2021 оны 05 сарын 13-ны өдөр 3 төвд ажилласан. 2021-2022 оны хичээлийн жилд БШУЯ-ны Сургуулийн өмнөх боловсролын газраас хүүхэд харах үйлчилгээг эхлүүлэхгүй байх чиглэл өгсөн. | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | | Төрийн бус өмчийн цэцэрлэгийн нэмэлт элсэлтийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | | | Төрийн бус өмчийн цэцэрлэгийн сул орон тоог ашиглан хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Тоо | 51 | Үйл ажиллагааг дэмжин ажилласан байна. | НХХ, БХ | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01-р сарын 19-ний өдрийн Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэх тухай А/17 дугаар захирамжаар 2021 онд төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийн сул оронд нэмэлт элсэлтээр цэцэрлэгт хамран суралцуулах хүүхдүүдийн тоог баталсан. Энэхүү захирамжаар Үрэл хотхон, хөгжил, Эрдмийн цацраг, Гандирсын хүүхдүүд, Ногоон төгөл, Номт сансар, Цасангоо нарын 7 цэцэрлэгт 148 хүүхдийг хамруулах ажлыг зохион байгуулсан. Төрийн бус өмчийн 29 цэцэрлэгийн 1350 хүүхдийн ирцэд сар бүр хяналтын тооллого хийж, гүйцэтгэлээр хувьсах зардлын санхүүжилтийг олгож байна. | | | | | | | | |
| 34 | | Байгууллагын дэргэдэх цэцэрлэг, салбар бүлгийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | | | Байгууллагын 3 цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ. | Тоо | 52 | Үйл ажиллагааг дэмжин ажилласан байна. | НХХ, БХ, ААНБ | 100% |
| | | 2021-2022 оны хичээлийн жилд 16-р цэцэрлэгт Гадаад харилцааны яамны дэргэдэх салбар 3 бүлэгт 50, Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын түрээсийн байранд 1 бүлэг 25, Номт сансар цэцэрлэгийн түрээсийн байранд 3 бүлэгт 75, нийт 150 хүүхэд байгууллагын дэргэдэх цэцэрлэгт хамрагдсан. Шинээр АШУҮИС-ийн байранд 135-р цэцэрлэгийн салбар 3 бүлгийг ажиллуулахаар засвар, тохижилтын ажил хийгдсэн. | | | | | | | | |
| 35 | 2.4.3 Багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна. | Дүүргийн Боловсролын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлнэ. | 78,000.00 | Дүүргийн төсөв | Бодлогын баримт бичиг боловсруулсан байна. | Хувь | | Бодлогын баримт бичиг боловсруулах төлөвлөлт хийгдсэн байна. | НХХ, БХ | 100% |
| | | Дүүргийн боловсролын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах PESTER макро орчны дүн шинжилгээ хийх арга зүйн сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 19 захирал, цэцэрлэгийн 35 эрхлэгчид зохион байгуулсан. | | | | | | | | |
| 36 | | Багшийн дотоод /харилцаа | 3,000.00 | Дүүргийн төсөв | Багш ажилтны ёс зүйг | Тоо | 100 | Жил бүр 100 багшийг ур | НХХ, БХ | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хандлага, ёс зүй, багаар ажиллах, цаг төлөвлөлт/ ур чадварыг хөгжүүлэх модуль сургалтыг зохион байгуулна. | | | төлөвшүүлэх сургалтад хамрагдсан багшийн тоо | | | чадварыг хөгжүүлсэн байна. | | |
| | | - Боловсролын байгууллагын удирдах ажилтны харилцаа хандлага, ёс зүй, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Хувь хүний хөгжлийн институттэй хамтран зохион байгуулсан. Сургалтад төрийн өмчийн 19 сургуулийн захирал, 35 цэцэрлэгийн эрхлэгч хамрагдаж, харилцааны сэтгэл зүй, сэтгэл хөдлөлөө удирдах ур чадвар, багийн хөгжил, бүтээмж нэмэгдүүлэх, цагийн менежментийн хөтөлбөрт хамрагдсан.<br>-“Багшийн хөгжил, ур чадвар боловсролын реформын үндэс” зорилгын дор ерөнхий боловсролын бага, дунд, ахлах ангийн математик, байгалийн ухааны багш нарт зориулж, нийт 19 цагийн цогц агуулга бүхий мэргэжлийн болон цахим туршлага нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. Дүүргийн 2232 багшаас 1600 гаруй багш сургалтад сайн дураар бүртгүүлж, 1200 орчим багш 1 дүгээр сарын 18-наас 5 хоногийн турш цахим сургалтад хамрагдсан.<br>-“Хүүхдийн хөгжил ба багш, эцэг, эх, гэр бүлийн хамтын ажиллагаа” сэдэвт онлайн сургалтанд 33 арга зүйч, 68 багшийг хамруулан бага насны хүүхдийн хөгжлийг бүтээлч үйлээр дамжуулан хөгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлсэн. | | | | | | | | |
| 37 | | Удирдах ажилтан, багш, ажилтан ажиллагсдыг ажлын үр дүнгээр дүгнэж, урамшуулах ажлыг тогтмол зохион байгуулна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | Шилдэг багш, ажилтны тоо | Тоо | 100 | Жил бүр 100 багшийг ур чадварыг хөгжүүлсэн байна. | НХХ, БХ, ЕБС, Цэцэрлэг | 100% |
| | | -Боловсролын байгууллага, багшийн ажлын үр дүнг дүгнэж, урамшуулан дэмжих үйл ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан. Энэхүү үйл ажиллагаа нь Орчин цагийн боловсролын салбар үүсэж, хөгжсөний 100 жилийн ой, дэлхийн багш нарын 27 дахь өдөр, монголын багш нарын 55 дахь өдрийн хүрээнд элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр сурагчийн сурлагын амжилтад ахиц гаргаж, сурагчдадаа 800 оноо авах боломжийг бүрдүүлсэн 15 багш, цахим сургалтын үед манлайлан ажилласан цэцэрлэг, сургуулийн 20 багш, коронавируст халдварын үед орон нутагт дэмжлэг үзүүлж, идэвх санаачлагатай сайн ажилласан 5 цэцэрлэг, 6 сургууль зэрэг 47 хүнийг урамшуулан дэмжих үйл ажиллагааг дүүргийн Засаг даргын 2021 оны 09 сарын 29-ний өдрийн А/324 дүгээр захирамжийн хүрээнд зохион байгуулсан. | | | | | | | | |
| 38 | | Мэргэжлийн багшийн заах арга зүй, ур | 5,000.00 | Дүүргийн төсөв | Заах арга зүй, ур чадвараар | Тоо | 20 | Жил бүр 20 багшийн ур чадварыг | НХХ, БХ, ЕБС, | 100% |

<table>
<tr><td></td><td></td><td>чадварын уралдааныг жил бүр зохион байгуулан үр дүнг тооцож, дэмжин ажиллана.</td><td></td><td></td><td>шалгарсан багшийн тоо</td><td></td><td></td><td>хөгжүүлэн урамшуулсан байна.</td><td>Цэцэр лэг</td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="9">-Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын дунд “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, асуудал, шийдэл” сэдэвт илтгэлийн уралдааныг 4 үе шаттай зохион байгуулж, 230 багш оролцов. Дүүргийн түвшинд 69, 135, 205-р цэцэрлэгийн багш нарын баг шалгарсан. Энэхүү уралдааныг сургууль, цэцэрлэгийн нийт багш, удирдах ажилтнуудын дунд 3 үе шаттайгаар, цахимаар амжилттай зохион байгуулж, 2021 оны 3-р сарын 6-ны өдөр 3-р шатанд шалгарсан шилдэг 18 илтгэлээс Боловсролын хүрээлэнгээс гаргасан удирдамжийн дагуу улсын хэмжээнд өрсөлдөх 1 илтгэл шалгаруулсан.<br>-БСШУС-ын Сайдын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/194 дугаар тушаалын дагуу хичээл, сургалтын үйл ажиллагаанд холбогдох зохицуулалт хийж, энэ хугацаанд аливаа уралдаан, тэмцээн зохион байгуулахыг цуцалсан.<br>-Боловсролын хүрээлэнгээс 54 дэх удаагийн эрдэм шинжилгээний хурлыг 2021-2022 оны хичээлийн жилд “Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвтэйгээр зарласан. Дүүргийн хэмжээнд зохион байгуулсан эрдэм шинжилгээний илтгэл шалгаруулах байгууллагын түвшний шалгаруулалтанд 35 цэцэрлэгийн 210 багш оролцож, 2-р шатны буюу хэсгийн шалгаруулалтад 35 багш оролцохоор бэлтгэл хангаж байна.</td></tr>
<tr><td rowspan="2">39</td><td rowspan="2">2.4.4 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлж, сурлагын чанарт хяналт тавина.</td><td>Цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн явцын болон үр дүнгийн үнэлгээг жил бүр тогтмол хийж, хөгжлийн ахицыг тооцон багшийг дэмжиж ажиллана.</td><td></td><td></td><td>Үнэлгээний дундаж хувь</td><td>Хувь</td><td></td><td>Багшийн чадвар нэмэгдэж, хүүхдийн хөгжлийн үнэлгээ дээшилсэн байна.</td><td>НХХ, БХ, ЕБС, Цэцэр лэг</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">БШУС-ын 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/280 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам”-аар хүүхдийн хөгжлийн үнэлгээг явцын болон үр дүнгийн үнэлгээгээр дүгнэхэд дүүргийн хэмжээнд хөгжлийн ахиц 23%-иар өссөн байна.<br>-2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилийн хүүхдийн хөгжлийн үнэлгээг бүлгийн харьцуулалтаар харьцуулахад бага бүлэг хангалттай 15%-иар, дундаж 1%-иар, дунджаас доогуур 22%-иар, дунд бүлэг хангалттай 12%-иар, дундаж 6%-иар, дунджаас доогуур 6%-иар, ахлах бүлэг хангалттай 12%-иар, дундаж 6%-иар, дунджаас доогуур 6%-иар, бэлтгэл бүлэг хангалттай 30%-иар, дундаж 17%-иар, дунджаас доогуур 13%-иар, холимог бүлэг хангалттай 51%-иар, дундаж 30%-иар, дунджаас доогуур 21%-иар тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 40 | | Боловсролын чанарын үнэлгээнд дүн шинжилгээ хийж, сурлагын амжилтыг ахиулна. | | | Чанарын үнэлгээний дундаж | Хувь | | Сурлагын амжилт нэмэгдсэн байна. | НХХ, БХ, ЕБС, Цэцэр лэг | 100% |
| | | -БШУЯ, Дэлхийн банк, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулсан “Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх” судалгааны ажил 2021 оны 09 сарын 20-оос 10 сарын 20-ны хооронд зохион байгуулагдаж, судалгаанд түүврийн аргаар сонгогдсон 13 сургуулийн 1-р ангийн 29 бүлгийн 1677 суралцагч хамрагдсан.<br>-Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээлийн агуулгын хоцрогдол, нөхцөл байдлыг тодорхойлох, дэмжлэг үзүүлэх, зайн сургалтын үе дэх сургалтын бэрхшээлийг илрүүлэх зорилгоор Оношлох үнэлгээнд түүврийн аргаар сонгогдсон 34 сургуулийн 2-12 дугаар ангийн 78052 сурагч хамрагдсан.<br>-2021 оны 10 дугаар сарын 14-28-ны өдрүүдэд Сургуульд суурилсан үнэлгээнд 2-12-р ангийн 39289 сурагчийн 80% хамрагдсан. | | | | | | | | |
| 41 | | Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг тооцож, урамшуулах ажлыг зохион байгуулна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | Амжилттай суралцсан сурагчдын тоо | Тоо | | Дүүргийн дундаж онооны үзүүлэлтийг нэмэгдүүлсэн байна. | НХХ, БХ, ЕБС, Цэцэр лэг | 100% |
| | | -Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл хангах зорилгоор цахим сургалтын гараены үнэлгээ боловсруулахаар Математик, Нийгмийн ухаан, Англи хэлний хичээлээр цахим сорил зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн 36 сургуулийн 2763 суралцагчаас давхардсан тоогоор 3410 удаагийн хандалтаар цахим сорилд хамрагдан, сорилын үр дүнд анализ хийж, сургалтын агуулгыг боловсруулан ажилласан.<br>-Шинэ Монгол технологийн дээд сургуультай хамтран 12-р ангийн сурагчдаас Математик, Хими, Физикийн хичээлээр цахим сорил авах ажил зохион байгуулсан.<br>-Давтлага хичээлийн 1 сарын хугацаатай зохион байгуулан Амжилтын гараа сорилыг 2021 оны 05 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулж, 38 сургуулийн 2624 сурагч хамрагдсан.<br>-Элсэлтийн ерөнхий шалгалтад 10 судлагдахуунаар 39 сургуулийн 2625 суралцагч хамрагдан батламжаа гардан авч, 36 сурагч 800 оноо авсан үр дүн гарсан.<br>-2021 оны элслэлтийн ерөнхий шалгалтын онооны дундаж 540,1 хүрч өнгөрсөн оноос 7,5 оноогоор өссөн. | | | | | | | | |
| 42 | 2.4.5 “Насан туршийн боловсролын төв”-өөр олгох сургалтын чанар, хүртээмжийг сайжруулж, | Бичиг үсгийн боловсролгүй, сургууль завсардсан хүүхэд, залуучуудын | | | Сургалтад хамрагдсан иргэний тоо | Тоо | 100 | Мэдээллийн сан бүрдүүлж, бичиг үсгийн чадамж дээшилсэн байна. | НХХ, АБНТБ Х, БХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургуульд суралцаагүй, сургууль завсардсан, зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд, иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг эзэмшүүлэх, иргэдийн нийгмийн боловсролыг дээшлүүлэх цахим платформд суурилсан сургалтын үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | мэдээллийн сан бүрдүүлж, бичиг үсгийн болон дүйцсэн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна. | | | | | | | | |
| | | -БСШУСС-ын А/168 тушаал, БСШУСС-ын А/756 тушаалын хэрэгжилтийг ханган Насан туршийн боловсролын төв нь 20 хорооны хүн амын дунд тасралтгүй боловсролын үйлчилгээ үзүүлж, 6 анги салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.<br>-2020-2021 оны хичээлийн жилд Насан туршийн боловсролын төвд дүйцсэн хөтөлбөрийн Бага боловсролд 24, Суурь боловсролд 114, Бүрэн дунд боловсролд 87 нийт 225 суралцагч хамрагдан суралцсан. Үүнээс: Хөгжлийн бэрхшээлтэй 2 суралцагч, Хийдэд шавилан суугаа лам 57 суралцагч суралцсан байна.<br>-2020-2021 оны хичээлийн жилд 81 суралцагч суурь боловсрол, 56 суралцагч бүрэн дунд боловсрол эзэмшсэн.<br>-Төгсөгчдөөс 2 суралцагч МСҮТ-д, 5 суралцагч коллежид, 7 суралцагч их дээд сургуульд элсэн суралцсан байна. "Бичиг үсгийн боловсрол"-ын сургалтанд 1, 9-р хорооны 2 суралцагч дунд, ахисан түвшинд хамрагдсан.<br>-Суралцагчид нь суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэнээр дараагийн шатны сургалтад хамрагдах боломж нээгдэж байна<br>-2021-2022 оны хичээлийн жилд тус насан туршийн боловсролын төвд сургууль завсардсан болон суурь, бүрэн дунд боловсрол эзэмших хүсэлтэй 29 суралцагч шинээр элсэн суралцсан. Үүнээс бага боловсролд 2, суурь боловсролд 13, бүрэн дунд боловсролд 14 суралцагч хамрагдсан.<br>-2021-2022 оны хичээлийн жилд тус Насан туршийн боловсролын төвийн суралцагчдын тоо 136 суралцагч байна. Үүнээс лам суралцагчид 61, насанд хүрэгчид 44 суралцагч танхимаар болон зайнаас хичээллэж байна. | | | | | | | | |
| 43 | | Иргэдэд Амьдрах ухааны боловсрол, Иргэний боловсрол, Гэр бүлийн боловсрол, Гоо зүй мэдрэмжийн боловсрол, Ёс суртахуун төлөвшлийн боловсрол, Шинжлэх ухааны боловсрол хөтөлбөрийг баяжуулан боловсруулах, | | | Сургалтад хамрагдсан иргэний тоо | Тоо | 100 | Хөтөлбөр боловсруулсан байна. | НХХ, АБНТБХ, БХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цахим хэлбэрээр сургалт зохион байгуулна. | | | | | | | | |
| | | -БСШУСС-ын А/756 тушаалын хэрэгжилтийг ханган иргэдийн хэрэгцээнд тулгуурлан бүтээсэн, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэн бүр насан туршдаа тасралтгүй хөгжихөд зориулсан теле хичээл болон цахим контентуудыг STAR телевиз, Насан туршийн боловсролын үндэсний төвийн пэйж хуудас, дүүргийн Насан туршийн боловсролын төвийн пэйж хуудсаар дамжуулан түгээн дэлгэрүүлэн ажиллаж байна.<br>-Санхүүгийн боловсролын сургалтыг танхимаар 2 удаа 31 иргэнд, цахимаар 2 удаа 24 иргэнд, “Хуримтлал үүсгэх” онлайн сургалтыг Хонгорхон бренд”-тэй хамтран зохион байгуулж, дүүргийн бизнес эрхлэгч 12 иргэнд бизнес туршлагаа хуваалцсан.<br>-Иргэний боловсролын агуулгаар “Хувь хүний хөгжил”-ийн сургалтыг 6 удаа 62 иргэнд, Мэдээлэл технологийн анхан шатны сургалтыг 5 удаа зохион байгуулж танхимаар 38 хүнд, цахимаар 150 дугаар цэцэрлэгийн ажилтан, албан хаагч 15 иргэнд тус тус зохион байгуулсан.<br>-Англи хэлний анхан шатны сургалтыг цахимаар 1 удаа 150 дугаар цэцэрлэгийн ажилтан, албан хаагч 15 иргэнд, 10 хорооны 10 иргэнд хорооны иргэдийн хурлын танхимд зохион байгуулсан.<br>- “Монгол бичиг – III” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол бичгийн сургалтыг 150, 109 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид нийт 32 иргэнд, 12 дугаар ангийн 10 суралцагчдад, төвийн багш, ажилтан албан хаагч 16 иргэнд, дүүргийн онцгой байдлын 34 дүгээр ангийн алба хаагчдад тус тус зохион байгуулсан.<br>-2021 онд 9 төрлийн 24 удаагийн давтамжит сургалт, үйл ажиллагаагаар иргэдэд хүргэж ажилласан байна. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 254 иргэнд танхимаар, 11610 иргэнд онлайн буюу зайнаас, онлайн видео хичээлээр 2426 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. | | | | | | | | |
| 44 | | Иргэдийн нийгмийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн гарын авлага, зөвлөмж бэлтгэх, дүүргийн хүн амд хүртээмжтэйгээр хүргэнэ. | 13,125.00 | Дүүргийн төсөв | Гарын авлага хүлээн авсан иргэдийн тоо | Тоо | 100 | Иргэдэд гарын авлага, зөвлөмж хүргэсэн байна. | НХХ, АБНТБХ, БХ | 100% |
| | | - Иргэдийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг бүрэн шинэчилж, Амьдрах ухааны боловсрол 4 агуулгын хүрээнд 13 цагийн хөтөлбөр,Санхүүгийн боловсрол 5 агуулгын хүрээнд 13 цагийн хөтөлбөр, Иргэний боловсрол 3 агуулгын хүрээнд 18 цагийн хөтөлбөр, Гэр бүлийн боловсрол 4 агуулгын хүрээнд 18 цагийн хөтөлбөр, Ёс суртахуун төлөвшлийн боловсрол 2 агуулгын хүрээнд 8 цагийн хөтөлбөр, Соёл гоо зүйн боловсрол 2 агуулгын хүрээнд 10 цагийн хөтөлбөр зэрэг нийт 80 цагийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг бэлтгэж, иргэдийн сургалтын нэгдсэн арга зүйн сантай болсон<br>-Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 254 иргэнд танхимаар, 11610 иргэнд онлайн буюу зайнаас, онлайн видео хичээлээр 2426 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. | | | | | | | | |

<table>
<tr><td rowspan="2">45</td><td rowspan="4"></td><td>Насан туршийн боловсролын төвийн суралцагчдыг "Үдийн хоол хөтөлбөрт" хамруулна.</td><td>4,455.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Хамрагдсан хүүхдийн тоо</td><td>Тоо</td><td></td><td>Суралцагчид "Үдийн цай" хөтөлбөрт хамрагдсан байна.</td><td>НХХ, АБНТБХ, БХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">-2019 оноос "Holt International" төрийн бус байгууллага, 71 дүгээр сургуулийн цайны газартай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж, бага, суурь боловсролын 28 суралцагчдыг "Үдийн хоол хөтөлбөр"-т хамруулан суралцагчдын сурах идэвхийг дэмжин ажиллаж байна.<br>-Суралцагчид үдийн хоол хөтөлбөрт хамрагдсанаар хичээл таслалтгүй, сурах идэвхи оролцоо сайжирсан.</td></tr>
<tr><td rowspan="2">46</td><td>Насан туршийн боловсролын төвийн байранд бүрэн засвар хийж, хүүхэд хөгжлийн, үсчин гоо сайхны, дүйцсэн хөтөлбөрийн, иргэдийн, нийгмийн чиглэлийн танхим, кабинетыг байгуулна.</td><td>3,500.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Завсар, хөрөнгө оруулалтын хэмжээ</td><td>Тоо</td><td></td><td>Үсчин, гоо сайхны тоног төхөөрөмж шинэчилсэн байна.</td><td>НХХ, АБНТБХ, БХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">-БШУ-ы сайдын 2020 оны 12 сарын 23-ний өдрийн "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зарим арга хэмжээний тухай" А/200 дугаар тушаалын дагуу Азийн хөгжлийн банкны 18.882.871 төгрөгний санхүүжилтээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхимыг шинээр тохижуулсан. Мөн тус төвийн анги танхимыг дүйцсэн хөтөлбөрийн болон иргэдийн сургалтын чиглэлээр өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан засварлан тохижуулж байна.</td></tr>
<tr><td colspan="11">2.5 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, хүүхэд, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.</td></tr>
<tr><td>47</td><td>2.5.1 Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн засвар,</td><td>Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлаар мэдээллийн сан</td><td>40,000.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэгдсэн мэдээллийн сан үүссэн байна.</td><td>Чан ар</td><td>Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын атрибут мэдээлэл</td><td>Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэгдсэн мэдээллийн сан үүссэн байна.</td><td>ТНААХ, ТГХШХ, НХХ</td><td>100%</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тохижилт, хөрөнгө оруулалтын ажлыг эрэмбэлэх цахим мэдээллийн сан бүрдүүлж, сургалтын орчинг сайжруулна. | үүсгэж баяжуулна. | | | | | мэдээллийн санд бүртгэгдээгүй байна. | | | |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1-20 дугаар хорооны 173 байршлын тохижилтын талбайн эд хөрөнгийг бүртгэлжүүлээд байна. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын төлөвлөлт, худалдан авах ажиллагааны мэдээлэл, гүйцэтгэлийн хяналт, санхүүжилтийн мэдээллийг харуулсан мэдээллийн сан үүсгэж баяжуулан ажиллаж байна. | | | | | | | | |
| 48 | 2.5.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ, автобусны үйлчилгээ, туршлагыг нэвтрүүлэн “ГЭРТЭЭ ХАРИХ ГЭРЭЛТЭЙ ЗАМ” арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн аюулгүй орчин бүрдүүлнэ. | "Гэртээ харих гэрэлтэй зам" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 10,000.00 | Дүүргийн төсөв | Хөтөлбөр батлуулж, зохион байгуулсан ажил, хамрагдсан хүний тоо | Тоо | | Хөтөлбөр боловсруулсан байна. | НХХ, ГБХЗХХ | 100% |
| | | -Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ, автобусны үйлчилгээ, туршлагыг нэвтрүүлэн хүүхдийн аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор Гэртээ харих гэрэлтэй зам хөтөлбөрийг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр боловсруулан ажиллаж байна. Эцэг, эх олон нийтийн оролцоотойгоор сургууль, цэцэрлэгийн эргүүл зохион байгуулан дэмжлэг үзүүлж ажиллах, сургуульд сэтгэл зүйч ажиллуулах, сургуулийн автобусны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, хүүхдийг зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.<br>-Танхимын сургалт эхлэх үеийн бэлэн байдал хангахтай холбоотойгоор дүүргийн төрийн өмчийн 8 сургуулийн 12 автобус үзлэгт хамрагдан тэнцэж, төрийн бус өмчийн 7 сургуулийн 33 автобуснууд хуваарийн дагуу үзлэг оношилгоонд хамрагдсан.<br>- Хүүхдийг зам тээврийн ослд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Шар дарцаг аяныг 2021 оны 11 сарын 09-ний өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, аяны хүрээд Замын хөдөлгөөнд оролцох 10 алтан дүрмийн хэвшүүлэхээр 30 секундын штрок хийж, нийтэд түгээсэн.<br>-Коронавируст халдвар/Ковид-19/-ын үед цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийн үнэлгээ хийхээр 3 баг ажилласан. Төрийн өмчийн 24 сургууль, 35 цэцэрлэг, Насан туршийн боловсрол 1, төрийн бус өмчийн 22 сургууль, 28 цэцэрлэгт нийт 20 үзүүлэлтээр үнэлгээ хийхэд бага эрсдэлтэй-47 сургууль, дунд эрсдэлтэй-0, их эрсдэлтэй-0, бага эрсдэлтэй 57 цэцэрлэг, дунд эрсдэлтэй-7 цэцэрлэг байна. | | | | | | | | |
| 49 | 2.5.4 Хүүхэд, залуучуудын номын сангийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулна. | 3, 5,12,16 дугаар хороодын номын булангийн үйл ажиллагааг сайжруулан баяжилт хийнэ. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Ажлын явц | 2019 онд дүүргийн Засаг даргын захирамжаар 3.5.12.16 дугаар хороодод номын булан шинээр байгуулсан. | Номын сангийн хүртээмж нэмэгдсэн байна. | НХХ, Хороод | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Журам батлах тухай 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Түр журам батлах тухай 18,20,21 дүгээр тушаал, шийдвэрийн дагуу коронавирусийн халдвар дархалтаас сэргийлэх зорилгоор номын сангийн үйл ажиллагаа хаагдсан байсан бөгөөд 08 дугаар сарын 23-ны өдрөөс халдвар хамгаалллын дэглэм баримтлан ажиллахаар болсон.<br>Нийслэлийн Соёл урлагийн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Үндэсний номын сан, Хүүхдийн төв номын сан, Нацагдоржийн нэрэмжит номын сантай хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.<br>- Сүхбаатарын талбайд 2021 оны 08 дугаар сарын 28,29-ний өдөр зохион байгуулагдсан хичээлийн шинэ жилд зориулсан үзэсгэлэн худалдаа болон 30-ны өдөр зохион байгуулагдсан дүүргийн Өглөөний гудамжны нээлтийн арга хэмжээнд “Оюуны хөгжил IQ” төвтэй хамтран номын үзэсгэлэн худалдаа гарган ажилласан.<br>-Нийслэлийн Нийгмийн халамжийн газраас гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэд түр байрлах байгууллагад ном хандивлах аян өрнүүлсэнтэй холбогдуулан 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 20 ширхэг номыг хандивлан хүргүүлсэн. | | | | | | | | |
| 50 | 2.5.7 Багшийн ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэх, сурлагын амжилт, чанарыг ахиулах зорилгоор хүүхэд, эцэг эх, багшийн цахим хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлнэ. | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт цахим хамтын ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчилж, интернэтийн хурд нэмэгдүүлнэ. | | | Интернэтийн хурд нэмэгдүүлсэн сургуулийн тоо | Тоо | | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хамтын ажиллагааг дэмжсэн байна. | НХХ, ТГХШХ, БХ | 100% |
| | | -Дүүргийн сургуулиудад цахим технологийг бүрэн нэвтрүүлэх, Google Education Suite цахим талбар, Microsoft One Drive гэх зэрэг цахим талбарыг илүү өргөн боломжоор ашиглахад дэмжлэг үзүүлэн ажиллаж нийт 23 сургууль (төрийн өмч 15, хувийн 8) сургууль хамрагдаж, 1228 багш, 23,101 сурагчид цахим сургалтын орчинд сургалт явагдах орчин бүрдсэн байна.<br>-Теле болон цахим хичээлийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус өмчийн 30 сургуулийн 1521 сурагчид Мобикомын үнэгүй дата олгож, 1, 11-р сургуулиуд интернэтийн хурдаа нэмэгдүүлсэн.<br>-Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 299 дүгээр цэцэрлэгт 260 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг зохион байгуулсан. | | | | | | | | |
| 51 | | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийг | | | Хандалтын тоо | Тоо | 5000 | Цахимаар үйлчилгээний чанарыг сайжруулсан байна. | НХХ, БХ | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цахимаар зохион байгуулна. | | | | | | | |
| | | -Төрийн өмчийн ерөнхий боловсролын 12 сургууль, 34 цэцэрлэгийн хамран сургах тойрог тогтоохоор 1-20 хорооны ажлын алба, сургууль, цэцэрлэгийн удирдлага, иргэдийн саналыг тусган дүүргийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 2/491 дугаартай албан бичгээр нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн Боловсрол Шинжлэх Ухааны Сайд, Эрүүл Мэндийн Сайдын хамтарсан А/292, А/525 дугаар тушаалаар баталсан “Коронавируст халдвар, / Ковид-19 /-ын үед цэцэрлэгийн сургалт , үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын 2.8 дахь заалтын дагуу уламжлалт аргаар 1 бүлэгт 20 -+ байхаар тооцон 2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийг зохион байгуулж, нийт 64 цэцэрлэгт 4 настай 2729, 5 настай 3104 хүүхдийг хамруулаад байна. Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтсийн даргын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/09 дүгээр тушаалаар дүүргийн 1 дүгээр ангийн цахим элсэлт, цэцэрлэгийн элсэлт зохион байгуулах Ажлын хэсэг байгуулагдсан. 2021 оны 08 дугаар 30-ны өдрийн байдлаар дүүргийн хамран сургах тойргийн 12 сургуульд элсэн суралцах 3481 элсэгчдээс 3058 элсэгчийн элсэлт баталгаажиж, 87.8 хувь нь хамран сургах тойргийн сургуульд суралцсан. | | | | | | | |
| 52 | 2.5.8 Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд "Загвар” төслийг хэрэгжүүлнэ. | 80000.0 | Дүүргийн төсөв | Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ сайжирч, стандарт хангана. | Тоо | Ерөнхий боловсролын 3 сургуулийн ажилчид мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, 2 цайны газар засвар үйлчилгээ хийгдэж стандарт хангасан. | Ерөнхий боловсролын 1-2 сургуулийн гал тогоог жишиг стандартын хэмжээнд хүргэсэн байна. | ХХҮХ | 70% |
| | | Ковид-19 цар тахалтай холбоотойгоор “Үдийн хоол” хөтөлбөрийг 2021-2022 оны хичээлийн жилд нийслэлийн ерөнхий боловсролын 20 сургуульд, цаашид бусад сургуулиудад шат дараатайгаар хэрэгжих болсон тул уг арга хэмжээ 2022 он хүртэл хойшилсон. 2022 онд дүүргийн хэмжээнд 1, 3, 35, 45, 58, 71 дүгээр сургуулиудыг бүрэн шилжүүлэхээр төлөвлөж нийслэлийн Боловсролын газартай хамтран шаардлагатай төсвийг төлөвлөн гаргаж, 2022 оны төсөвт оруулахаар Боловсрол Шинжлэх Ухааны яамруу санал хүргүүлсэн. | | | | | | | |
| 53 | 2.5.9 Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах талаарх мэдлэгийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад хог хаягдлын хор уршиг, түүнийг | 20,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | 200 иргэн, 50 ААН-д зохион байгуулсан. | Төрийн өмчийн 32 цэцэрлэг, 19 Ерөнхий боловсролын сургуульд сургалт зохион байгуулсан байна. | ТНААХ ТГХШХ СТСХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчлан таниулах ажлыг эхлүүлж, хэрэгжүүлнэ. | хэрхэн бууруулах, дахин ашиглах, хогийг ангилан ялгах дадал зуршлыг бий болгох талаар сургалт, сурталчилгаа хийж, таниулах ажлыг зохион байгуулна. | | | | | | | | |
| | | 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-тай хамтран дүүргийн 9 дүгээр хорооны 4 дүгээр сургуулийн бага ангийн сурагчдад Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, хүүхдийг багаас нь хог хаягдлыг ангилан ялгахад хэвшүүлэх сургалтыг зохион байгуулж ажилласан. Мөн Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээр сургалтыг зуслангын бүс болох 19, 20 дугаар хороонд 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж ажилласан болно. | | | | | | | | |
| 2.6 Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, тусламж үйлчилгээг сайжруулна. | | | | | | | | | | |
| 54 | 2.6.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулан иргэдэд түргэн шуурхай хүргэнэ. | Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулан иргэдэд түргэн шуурхай, ил тод үйлчилгээг хүргэнэ. | | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | "Ehalamj.mn" халамжийн нэгдсэн системийн үйл ажиллагааг жигдрүүлж, халамжийн үйлчилгээг цахимаар иргэдэд үзүүлсэн байна. | НХХ, ХөХҮХ | 100% |
| | | Нийгмийн халамжийн 76 үйлчилгээнээс 2021 онд 28 үйлчилгээ “Ehalamj.mn” системрүү цахим хэлбэрт шилжиж, хүсэлт гаргасан 23977 иргэний банкны дансыг холбож, 100 хувь үйлчилгээг цахимжуулсан. /Ehalamj.mn/ системрүү шилжсэн нийгмийн халамжийн тэтгэврийн үйлчилгээг 1846 иргэн, нийгмийн халамжийн тэтгэмжийн үйлчилгээг 61702 иргэн, насны хишиг 8230 ахмад, алдар цолтон ахмад настанд төрөөс олгох тусламж, хөнгөлөлт 342 ахмад, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж 6897 иргэнд нийт 79017 иргэнд 26,377,016,746 төгрөгний үйлчилгээ олгосон. | | | | | | | | |
| 55 | 2.6.2 Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй зорилтот бүлгийн иргэдэд | Зорилтот бүлгийн иргэдэд амьжиргааны бодит туслалцаа үзүүлнэ. | 40,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | 2020 онд дүүргийн Засаг даргын захирамжаар нийт 7 өрхөд гэр, 10 иргэнд мөнгөн тусламж олгосон. | Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргаа дээшилсэн байна. | НХХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | амьжиргааны бодит туслалцаа үзүүлнэ. | Дүүргийн Засаг даргын 2021 оны А/92, А/253, А/254, А/255, А/393, А/394, А/396 дугаар тушаалаар амьдралын гачигдалтай, хүнд өвчний улмаас эмчилгээний зардал хүссэн 9 иргэнд 28,300,000 төгрөгий буцалтгүй тусламж олгосон. | | | | | | | | |
| 56 | 2.6.3 Хүмүүнлэгийн чиглэлээр Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлнэ. | Хүмүүнлэгийн үйл ажиллагаа зохион байгуулна. | 80,000.00 | Дүүргийн төсөв | Зохион байгуулсан үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Зорилтот бүлгийн хүмүүст нийгэм-сэтгэл зүйн болон нийгмийн халамжийн үйлчилгээг олон нийтийн оролцоонд тулгуурлан хүргэсэн байна. | НХХ, УЗХ, ХЗДАА | 100% |
| | | -Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/06, А/25 дугаартай захирамжаар гэр нь шатсан иргэн /Д.Бадарч, Ж.Батдулам/-д тус бүрт 4,300,000, нийт 8,600,000 төгрөгийн 5 ханатай гэр, хүнсний багц олгосон.<br>-Дүүргийн Улаан загалмайн хороотой хамтран дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/05, А/84 дүгээр тушаалаар Төв аймгийн 016 дугаар цэргийн анги, Зүүн Түгээх Цахилгаан Түгээх Станцын ажилтануудын дунд Цусны донорын өдөрлөг зохион байгуулж, 192 хүн цусаа хандивлалаа.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн А/07 дугаар тушаалаар хэсэгчилэн хөл хорио тогтоосон үед шаардлагатай тохиолдолд 100 өрхөд нийт 5,000,000 төгрөгийн хүнсний багц, тусламж олгов.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн А/80 тоот тушаалаар тус дүүргийн 17-р хорооны иргэн Н.Алтангэрэлд 5.000.000 төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж олгов.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/85, А/118, А/120 дугаар тушаалаар дүүргийн 10, 18 дугаар хорооны ам бүл ганцаараа амьдардаг, эмзэг бүлгийн 6 иргэнд 5 ханатай иж бүрэн гэр, хүнсний багц тусламж олголоо. | | | | | | | | |
| 57 | 2.6.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүний салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллана | Хөгжлийн бэрхшээлтэй хүний салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | 10,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | 2019 онд дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжиж ажилласан байна. | НХХ | 100% |
| | | Коронавируст халдвар /Covid-19/-ын тархалт нэмэгдсэний улмаас зөвлөлийн хурлыг 2 удаа цахимаар зохион байгуулж, цар тахлын үед хийгдэх ажлаа төлөвлөн, хагас жилийн ажлын тайланг дүгнэсэн. Үүнд:<br>1. Коронавируст халдвар /Covid-19/-аас урьдчилан сэргийлэх, хамгаалах, эмнэлзүйн зөвлөмжийг бүх хэлбэрээр хүргэх,<br>2. Шаардлагатай хүмүүст хүнсний болон эрүүл ахуйн багцын тусламжийг үзүүлэх,<br>Дүүргийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/207 дугаар Захирамжаар Налуу замтай - Иргэдэд ээлтэй жишиг гудамж байгуулах ажлын хэсэг гарч, 11 авто замын уулзвар явган замтай огтлолцож, үүнээс 2 нь л явган хүний гарцтай байгаад дүн шинжилгээ хийж ажиллалаа.<br>Уг ажиллагаанд 12-р хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэн Г.Оюунчимэгийн хамт 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр явган замаар зорчиход бордюр стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд нөхцөл байдлын үнэлгээ хийлээ. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хүртэл эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох төслийн мэдээллийг иргэдэд байгууллагын болон хороодын Засаг даргын ажлын албаны пэйж хуудас, 20 хорооны мэдээллийн самбарт байршуулан, утсаар 27 иргэнд зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан.<br>Энэ онд хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэн коронавируст халдвар /Ковид-19/-аар өвдөж бүрэн эдгэрсэн бөгөөд тэдэнд нэг бүр нь 58000 төгрөгийн хүнсний болон ахуйн хэрэглээний багцыг өгсөн.<br>Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тэргэнцэр, ХБ хүүхэдтэй ажиллах ном, гарын авлага, дохионы хэлний цагаан толгойг хэвлэн байршуулсан.<br>Хүнсний тусламж нэн шаардлагатай зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй 28 иргэн, 200 хүүхдэд бэлэг, хүнсний багцын тусламж дэмжлэг үзүүллээ. | | | | | | | | |
| 2.7 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дэмжин ажиллана. | | | | | | | | | | |
| 58 | 2.7.1 Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулна. | Чуулга уулзалтыг зохион байгуулж, татвар төлөгч байгууллагыг урамшуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Чуулганд оролцогчдын тоо | Тоо | | Ажил олгогчийг дэмжсэн байна. | НХХ, ХөХҮХ, ААНБ | 100% |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Ажил олгогчдын уулзалтыг 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр зохион байгууллаа. Энэ үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 21 иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогч нарыг урамшуулав. | | | | | | | | |
| 59 | 2.7.2 Ажилгүй, орлогогүй иргэдийг мэргэжлийн болон давтан сургалтаар мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэн чадавхжуулж, хөдөлмөр эрхлэхэд нь зуулчилж ажиллана. | Мэргэжил олгох, давтан сургалтад зорилтот бүлгийн иргэдийг хамруулна. | | | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | Тоо | Ажил, мэргэжлийн чиг баримжааны ганцаарчилсан зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээг 543 иргэнд үзүүлсэн. | Зорилтот бүлгийн иргэдээс тухайн жилд батлагдан ирсэн квотоос хамааран сургасан байна. | НХХ, ХөХҮХ ХЗДАА | 100% |
| | | -“Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ”-ний хүрээнд “Алтан алхам” ТББ-ын сургалтын төвтэй хамтарч “Хүнсний эрхийн бичиг”-т хамрагддаг хөдөлмөрийн насны 51, хөгжлийн бэрхшээлтэй 13 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, сэтгэл зүйн сургалтад хамруулсан. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтий газрын сонгон шалгаруулалтад тэнцсэн 40 иргэн үйлдвэрлэл дээрх мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдаж, мэргэжилтэй боллоо.<br>-“Ажилсаг Монгол Залуус” хөтөлбөр нь залуучуудыг идэвхтэй амьдралын хэв маягт сургах, эх оронч үзлийг төлөвшүүлж, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар тэднийг хөдөлмөрт бэлтгэж, ажилтай, орлоготой болгоход чиглэгдсэн бөгөөд хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ХНХЯ, харьяа байгууллагууд ханган ажиллаж байна.<br>-“Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх”-ийн 18-34 насны хөдөлмөр эрхлэх боломжтой 84 иргэний судалгааг НХЭГ, ННХГ-т хүргүүлж, Төв аймгийн “Жаргалант” суманд 33 иргэн ургац хураах түр ажлын байранд зуучилсан. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Шинээр бий болсон 1050 ажлын байрыг бүртгэж, 115 иргэнийг ажилд зуучилж, сул чөлөөтэй ажлын байр 678, шинээр бүртгүүлсэн ажил хайгч 1410, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг 1410, ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө, мэдээллийг 2500 иргэнд өгч ажилласан. “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хөдөлмөрт бэлтгэх аж ахуй эрхлэлийн сургалтанд 13 иргэн хамрагдсан. | | | | | | | | |
| 60 | 2.7.3 Өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байр бий болгох, өрхийн үйлдвэрлэл, бизнесээ хөгжүүлэхэд нь дэмжин ажиллана. | "Зохион байгуулалттай ажлын байр" хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын гудамж тохижуулахад хамтран ажиллана. | 20,000.00 | Дүүргийн төсөв | Ажлын байрны тоо | Тоо | | Зохион байгуулалттай ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. | НХХ, ХөХҮХ ХЗДАА | 100% |
| | | -“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд “Зохион байгуулалттай ажлын байр арга хэмжээ нь 2021 онд Ковид-19 цар тахалтай холбогдуулан “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх” хөтөлбөр болж, нэр нь өөрчлөгдсөн. Хөтөлбөрийн хүрээнд нийтийг хамарсан ажилд зорилтот бүлгийн 166 иргэн оролцож, 14,420,000 төгрөгний ажлын хөлс олгосон.<br>-Ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах зорилгоор дүүргийн Засаг даргын 2021.11.18-ны өдрийн А/409 дүгээр захирамжаар 9,900,000 төгрөг шийдвэрлэж, 13 дугаар хороонд жишиг гудамж байгуулах ажлыг эхлүүлээд байна. | | | | | | | | |
| 61 | | Өрхийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, 20 өрхийн амьжиргааг дэмжинэ. | 50,000.00 | Дүүргийн төсөв | Хороо тус бүрээс 1 өрх сонгож хөтөлбөрт хамруулсан байна. | Тоо | | Зорилтот бүлгийн 5 өрхийн хөгжлийг дэмжсэн байна. | НХХ, ХөХҮХ ХЗДАА | 100% |
| | | -Нийслэлийн хэмжээнд 2021 онд өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны 409679-өөс доогуур оноотой 3000 өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилтын хүрээнд дүүргийн 20 хорооны ЗДАА-нд 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/218 тоот “Хамтран ажиллах тухай” албан бичгийн дагуу судалгаа авч нэгтгэв. 2021 онд “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т сонгогдсон 360 өрхтэй ажиллах ажлын нэгдсэн төлөвлөгөөнд 3 зорилт, 17 ажил төлөвлөн, хэрэгжүүллээ.<br>-“Ажилсаг монгол” хөтөлбөрт зорилтот бүлгийн “Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ”-нд хамрагдаж байгаа хөдөлмөрийн 18-34 насны 84 иргэний судалгааг ННХГ, НХЭГ-т хүргүүлж, Төв аймгийн “Жаргалант” суманд 33 иргэнийг үргац хураах түр ажлын байранд зуучилсан. Хөтөлбөрт сонгогдсон 9, 12 дугаар хорооны хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, өөрсдийн гэсэн гэр оронгүй 2 иргэний төслийг ОНОТХҮ-ий бүлгийн төслийн сонгон шалгаруулах ажлын хэсэг дэмжиж, тус бүрт 1,5 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br>“Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т хамрагдаж буй 360 өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгцээ, чадавх, боломжийг нь харгалзан суурь судалгаа гарган, хөтөлбөрт хамрагдсан хөдөлмөрийн насны 4 иргэнийг байнгын ажлын байранд, 17 иргэнийг түр ажлын байраар хангаж, нийт давхардсан тоогоор 105 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл өгч, ажилд зуучилж, түр болон байнгын ажлын | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байраар хангав. Өрхийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, 20 өрхийн амьжиргааг дэмжих ажлыг эрчимжүүлэх ажлыг дүүргийн НХХ-тэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул хөтөлбөрийн үр дүн буурсан үзүүлэлттэй байна. | | | | | | | | |
| 62 | 2.7.4 Бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын цагийн уян хатан зохицуулалт хийж, оюутан, залуучуудыг цагаар болон өдрөөр ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлсэн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжин ажиллана. | Ажлын байр бий болгосон байгууллагыг дэмжин урамшуулна. | | | Ажлын байрны тоо | Тоо | | Оюутан залуучуудын ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. | НХХ, ХөХҮХ | 100% |
| | | Оюутан, залуучуудыг “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-д холбон зуучилдаг. Ажил хайгч 7 оюутанд “Миний дэлгүүр”-ийн “Төгсөгчдийг бэлтгэх хөтөлбөр”-т цалинтай дадлагын ажилд холбон зуучилсан. Сүхбаатар дүүргийн харъяалалтай 50 оюутныг нийтийг хамарсан цагийн ажлын байранд зуучилж, ажлын хөлс олгосон.<br>-“Сити их сургууль”-ийн оюутан залуучуудад цагийн ажлын мэдээлэл өгөх, цагийн ажилд зуучлах арга хэмжээг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, өдөрлөгт тус сургуулийн нийт 200 гаруй оюутан залуус хамрагдаж, үүнээс тус дүүрэгт харьяалалтай 30 оюутаныг 7 дугаар хорооноос зохион байгуулсан нийтийг хамарсан Сэлбэ голын ай сав, тарьсан модыг услах, арчлах хамгаалах түр ажлын байранд зуучилж, 840,000 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон. Нийт 87 оюутныг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байна.<br>-2020 онд хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэн ажилуулсан 2 аж ахуйн нэгж байгууллагын гэрээг 2021 оны 09 дүгээр сард дүгнэж, нийт 10,080,000 төгрөгний урамшууллыг ажил олгогчдод олгосон.<br>-“Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх” хөтөлбөрийн ажил олгогчийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2021 онд “Мөнхцаглашгүй” ХХК, “Универсум” ХХК–ууд зорилтот бүлгийн ажил хайгч 2 иргэнтэй ажил олгогчийг дэмжих гэрээ байгуулсан. Хөтөлбөрийн дагуу эдгээр иргэдийг 12 сараас дээш хугацаагаар ажиллуулсан тохиолдолд, гэрээг 2022 дүгнэж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр ажил олгогчид олгоно. | | | | | | | | |
| 2.8 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ. | | | | | | | | | | |
| 63 | 2.8.1 Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг технологийн шийдлээр дэмжихэд анхаарч, бүтээгдэхүүнийг сурталчилна. | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, "Сүхбаатар дүүрэгт үйлдвэрлэв" борлуулалтын цэгийг ажиллуулна. | 15000.0 | Дүүргийн төсөв | Борлуулалтын 1 цэг ажиллуулж, 80 үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээгдэхүүнийг борлуулна. | Тоо | | Борлуулалтын цэгийн үйл ажиллагааг эхлүүлж тоног төхөөрөмж авч, бүрэн тохижуулсан байна. | ХХҮХ | 100% |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="8">- "Сүхбаатар дүүрэгт үйлдвэрлэв" борлуулалтын цэгийн тохижилтын ажлыг БУЗТ ХХК гүйцэтгэж, 2021 оны 4 дүгээр сард хүлээлгэн өгч Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвөөс 380,000 төгрөгийн лэд гэрэлтэй хаяг, 495,000 төгрөгийн ханын хувцасны тогтоогч, өлгүүр /өргөн 6м, өндөр 2,2м/ худалдан авч суурилуулан борлуулалтын цэг ажиллаж эхэлсэн.<br>Борлуулалтын цэгт 64 үйлдвэрлэл эрхлэгчийн үндэсний болон европ загварын хувцас, арьсан гутал, цүнх, ноос ноолууран хувцас, хүүхдийн болон том хүний биеийн тамирын хувцас, бэлэг дурсгалын үнэртүүлэгч лаа зэрэг 65 нэр төрлийн 1095 ширхэг бүтээгдэхүүн байршиж, 1,754,800 төгрөгийн борлуулалт хийж үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна.<br>Цар тахлын үед "Сургалт, судалгаа мэдээллийн төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Бүтээгдэхүүн сурталчлах, борлуулалтыг дэмжих төв" болгон ажиллуулж 19 үйлдвэрлэл эрхлэгчийн 20 нэр төрлийн бүтээгдэхүүнийг сурталчлан 792,500 төгрөгийн бүтээгдэхүүн борлогдож, 890,000 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх захиалгыг аваад байна.</td></tr>
<tr><td rowspan="2">64</td><td></td><td>Сургалт мэдээллийн төвөөр дамжуулан үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах цахим хуудсыг ажиллуулна.</td><td>7000.0</td><td>Дүүргийн төсөв</td><td>100-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээгдэхүүнийг танилцуулна.</td><td>Тоо</td><td>Шинээр хийгдэх ажил</td><td>100-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээгдэхүүнийг танилцуулсан байна.</td><td>ХХҮХ</td><td>100%</td></tr>
<tr><td></td><td colspan="8">Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулан зах зээлд бие даан үйлдвэрлэлээ явуулахад бэлтгэн гаргах, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэн улмаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой вэб сайтын ажлыг гүйцэтгэх Грийн софт ХХК, Модив софт ХХК, Мета вайс ХХК, Ай Ти Солушинг ХХК гэх дөрвөн байгууллагын үнийн саналыг судлан үзэж, вэб сайт хийхээр Модив софт ХХК сонгогдоод байна.</td></tr>
<tr><td>65</td><td></td><td>Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэлийг тогтмолжуулснаар, шаардлагатай интернэт орчны үйлчилгээ үзүүлэх "Хамтын оффис"-ыг ажиллуулна.</td><td>-</td><td>-</td><td>300-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчийг бүртгэж, давхардсан тоогоор 1060 үйлдвэрлэл эрхлэгчдэд "Хамтын оффис"-ын үйлчилгээг үзүүлнэ.</td><td>Тоо</td><td>Дүүргийн 300 үйлдвэрлэл эрхлэгчийг бүртгэсэн.</td><td>300-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчийг бүртгэж, давхардсан тоогоор 250 үйлдвэрлэл эрхлэгчдэд "Хамтын оффис"-ын үйлчилгээг үзүүлсэн байна.</td><td>ХХҮХ</td><td>100%</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | - Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвтэй хамтран 2021 оны 03 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд дүүргийн үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхэлдэг 1040 аж ахуй нэгжээс 59 асуумжаар бүртгэл, судалгааг хийж, 205 аж ахуй нэгжийн мэдээллийг шинэчилсэн.<br>- Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв, “Эм Ай Си Жи” судалгааны байгууллагатай хамтран үйлдвэрлэл эрхлэгчдийн нөхцөл байдлын үнэлгээнйи 10 асуумж бүхий судалгааг 2021 оны 05 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд 171 аж ахуй нэгжтэй утсаар холбогдон авч, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвд хүргүүлсэн.<br>- Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэлийг тогтмолжуулж, шаардлагатай интернет орчны үйлчилгээ үзүүлэх "Хамтын оффис" буюу компьютерийн лаборатори ажиллуулж 150 иргэнийг хамруулан ажилласан.<br>- - Сэлбэ дэд төвийн ЖДҮЭДХөгжлийн төвийн нэг цэгийн үйлчилгээнд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн 5 албан хаагч өдөр бүр ээлжлэн ажиллаж нийт 1100 иргэнд төрөөс жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд олгох зээл, хөнгөлөлтийн талаарх зөвлөгөөг өгч ажилласан. | | | | | | | | |
| 66 | 2.8.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд бизнес эрхлэгчид, Старт ап бизнес компаниуд, инновацын төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулна. | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж байгууллагуудыг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулна. | | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. | НХХ ХөХҮХ | 100% |
| | | -Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Дэлхийн банкны хөрөнгө оруулалттай “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн удирдамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдаж, “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ”–ний жижиг зээлийн зарыг дүүргийн вэб сайт, цахим хуудас, 1-20 дугаар хорооны мэдээллийн самбарт 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс байршуууллаа. Зарын дагуу утсаар болон цахимаар 323 иргэн бүртгэж, зээлийн өмнөх 2 өдрийн сургалтанд 260 иргэн хамруулж, нийт 61 иргэн төсөл ирүүлснээс 52 төслийг “ХААН” банкинд уламжиллаа. Үүнээс 20 иргэний төсөл дэмжигдэж, 181,500,000 төгрөгийн санхүүжилт авсан. Санхүүжилт олгогдсоноор 34 ажлын байр хадгалагдаж, шинээр 6 ажлын байр бий болсон.<br>-“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 21 төсөл 100,000,000 төгрөг, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 12 төсөл 36,000,000 төгрөг, “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-т 11 иргэн 55,000,000 төгрөгний төслүүд шалгарч, санхүүгийн дэмжлэг олгов. ‘’Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгийн төсөл хүлээн авах хугацааг 14 хоног сунгаж, мэдээллийг нийтэд ил тод хүргэсэн. | | | | | | | | |
| 67 | 2.8.3 Зорилтот бүлгийн болон үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын байрны | Зорилтот бүлгийн болон үйлдвэрлэл эрхлэгчдэд ажлын байрны | 0.0 | - | Давхардсан тоогоор 200-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгч иргэн, | Тоо | Дүүргийн 30 үйлдвэрлэл эрхлэгчдэд ажлын байрны хөнгөлөлттэй | Үйлдвэрлэл эрхлэгч 50-аас доошгүй иргэн, 2 зорилтот бүлгийн иргэн ажлын | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ, бизнес инкубацийн арга хэмжээнд хамруулна. | болон тусгай төрлийн тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээг үзүүлнэ. | | | 14 зорилтот бүлгийн иргэнийг ажлын байраар хангаж, 80 иргэн, аж ахуй нэгжид тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээг үзүүлсэн байна. | | түрээсийн үйлчилгээ үзүүлж, 53 иргэнийг ажлын байраар хангаж, зорилтот бүлгийн 1 иргэнд үйлчилгээг хүргэж ажилласан. | байраар хангаж, 20 иргэн, аж ахуй нэгжид тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээг үзүүлсэн байна. | | |
| | | - Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвөөс 29 үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгж, иргэнтэй хөнгөлөлттэй нөхцлөөр ажлын байрны түрээсийн гэрээ байгуулан 57 иргэнийг ажлын байраар хангасан. Хөнгөлөлттэй түрээсийн 114 дүгээр өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж бүтээгдэхүүн борлуулалтыг дэмжин ажиллаж байна.<br>- Цар тахлаас шалтгаалан өндөржүүлсэн бэлэн байдал болон бүх нийтийн бэлэн байдал зарласан тул үйлдвэрлэл эрхлэгчийн түрээсийн төлөлтийг 1,2,4,5 дугаар саруудад 54,74% буюу 6,929,270 төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, үйлдвэрлэлийн зардалд дэмжлэг үзүүлсэн.<br>- Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн 109-р өрөөнд дүүргийн 300 гаран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Итгэлийн оч гал дөл” НҮТББ нь “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын “Хамтдаа даван туулъя” төслийн хүрээнд 6 оёдлын тоног төхөөрөмж, 120$м^2$ талбай бүхий хүлэмжийг тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн хамт хүлээн авсан. Энэхүү ажил эхэлснээр хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэн байнгын ажлын байраар хангагдахаар болсон тул байгууллагын зүгээс 10$м^2$ өрөөг томруулан 18$м^2$ өрөөнд сэлгүүлэн оруулж, үйл ажиллагааг нь дэмжсэн. Мөн “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын “Гал голомт” хөтөлбөрийн хүрээнд “Итгэлийн оч гал дөл” НҮТББ 0-5 насны тэжээлийн дутагдалтай хүүхэдтэй 75 өрхөд хүнсний тусламж өгөх үйл ажиллагаанд байгууллагын зүгээс өрөө тасалгаагаар хангаж дэмжин ажилласан.<br>- Засгийн газраас зарлагдсан жилийн 3%-ийн хүүтэй зээл зарлагдсантай холбогдуулан 2021 оны 03 дугаар сарын 16-26-ны өдрүүдэд байгууллагын үйлдвэрлэл эрхлэгчдийн зээлийн хүсэлтийн мэдээлэл боловсруулж, Худалдаа хөгжлийн банкинд хүргүүлсэн. Дүүргийн жижиг дунд үйлвэрийг дэмжих төвийн 1 үйлдвэрлэл эрхлэгч 50,000,000 төгрөгийн зээл авсан.<br>- Тусгай төрлийн тоног төхөөрөмж /хатгамлын машин, канза/-ийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлж, нэг иргэнийг операторoор ажиллуулан ажлын байраар хангасан. Тус үйлчилгээг 85 иргэн, аж ахуй нэгжид хүргэж 860,000 төгрөгийн борлуулалт хийж, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжсэн. | | | | | | | | |
| 68 | 2.8.4 Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх мэдээллийн төвд үйлдвэр | Үйлдвэрлэл эрхлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн чадавхжуулах болон бизнесийн | 8000.0 | Дүүргийн төсөв | 1200 гаруй үйлдвэр эрхлэгчийг хамруулна. | Тоо | 16 удаагийн сургалт, 2 удаагийн танилцах аялалд зохион байгуулж давхардсан тоогоор 500 гаруй иргэнийг хамруулсан. | 8 удаагийн сургалтад 200, танилцах аялалд 40 бизнес эрхлэгчийг хамруулсан байна. | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрхлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан төрөл бүрийн сургалт, уулзалтыг зохион байгуулна. | төрөл бүрийн танхимын болон цахим сургалт, туршлага солилцох бизнес аялдыг зохион байгуулна. | | | | | | | | |
| | | - “Эх оронч худалдан авалт үндэсний үйлдвэрлэл 2021” цахим үзэсгэлэн худалдаа арга хэмжээний хүрээнд 2021 оны 04 дүгээр сарын 12-19-ний өдрүүдэд Татварын ерөнхий газраас “Татвар төлөлт, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн анхаарах асуудал”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, хөнгөлөлт, чөлөөлт”, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагаас “Компанийн засаглалын тухай", Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ” сэдвүүдэр зохион байгуулсан цахим сургалтанд 45 үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулан ажилласан.<br>- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Европын сэргээн босголт хөгжлийн банк хамтран сошиал медиа маркетинг, сав баглаа боодол, хүний нөөц, санхүү, менежментийн нийт 26 удаагийн цуврал цахим сургалт, зөвлөгөөнд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн бойжигч болон бичиг бизнес эрхлэгч 500 иргэнийг хамруулсан бөгөөд салбарын болон зээлийн мэдээлэл зөвлөгөөг давхардсан тоогоор 1658 иргэнд тус тус хүргэсэн.<br>- Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн удирдлага, албан хаагчид 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдөр дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үйл ажиллагаа болон дэмжих төвийн бойжигч нартай санал солилцож үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнийг танилцуулан сурталчилж, харилцан санал солилцож, туршлага судалсан.<br>- Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын “Бизнес инкубаци төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд “Технож” бизнес инкубаци төвийн захирал Г.Галаарийдий, судлаач, доктор Н.Мөнхөө нар 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдөр байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, бойжигчдын үйлдвэрлэл, бүтээгдэхүүнийг танилцуулан сурталчилж, туршлага судалсан.<br>- Байгууллагын үйлдвэрлэл эрхлэгч, үйлчлүүлэгч иргэдийг зээл, салбарын эрх зүй, цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор дүүргийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн мэдээллийн самбарт нийт 60 мэдээ байршуулсан. | | | | | | | | |
| 69 | | Мэргэжлийн холбоодтой хамтран тэмцээн уралдаан, уулзалт, арга хэмжээг зохион байгуулж, шилдэг үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг сурталчлан, урамшуулах | 5000.0 | Дүүргийн төсөв | 100-аас доошгүй иргэнийг хамруулж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | Тоо | Шинээр хийгдэх ажил | 100-аас доошгүй иргэнийг хамруулж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн байна. | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг зохион байгуулна. | | | | | | | |
| | | - 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр БНСУ-ын Чугчёонбуг мужийн удирдлага, бизнес эрхлэгчид ба Сүхбаатар дүүрэг болон Сүхбаатар аймгийн удирдлага, ЖДҮДТ-ийн 10 эмэгтэй бизнес эрхлэгчдийг танилцуулах, талуудын цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцох уулзалт, сургалтыг зохион байгуулан ажилласан.<br>- НЖДҮҮДХ төв дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв хамтран 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Санхүүгийн мэдлэг олгох” сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>- Албан хаагчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх үүднээс Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналын төрөл, түүнийг олгох журмын дагуу ДИТХ болон Засаг даргын хамтарсан шагналд Э.Жаргалтуяаг “Хүндэт тэмдэг”-ээр, жижүүр Б.Индрээбүд, Х.Очирбат нарыг “Хөдөлмөрийн алдар” медалиар, Монголын Залуучуудын Холбоо үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд ажлын гүйцэтгэлээрээ манлайлсан тэргүүний ажилтан А.Баярцэнгэлийг ”Тэргүүний залуу” цол тэмдгээр шагнуулсан.<br>- Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны Санкол өрхийн эмнэлэгтэй хамтран 2021 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр 35 албан хаагчид болон үйлдвэрлэл эрхлэгчдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан.<br>- Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэлийн спортын хороо, төрийн бус байгууллагуудтай хамтран 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11-р сарын 30-ны өдрүүдэд улсын хэмжээнд анх удаа зохион байгуулж байгаа “Цахим гимнастрада” биеийн тамирын арга хэмжээнд байгууллагын ажилтан албан хаагчид болон 54 үйлдвэр эрхлэгчдийг хамруулан оролцож байна.<br>Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 382 жилийн ойг тохиолдуулан 10 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан Их хотын хямдрал-2021 арга хэмжээнд дүүргийн үйлдвэрлэл эрхлэгч болох ноосон нэхмэл бүтээгдэхүүн, төрөл бүрийн оймс, гутал, эсгий тавчик, үндэсний хувцас, хүүхдийн танин мэдэхүйн ном, сахар, савласан цай, N95 маскны үйлдвэр нийт 7 аж ахуйн нэгжийг оролцуулж борлуулалтыг дэмжиж ажилласан. Үзэсгэлэнгийн үеэр МҮХАҮТ, УБХЗАА-аас нийслэлийн иргэдэд хямдралтай, урамшууллалттай худалдаа үйлчилгээгээр бэлэг барьж идэвхитэй оролцсон аж ахуйн нэгжүүдэд батламж олгосон. | | | | | | | |
| 70 | 2.8.5 Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтран ажиллах, гадаад, дотоодын зах зээлд таниулах, үзэсгэлэн худалдаанд хамруулна. | Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, дотоод гадаадын үзэсгэлэн, яармаг худалдаанд хамруулж, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. | 15000.0 | Дүүргийн төсөв | Гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаанд 240 үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулж, дэмжин ажиллана. | Тоо | Гадаад, дотоодын 11 удаагийн үзэсгэлэн худалдаануудад 92 үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжин оролцуулсан. | Дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаанд 40 үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулсан байна. | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | - Хөдөө орон нутагт үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг танилцуулах зорилгоор ЖДҮД төвийн хариуцсан мэргэжилтэн зуучлан 4 үйлдвэрлэл эрхлэгч бараа бүтээгдэхүүнээ Дорноговь, Хөвсгөл, Дундговь, Хэнтий аймагт 2021.01.05-ны өдрөөс 11.09-ний өдрийн хүртэлх хугацаанд тавилгын үйлдвэрлэл, монгол футболк, үндэсний болон европ хувцас, арьсан гутал үйлдвэр эрхлэгчид хамтран зөөврийн борлуулалтын үйлчилгээ ажиллуулж 13,495,000 төгрөгийн борлуулалт хийсэн.<br>- "Монгол Японы Цахим Бизнес Форум, Үзэсгэлэн 2021" www.exportmongolia.org цахим талбарт 2021.06.25-наас 7.05-ны хооронд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгжүүдийг дэмжих, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнийг Япон улсын зах зээлд таниулан сурталчлах, хэрэглэгч захиалагчтай холбох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд дүүргийн Содон фүүдс ХХК, Цаст согоот ХХК, Каспийн эрдэнэс ХХК, Эко амьдрал ХХК, Янмал ХХК-ыг оролцуулан дэмжиж ажилласан.<br>- Цахим борлуулалтыг дэмжих ажлын хүрээнд бүх идэвхтэй фэйсбүүк группууд болох "Одтой бүсгүйчүүд", "7-н буудал, Дамбадаржаа, Бэлх, Сэлхийн зарын групп", "Завгүй ээжүүд", "Sally comedy group", "Ноолууран хувцсанд дурлагчид", "Гэрээсээ дэлгүүр хэсье", "Bolor home shop", "Хайсан бүхнээ эндээс", "Солонгон ааштын увидас", "Ээжүүдийн групп", "Mom`s store", "Монгол дээл, лоовууз, малгай", "Улаанбаатар зарын нэгдсэн групп", "Монголын хамгийн том зарын групп", "Дамбадаржаа, Тоосго, Бэлх, сэлхийн зарын нэгдсэн групп" рүү 8 үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг танилцуулж, "Шинэ сүлжээ кашимер" ХХК өндөр борлуулалттай идэвхтэй ажиллаж 550,000 төгрөгийн борлуулалт хийсэн.<br>- "Хичээлийн шинэ жил-2021", "НЖДҮД Хөгжлийн төвийн нээлтэд зориулсан үзэсгэлэн худалдаа", "Худалдаа 100" жилийн ойн хүрээнд МҮХАҮТ-аас зохион байгуулсан үзэсгэлэн худалдаа, "Нээлттэй хаалганы өдөрлөг 2021", "Нэг ч ЖДҮҮЭ хөгжлөөс хоцрох ёсгүй", "Соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч ЖДҮҮ эрхлэгчийн анхдугаар зөвлөгөөн 2021", "Их хотын хямдрал-2021" зэрэг 10 гаруй үзэсгэлэн худалдаанд 40 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулж борлуулалтын сувгийг нэмж ажилласан.<br>2021 онд дотоодын үзэсгэлэн худалдаанд 60 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулж 63,330,00 төгрөгийн борлуулалттай ажилласан байна. | | | | | | | | |
| 2.9 Соёлын үйл ажиллагааг дэмжиж, түгээн дэлгэрүүлнэ. | | | | | | | | | | |
| 71 | 2.9.1 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд, залуучууд, иргэдийн авьяасыг нээн хөгжүүлэх, урлаг соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулна. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд "Хүрэл тулга" "Уран жиргээ" уралдаан зохион байгуулна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | 2019 онд Уран жиргээ наадамд нийт 153 хүүхэд оролцож, шалгарсан 16 хүүхэд нийслэлийн шалгаруулалтад оролцсон. | Улс, нийслэлийн уралдаан тэмцээнд оролцуулж, амжилт гаргасан байна. | НХХ, БХ | 0% |
| | | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Журам батлах тухай 45 дугаар тогтоол, 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай 176 дугаар тогтоол, 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 259 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Түр журам батлах тухай 18,20,21 дүгээр тушаал, 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар хурлын тэмдэглэл, Боловсрол, Шинжлэх Ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 08 сарын 19-ний өдрийн А/292,А/525 дугаар тушаалын 2.15- | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | д Хүүхэд, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан аливаа тэмцээнийг зохион байгуулахыг хориглоно гэж заасны дагуу олон нийтийг хамарсан тэмцээн уралдаан зохион байгуулагдаагүй. | | | | | | | | |
| 72 | | ЕБС-ийн сурагчдын дунд хүүхдийн найрал дууны наадам зохион байгуулна. | 6,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | 2019 онд ЕБ-ын 9 сургуулийн 1000 орчим сурагчид оролцсон. | Улс, нийслэлийн уралдаан тэмцээнд оролцуулж, амжилт гаргасан байна. | НХХ, НСУГ, БХ, ЕБС | 0% |
| | | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Журам батлах тухай 45 дугаар тогтоол, 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай 176 дугаар тогтоол, 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 259 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Түр журам батлах тухай 18,20,21 дүгээр тушаал, 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар хурлын тэмдэглэл, Боловсрол, Шинжлэх Ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 08 сарын 19-ний өдрийн А/292,А/525 дугаар тушаалын 2.15-д Хүүхэд, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан аливаа тэмцээнийг зохион байгуулахыг хориглоно гэж заасны дагуу олон нийтийг хамарсан тэмцээн уралдаан зохион байгуулагдаагүй болно. | | | | | | | | |
| 73 | | Дээлтэй Монгол наадам зохион байгуулж, оролцоно. | 8,000.00 | Дүүргийн төсөв | Соёлын аялал жуулчлалыг сурталчлах | Тоо | 2017,2018 онд дэд байрт, 2019 онд Тэргүүн байрт тус тус шалгарсан. | Үндэсний өв соёлыг хадгалж, түгээн дэлгэрүүлсэн байна. | НХХ, НАЖГ | 30% |
| | | -Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Улсын баяр наадмыг цахимаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай А/75 дугаар тушаалын дагуу Хүй долоон худагт 5 гэр барьж, наадмын цахим бичлэг хийхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай 176 дугаар дугаар тогтоолын дагуу Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Дээлтэй монгол наадам зохион байгуулагдаагүй болно. | | | | | | | | |
| 74 | | Соёл урлагийн байгууллагуудтай хамтран хүүхэд, залуучууд, иргэдийг соёлын боловсрол олгох үзвэр үйлчилгээ, арга хэмжээнд хамруулна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | | Хүүхэд, залуучуудад соёл, урлагийн үйлчилгээ хүрсэн байна. | НХХ,, НСУГ | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 75 | | -Нийслэлийн Соёл урлагийн газраас “Улаанбаатар соёлтой болГоё” уриалгатай плакат, жижиг наалт тус бүр 2000 ширхэг ирүүлснийг 1-20 дугаар хороогоор дамжуулан иргэн, аж ахуйн нэгж байгууллага, гудамж, орон сууцны орцоор нааж, байршуулан иргэдэд сурталчилсан. Дүүргийн ЗДТГ, дэргэдэх хэлтэс, хороодын ЗДАА-ны албан хаагчдыг Хотын соёл аянд нэгдэхийг уриаллаа.<br>- Их хотын залууст хотын соёлыг төлөвшүүлэх зорилгоор Жамъяан гүний гудамжинд дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Өглөөний гудамж” тохижуулан 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдөр албан ёсоор нээж, тус гудамжинд аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж, өөрсдийн гэсэн өвөрмөц онцлогтой цэсээр үйлчилгээ үзүүлж, үнэгүй WiFi-тай орчинд өглөөний цайгаа уух, дугуйтай зорчих, алхах, урлаг спортын арга хэмжээнд хамрагдах, сургалт, уулзалт зохион байгуулах, гудамжны номын сангаар үйлчлүүлэх боломжтой болсон. Мөн Жазз Лав ТББ-тай хамтран Монгол, гадаадын хамтарсан жааз хөгжмийн тоглолтыг 7 хоногийн 1 дэх өдөр болгон тоглуулж ажилласан. | | | | | | | |
| 75 | 2.9.2 Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна. | Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Хамруулсан хүний тоо | Тоо | | 100 залуучуудыг хамруулсан байна | НХХ, ХГБЗХ Х, НСУГ, БХ | 100% |
| | | -Сэтгэцийн эрүүл мэнд, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх 3 постер зөвлөмж бэлтгэж, фэйсбүүк хуудсаар 2760 хүнд хүргэлээ.<br>-Голын эрэг дагуу амарч зугаалж байгаа 798 иргэнд "Хоггүй зугаалах гоё" уриа бүхий наалттай хогийн уут, зөвлөмж тараасан.<br>-НГБХЗХГ-аас зохион байгуулсан “Хот хоггүй бол гоё” аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Сэлбэ голын эрэг дагуух 5 км орчим газарт дүүргийн Хүүхдийн элч болон Хүүхдийн холбооны 15 гишүүнтэй хамтран сайн дурын цэвэрлэгээ хийлээ.<br>-“Оролцоод хөгжье 2021” чуулганыг хүүхэд, залуучуудынхаа оролцоог нэмэгдүүлэх, тэдний өмнө тулгамдаж байгаа асуудлыг хамтдаа шийдвэрлэх, Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын чадавхыг бэхжүүлэх, хүүхдийн амьдралын бүхий л талбарт хүүхдийн оролцоог тодорхойлох, хүүхдийн төлөө хийж байгаа ажлуудыг хүүхдийн нүдээр харж үнэлэх, тэдэнд тулгамдсан асуудлыг бодлого шийдвэрт тусгах, “Хүүхдийн элч”-ийг томилох, хүүхдийн эрх, хамгаалалд нийгэмд үүрэг хүлээж байгаа хүн бүрийн санаа, бодлыг тусгах зорилгоор 2021 оны 05 дугаар сарын 02-ны өдөр цахимаар амжилттай зохион байгуулсан. Чуулганд дүүргийн төрийн болон төрийн бус ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн хүүхэдтэй ажилладаг 32 байгууллагын мэргэжилтнүүд зочноор уригдаж, хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаагаа танилцуулсан. Сүхбаатар дүүргийн “Хүүхдийн элч”-ээр тус дүүргийн 1-р хорооны иргэн, дуучин Н.Цэцэнбилэг нэр дэвшиж, 100 хувийн саналаар дэмжигдэн, хүүхдийн элчийн тангараг өргөсөн.<br>-Сурагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бүтээлч сэтгэлгээг өргөжүүлэх, 10 зөв дадлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 5 төрлийн постер бэлтгэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон хэлтсийн пэйж хуудсаар дамжуулан 2,780 хүүхдийн хандалт авлаа. | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | - Дүүргийн Ерөнхий боловсролын 49 сургуулийн 9-12 дугаар ангийн 1,500 сурагчийг хамруулан “Цахим орчинд эерэг байя” /Тик-Ток/ бичлэгийн уралдааныг цахимаар зохион байгууллаа.<br>-4,280 өсвөр үе, залуус олон нийтийг хамруулж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, цахим орчныг зохистой хэрэглэх, эрүүл зөв дадлыг амьдралдаа хэвшүүлэхэд үе тэнгийнхнээ уриалах, аливаад эерэг хандлагаар хандахад суралцсан. | | | | | | | | |
| 76 | | Нийслэлийн залуучуудын 10 зөв дадал, Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт зохион байгуулна. | 1,000.00 | Дүүргийн төсөв | Хамруулсан хүний тоо | Тоо | 3000 | Нийт 3000 өсвөр үе, залуучуудыг хамруулсан байна. | НХХ, ХГБЗХ Х | 100% |
| | | -Сүхбаатар дүүргийн Залуучуудын хөгжлийн төв фэйсбүүк хуудас болон Ражив Гандийн Нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж фэйсбүүк хуудсаар дамжуулан залуучуудыг эерэг хандлага, эрүүл амьдралын хэвшилд уриалсан 5 төрлийн постер бэлтгэн 2780 хүнд хүргэлээ.<br>-Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх 12 модуль сургалтын хүрээнд Харилцаа” сэдвээр сургалт зохион байгуулж, зорилтот бүлгийн 5 залуу хамрагдав.<br>-Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авч буй хорихоос өөр төрлийн ялтай 4 залуу, “Манай гэр” асрамж халамжийн төвд амьдарч байгаа 15 хүүхэд, нийт 19 өсвөр үе, залуусыг хамруулан “Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх 12 модуль сургалт” зохион байгуулсан.<br>-Ерөнхий боловсролын 16 дугаар сургууль, Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 540 өсвөр үе, оюутан залуусыг хамруулан “Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх 12 модуль” сургалт зохион байгуулсан. | | | | | | | | |
| 77 | 2.9.3 Хөшөө, дурсгалт газруудын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, соёлын аялал жуулчлалыг дэмжинэ. | Нутаг дэвсгэрт байрлах хөшөө дурсгалт газруудын арчлалт хамгаалалтыг сайжруулах хяналт, шалгалт хийж, холбогдох газартай хамтран ажиллана. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | Дурсгалт газруудын хадгалалт хамгаалалтад тогтмол хяналт тавин ажиллаж , 42 дурсгалд кадастрын зураглал хийлгэсэн. | Түүх соёлын үл хөдлөх хөшөө дурсгалын арчлалт, хамгаалалтыг сайжруулж, угааж, арчин нөхөн сэргээсэн байна. | НХХ , ТНААХ | 100% |
| | | -Нийслэлийн Соёл Урлагийн газартай хамтран дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Түүх соёлын дурсгалт Дамбадаржаалин хийдийн хадгалалт, хамгаалалтын байдалт хяналт хийсэн.<br>-Дүүргийн газрын албатай хамтран 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 14/749 албан бичгээр нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд түүх соёлын дурсгалт газруудын кадастрын бүртгэлийг мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлт хүргүүлсэн. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр, Бэлхийн аманд байрлах Хүннүгийн үеийн булш байрлах газарт 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хяналт хийхэд тус газарт 2014 онд хийсэн тохижилтын ажлын сүүдрэвч, сандал, гэрэлтүүлэг, хогийн сав, танилцуулга зэрэг нь алдагдсан байсан тул дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэст Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 3/610 албан бичиг хүргүүлсэн.<br>-Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/496 дугаар захирамжаар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булшны археологийн судалгаа" төслийг 2021 оны 6-р сарын 25-аас 8-р сарын 18-ыг хүртэлх 45 хоногийн хугацаанд хэрэгжүүлж, төслийн үр дүнд дурсгалын дэвсгэр зургийг үйлдэж, хүннүгийн язгууртны үүдэвч бүхий нэг булшийг сонгон малтлага судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд өнгөн хөрснөөс доош 3 үе шаталсан, 5.5 м гүнтэй, урвуу пирамид хэлбэрийн оршуулгын нүхийг анх хүннүчүүдийн ухсан байдлаар малтан илрүүлэв. Оршуулгын нүхнээс модон бунхны үлдэгдэл, авсны хүрэл чимэглэлүүд, сүйх тэрэгний тоног хэрэгсэл, гоёл чимэглэл, ваар савны хагархай зэрэг тухайн язгууртны зэрэг дэвийг илтгэх эд өлгийн зүйлс, хүний ясны хэсэг илэрч олдов.<br>-Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэнтэй хамтран 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын хөшөө, дурсгалт газруудын хадгалалт, хамгаалалтын байдалд төлөвлөгөөт хяналт хийлээ.<br>-Дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Хөдөлмөрийн баатар, академич, эрдэмтэн зохиолч Б.Ширэндэвийн хөшөөг Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-ын ажилтанууд 2021.06.22-ны өдөр угааж арчин, өнгө үзэмжийг сайжруулсан.<br>-Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас Нацагдоржийн хөшөө, Цэдэнбалын хөшөөний сэргээн засварлалтын ажлыг 2021 оны 7 дугаар сард Бодь буян ХХК-иар хийлгэж, дүүрэгт хүлээлгэн өгсөн болно.<br>Соёлын өвийн төвтэй хамтран Соёлын биет өв бүртгэх PCH3 программыг суулгаж, дүүргийн түүх соёлын дурсгалт газруудын дэлгэрэнгүй мэдээллийг оруулан ажиллаж байна. | | | | | | | | |
| | | 2.10 Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжин, гэр бүлийн тогтвортой байдлыг хангаан ажиллана. | | | | | | | | |
| 78 | 2.10.1 Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Жендерт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх Төвийн үйл ажиллагааг дэмжиж зардлыг шийдвэрлэнэ. | | | Зардлын хэмжээ | Хувь | | Төвийн үйл ажиллагааг дэмжиж зардлыг шийдвэрлэсэн байна. | НХХ, ХГБЗХХ | 100% |
| | | Жендерт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ "Нэг цэгийн үйлчилгээний төв"-д цагдаагийн аюулын зэргийн үнэлгээ, хүүхдийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн нийт 170 үйлчлүүлэгчийг хүлээн авч, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс насанд хүрэгч-12, хүүхэд-158 үйлчлүүлсэн бөгөөд Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ авсан 158 үйлчлүүлэгчдэд хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүйн холбон зуучлах үйлчилгээнээс гадна амьдрах ухааны чадвар олгох зорилгоор хүүхдийн насны онцлогт тохируулан өөртөө үйлчлэх чадвар, харилцааны чадвар, хооллолт, аюулгүй байдлын төлөвлөгөө хүүхэд тус бүр дээр боловсруулан, үндэсний өв уламжлалыг өвлүүлэх чиглэлээр ажилласан. (Дүүргийн харьяалалтай 80 хүүхэд, 8 насанд хүрэгч) | | | | | | | | |

<table>
<tr><td rowspan="2">79</td><td rowspan="6">2.10.2 Хүүхэд, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.</td><td>Алдарт эхийн одонтой эхчүүдийг алдаршуулна.</td><td>150,000.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Алдарт эхийн одонтой эхчүүдийн тоо</td><td>Тоо</td><td>7000</td><td>Эхчүүдийг алдаршуулсан байна.</td><td>НХХ, ХЗДАА</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">-Алдарт эхийн одонтой эхүүдийн судалгааг хороо тус бүрээр гаргаж, нийт 7545 Алдарт эхийн одонтой эхчүүдийн судалгаа нэгтгэв. Үүнээс: 1 дүгээр зэргийн одонтой 1794 эхчүүд, 2 дугаар зэргийн одонтой 5755 эхчүүд байна.<br>Сүхбаатар дүүргийн 20 хорооны Засаг даргын ажлын албанаас Алдарт эхийн 1, 2 дугаар одонгоор шагнагдах эхчүүдийн материалыг хүлээн авахдаа 2011 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын хууль, 2011 оны 06 дугаар сарын 08-ны Журам батлах тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн 116 дугаар зарлиг, Монгол улсын Ерөнхийлөгчийн 116 дугаар зарлигийн хавсралт “Эхчүүдэд алдар эхийн нэг, хоёрдугаар зэргийн одон шагнах тухай” журмын дагуу 2021 онд Алдарт эхийн нэгдүгээр одонгоор шагнагдах 32, хоёрдугаар одонгоор шагнагдах 319, нийт 351 эхийн материалыг 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авлаа. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шагнагдаж буй эхчүүдэд Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одон гардуулах үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Төрийн одонд зохион байгуулагдлаа. Төрийн ордоны хашаанд байрласан шинжилгээний явуулын цэгт Ковидийн түргэвчилсэн шинжилгээнд хамрагдаж сөрөг хариу гарсан эхчүүд Төрийн ордонд орж Монгол улсын Ерөнхийлөгч Х.Баттулгаас Алдарт эхийн одонгоо гардан авлаа.<br>Ерөнхийлөгчийн Тамгын газраас Алдарт эхийн одон гардан авч буй эхчүүдийн зургийг дүүрэг хороогоор дамжуулан эхчүүдэд дурсгав.</td></tr>
<tr><td rowspan="2">80</td><td>Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага шалгаруулна.</td><td>5,600.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>ХГБүлд ээлтэй байгууллагын тоо</td><td>Тоо</td><td>7</td><td>Аж ахуйн нэгж, байгууллагын хамрагдалт ахисан байна.</td><td>НХХ, ХГБЗХ Х, ААНБ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">-Дүүргийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А\318 дугаар захирамжаар байгуулагдсан 2021 оны Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага шалгаруулах ажлын хэсгийн хурлаар Хүүхэд, гэр бүлд ээлтэй хороогоор “16 дугаар хороо”, Хүүхэд, гэр бүлд ээлтэй цэцэрлэгээр “175 дугаар цэцэрлэг”, Хүүхэд гэр бүлд ээлтэй сургуулиар “35 дугаар сургууль”, Хүүхэд, гэр бүлд ээлтэй үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагаар “Монголын хүүхдийн урлан бүтээх төв”-ийг тус тус шалгаруулсан. Шалгарсан байгууллагуудын материалуудыг Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 1/1373 дугаар албан бичгээр нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэв.<br>-Дүүргийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А\318 дугаар захирамжаар байгуулагдсан 2021 оны шилдэг хүүхэд шалгаруулах ажлын хэсэг Ерөнхий боловсролын 47 сургууль, хүүхдийн оролцооны 3 байгууллагаас ирүүлсэн хүүхдүүдийн материалыг оны “Шилдэг хүүхэд” шалгаруулах удирдамжийн дагуу шалгаруулллаа.<br>- Монгол Улсын Консерватори ерөнхий боловсролын сургуулийн сурагч О.Нандин шалгуур үзүүлэлтийн болзол хангасан тул Нийслэлийн “Шилдэг хүүхэд”-д нэр дэвшүүлэн, холбогдох танилцуулгын хамт нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүллээ.</td></tr>
<tr><td>81</td><td>Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрлөг зохион байгуулна.</td><td>20,000.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Хүүхдийн тоо</td><td>Тоо</td><td>483</td><td>Зорилтот бүлгийн хүүхдүүд хамрагдсан байна.</td><td>НХХ, ХГБЗХ Х, ААНБ</td><td>100%</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Хүүхэд, залуучуудынхаа оролцоог нэмэгдүүлэх, тэдний өмнө тулгамдаж байгаа асуудлыг хамтдаа шийдвэрлэх, Хүүхдийн өөрийн удирлагын байгууллагын чадавхыг бэхжүүлэх, хүүхдийн амьдралын бүхий л талбарт хүүхдийн оролцоог тодорхойлох, хүүхдийн төлөө хийж байгаа ажлуудыг хүүхдийн нүдээр харж үнэлэх, тэдэнд тулгамдсан асуудлыг бодлого шийдвэрт тусгах, “Хүүхдийн элч”-ийг томилох, хүүхдийн эрх, хамгааллалд нийгэмд үүрэг хүлээж байгаа хүн бүрийн санаа, бодлыг тусгах зорилгоор Оролцоод хөгжье 2021” чуулганыг 2021 оны 05 сарын 02-ны өдөр цахимаар амжилттай зохион байгууллаа. Энэхүү чуулганд дүүргийн төрийн болон төрийн бус ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн 32 хүүхэд, хүүхэдтэй ажилладаг төрийн байгууллагын мэргэжилтнүүд зочноор уригдаж, хийж хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаагаа танилцуулсан. Сүхбаатар дүүргийн “Хүүхдийн элч”-ээр тус дүүргийн 1-р хорооны иргэн, дуучин Н.Цэцэнбилэг нэр дэвшиж, оролцогч хүүхдүүдийн 100 хувийн саналаар дэмжигдэн хүүхдийн элчийн тангараг өргөсөн.<br>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан болон хөгжлийн бэрхшээлтэй нийт 58 хүүхдэд гарын бэлэг хүргэлээ.<br>-Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Журам батлах тухай 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Түр журам батлах тухай 18,20,21 дүгээр тушаал, шийдвэрийн дагуу коронавирусийн халдвараас сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх чиглэлийг УОК, Шуурхайн штабаас 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдөр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт өгсөн.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газраас Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 1-20 дугаар хорооны хөгжлийн бэрхшээлтэй 60 хүүхдэд бэлэг гардууллаа.<br>-“Цахимд эерэгийг түгээцгээе” гар зураг, крилл болон монгол бичгийн цахим уралдааныг 5 насны ангиллаар зохион байгуулж, нийт 40 хүүхдийн бүтээл хүлээн авч, амжилттай оролцсон бүтээлийг шагнаж урамшуулсан. | | | | | | | | |
| 82 | 2.10.3 Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, бүх төрлийн цахим мэдээллийн халдлагаас урьдчилан сэргийлэх ажлыг өрнүүлнэ. | Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Хамруулсан хүний тоо | Тоо | 80 | Өсвөр насны 100 хүүхэд, залуучуудыг хамруулсан байна. | НХХ, ХГБЗХХ | 100% |
| | | -Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 5 төрлийн постер бэлтгэн давхардсан тоогоор 8465 хүнд хүргэлээ.<br>-“Ковид -19” цар тахалтай холбоотойгоор сургалтын үйл ажиллагаа хязгаарласан тул хорооны фейсбүүк хуудсаар дамжуулан эцэг, эхчүүд, 8-15 насны хүүхдэд цахим хэрэглээний талаарх 3 төрлийн постер, видео бичлэг бэлтгэн 2865 иргэнд хүргэлээ.<br>-“Цахимд эерэгийг түгээцгээе” сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн ахлах ангийн 30 хүүхдэд зохион байгуулан мэдлэг, мэдээллийг дээшлүүллээ.<br>-2 дугаар улиралд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 8 төрлийн постер бэлтгэн, давхартсан тоогоор 8465 хүнд хүргэсэн.<br>-2021 оны 05 дугаар сарын 15, 08 дугаар сарын 19-ний өдөр “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулан ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн нийт 98 хүүхэд хамрууллаа.<br>-8-15 насны хүүхдүүд цахим хэрэглээг хэтрүүлэн хэрэглэхийн сөрөг тал түүнээс урьдчилан сэргийлэх 3 төрлийн постер бэлтгэн 1914 хүүхдэд, цахим хэрэглээний талаарх видео бичлэгийг бэлтгэн 798 иргэнд хүргэв. | | | | | | | | |

<table>
<tr>
<td rowspan="2">83</td>
<td rowspan="2"></td>
<td>Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, Бид хариуцлагатай гэр бүл аяныг өрнүүлнэ.</td>
<td>10,000.00</td>
<td>Дүүргийн төсөв</td>
<td>Ажлын хэсгээс зохион байгуулсан ажлын тоо</td>
<td>Тоо</td>
<td></td>
<td>Хүүхдийн осол гэмтлийн тоо буурч, эрүүл аюулгүй орчин бүрдсэн байна.</td>
<td>НХХ</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="9">-“Гэр бүлийн Үнэ цэнэ“ штрок, мэдээллийг байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулж, 100 хүнд хүргэж ажилласан.<br>-Сар бүрийн Ням гарагийг гэр бүлийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлэх тогтоолын хүрээнд гэр бүлд чиглэсэн 7 төрлийн гэр бүлийн эерэг харилцаа хандлагын талаарх мэдээлэл бэлтгэн, фэйсбүүк хуудсанд байршуулж, 2500 хүнд хүргэсэн.<br>-Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх 2 төрлийн шторк, 4 төрлийн постерыг фэйсбүүк хуудсаар нийт 2612 хүнд сурталчилсан.<br>-Хүүхдийн тусламжийн утас-108, иргэнээс ирсэн нийт 312 дуудлага мэдээлэлд хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэв.<br>-“Би хариуцлагатай аав ээж“ аяны хүрээнд 36 байгууллагын эцэг, эхийн зөвлөлөөр дамжуулан, эцэг-эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж хүүхдэдээ тавих хараа хяналтыг сайжруулах зорилгоор “Хүчирхийллийг үл тэвчье” сэдэвт постер зөвлөмж мэдээллийг бэлтгэн пэйж, хуудсанд байршуулан, иргэд олон нийтэд хүргэлээ.<br>- Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан /2021.05.15/ Үлгэр жишээ гэр бүл сэдвийн хүрээнд цахим орчинд гэр бүлдээ цагийг үр дүнтэй зарцуулж буйг харуулсан бичлэг, постер бэлтгэн дүүрэг, хороодын пэйж хуудсанд байршуулж, 2104 хүний хандалт авсан. Гэр бүлийн өдөр, корона вирусаас урьдчилан сэргийлэх талаар 5 төрлийн зөвлөмж бэлтгэн, нийт 2506 хүнд хүргэлээ.<br>-Гэр бүл дэх хүчирхийлэлд өртсөн иргэдийн судалгааг нэгтгэн мэдээллийн бааз үүсгэн цахимаар болон биечлэн нийт 303 иргэнд сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өглөө.<br>-Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газар, прокурорын байгууллагатай хамтран Ерөнхий боловсролын 36 сургуулийн 115 нийгмийн ажилтан, эрхлэгч нарт 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр “Сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал, сургуулийн эргүүл, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхтэй явуулах зэрэг асуудлаар сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>Хүүхдийн эрх ашиг зөрчигдөж болзошгүй 5 дуудлага мэдээллийн дагуу Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс болон 9 дүгээр хороо, 4 дүгээр хороодод холбон зуучилсан.<br>Сүхбаатар дүүрэг 9 дүгээр хорооны хамтарсан багийн гишүүдийн хамт архи согтууруулах ундаа хэрэглэдэг, удаа дараа дуудлага мэдээлэл ирүүлсэн, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж болзошгүй 3 өрхөөр орж архины хор нөлөө, үр дагаврын талаар яриа таниулга хийж, зөвлөгөө өгч хяналт тавилаа.<br>-2021 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 09 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл “Үер усны ослоос урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт болон явган эргүүл”-ээр БЗД-ийн 11-р хороо Баянзүрхийн гүүрнээс Маршалын гүүр хүртэл Туул голын эрэг дагуу гэр бүлээрээ амарч, зугаалж буй 3075 иргэн үүнээс 1369 хүүхэд, 1679 насанд хүрэгчдэд анхааруулга сэрэмжлүүлэг, зөвлөмж хүргэсэн.<br>-Ковид -19 цар тахалтай холбоотойгоор эцэг, эх, хүүхдүүдэд зориулсан Ковид-19 өвчнөөс хүүхдээ хамгаалах, халдвар хамгааллын дэглэм сахих 3 төрлийн постер зөвлөмжийг хэлтсийн фейсбүүк хуудсаар дамжуулан 1258 хандалт авлаа.<br>-Хичээлийн шинэ жил эхлэж байгаатай холбоотойгоор анги танхимд “Ковид–19” цар тахлаас сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм сахих, хүүхдийг болзошгүй эрсдлээс хамгаалах зөвлөмж бүхий 3 төрлийн зурагт хуудас бэлтгэн 1212 иргэнд тараалаа.</td>
</tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хамтран ажиллах, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн тайланг хагас жилээр үнэлж дүгнэн 138 албан хаагчид мөнгөн урамшуулал олгосон. Монгол улсын төрийн одон медалиар 15 албан хаагч шагнагдаж, тус бүрийг 1 сарын үндсэн цалингаар урамшуулсан. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Нэг хаалга-нэг шинжилгээ арга хэмжээнд сайн ажилласан 45 албан хаагчийг албан тушаалын үндсэн цалингийн 10-15 хувиар, нийслэлийн Аудитын газрын санхүүгийн нэгдсэн тайланд стандарт, зөрчилгүй үнэлгээ авсан 6 албан хаагчийг албан тушаалын 3 сарын үндсэн цалингаар тус тус шагнаж урамшуулсан. | | | | | | | | |
| 115 | 4.1.7 Шүүхийн шийдвэрийг биелүүлж, холбогдох хуулийн | Холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх үйл | 450,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | Шүүхийн 12 шийдвэрийг биелүүлж, 130000000 | Шүүхийн шийдвэр биелсэн байна. | ТЗУХ, СТСХ, НШШГГ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангаж ажиллана. | ажиллагааг хууль журмын дагуу биелүүлнэ. | | | | | төгрөгний хохирол барагдуулсан. | | | |
| | | 2021 онд С.Янжмаад 2,570,620, Г.Должинсүрэнд 70,000,000, Алтан дорны хүч ХХК-д 60.000.000, Лэндс ХХК-д 3,300,000, Б.Эрдэнэбаатарт 6,658,663, нийт 148,258,783 төгрөгийг барагдуулж шүүхийн шийдвэр биелүүлсэн. | | | | | | | | |
| 116 | | Эрх зүйн маргаантай асуудлаар хуулийн дагуу дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрыг төлөөлөх ажлыг зохион байгуулна. | 300.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | 100 гаруй хэрэг, маргаанд төлөөлөн оролцсон. | Байгууллагыг төлөөлөх ажлыг хуульд нийцүүлэн зохион байгуулсан байна. | ТЗУХ, ГА | 100% |
| | | 2021 онд нийт 52 хэрэг маргаанд байгууллагыг төлөөлөх ажлыг хуульд нийцүүлэн зохион байгуулсан байна. Дүүргийн төсвөөс үйл ажиллагааны хэрэгжилтэд зориулж хөрөнгө мөнгө зарцуулаагүй болно. | | | | | | | | |
| 117 | | Жагсаал, цуглаан, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах мэдэгдлийг бүртгэх ажлыг зохион байгуулж нийтийн хэв журам аюулгүй байдлыг хангана. | - | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | Жагсаал, цуглаан хийх 27 хүсэлт ирснээс 3 мэдэгдлийг бүртгэн авч, 24 мэдэгдэлд татгалзсан тухай хариуг хүргэсэн. | Жагсаал, цуглаан хийх мэдэгдэл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | ТЗУХ ГА | 100% |
| | | 2021 онд жагсаал, цуглаан хийх 27 мэдэгдэлд татгалзсан, 1 мэдэгдлийг бүртгэж, өлсгөлөн зарлах тухай 2 мэдэгдэлд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуг тус тус хүргэсэн. | | | | | | | | |
| 118 | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэв журмын урамшилтай | 513,280.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | Хэв журмын урамшилтай 80 эргүүл ажилласан. | Гэмт хэрэг зөрчил буурсан байна. | ТЗУХ, ЦГ, Хороод | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эргүүл ажиллуулж, эргүүлүүдийг чадваржуулах зорилгоор сургалтад хамруулна. | | | | | | | |
| | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль хүчингүй болж Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Хэв журмын урамшилтай эргүүл нь Олон нийтийн байцаагч гэсэн нэршилтэй болсон. Тус Олон нийтийн байцаагчийн ажиллах журам, урамшууллын асуудлыг ХЗДХЯ-ны сайдын тушаалыг үндэслэн НИХТ-ын тогтоол батлагдаж Хэв журмын урамшилтай эргүүл буюу Олон нийтийн байцаагч ажиллах эрх зүйн орчин үүсэхээр хуульчилсан. Иймд дээрх эрх бүхий байгууллагаас холбогдох тушаал, шийдвэр гарах хүртэл хугацаанд Хэв журмын урамшилтай эргүүл буюу Олон нийтийн байцаагч ажиллах боломжгүй байна.<br>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 26 хэв журмын урамшилт эргүүл өөрийн оршин суух нутаг дэвсгэрийн гудамж талбайд эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажиллуулсан.<br>Урамшилт эргүүлүүдээс ажиллах хугацаандаа “Халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлье”, “Халдварын эсрэг хамтдаа”, “Аюулгүй ажлын байр”, “Байгалиа хамгаалъя”, “Халдварын эсрэг хамтдаа” “Унадаг дугуй”, “Хүүхэд илрүүлэлт” аян, “Хяналт шалгалт”, “Байна уу байна”, “Ирээдүйгээ хамгаалъя” аян, “Үерийн аюулаас сэргийлье”, “Хичээл эхэллээ”, “Үерийн уснаас үрсээ хамгаалъя”, “Угаарын хийн хордлогод өртөхөөс хамгаалъя”, “Хяналт шалгалт”, Илрүүлэлт-3 зэрэг 24 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд алба хаагчидтай хамтран ажилласан ба урамшилт эргүүлүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хорооны Засаг дарга, хороо хариуцсан хэсгийн байцаагч, хороон цагдаа нараас хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллалаа.<br>Мөн эргүүлүүдээс Нийслэлийн Засаг даргын дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хариуцсан хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, Зөрчлийн тухай хууль зөрчсөн 34 зөрчлийг илрүүлэн хариуцсан хэсгийн байцаагч хороон цагдаа нарт хүлээлгэн өгч 39 иргэнийг 475000 төгрөгөөр торгож, 1 иргэнийг баривчлуулсан.<br>Мөн дэлхий нийтэд тархаж буй шинэ төрлийн коронавирусын халдвараас сэргийлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/57 дугаар тогтоолоор олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлж буй 64 хэсгийн ахлагч нар дүүргийн 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт ажилласан.<br>Харицсан нутаг дэвсгэрт гудамж талбайд 1862 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 187 хэргээр буюу 9,1 хувиар буурсан байна. | | | | | | | |
| 119 | | Хэв журмын урамшилтай эргүүлийн хэвийн ажиллахад шаардагдах ажлын хэрэгслээр хангана. | 6,400.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | Хэв журмын урамшилтай 80 эргүүлд ажлын хантааз, бусад хэрэгслэлээр хангасан. | Хэвийн ажиллах хэрэгслээр хангасан байна. | ТЗУХ | 0% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 120 | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль хүчингүй болж Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Хэв журмын урамшилтай эргүүл нь Олон нийтийн байцаагч гэсэн нэршилтэй болсон. Тус Олон нийтийн байцаагчийн ажиллах журам, урамшууллын асуудлыг ХЗДХЯ-ны сайдын тушаалыг үндэслэн НИХТ-ын тогтоол батлагдаж Хэв журмын урамшилтай эргүүл буюу Олон нийтийн байцаагч ажиллах эрх зүйн орчин үүсэхээр хуульчилсан. Иймд дээрх эрх бүхий байгууллагаас холбогдох тушаал, шийдвэр гарах хүртэл хугацаанд Хэв журмын урамшилтай эргүүл буюу Олон нийтийн байцаагч ажиллах боломжгүй байна. | | | | | | | | |
| 120 | 4.1.8 “Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлнэ. | "Төрийн албан хаагчдын сургалт" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 40,000.00 | Дүүргийн төсөв | Албан хаагчдыг 90 хувь хамруулсан байна. | Хувь | 90 хувь | 90 хувьд хүрсэн байна. | ТЗУХ | 100% |
| 120 | | Засаг даргын Тамгын газрын даргын 2021.05.11-ний өдрийн Хөтөлбөр батлах тухай А/54 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөр”-ийг 8 зүйлтэйгээр боловсруулж батлуулсан. Хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2021.05.12-ны өдөр батлуулж, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн ЗДТГ-аас хороодын албан хаагчдад зориулан Хууль, эрх зүйн мэдлэг олгох 2 удаагийн багц сургалтыг зохион байгуулж 120, “Эерэг харилцаа ба хандлага” сэдэвт багц сургалтад 150, НЗДТГ-ын 12 удаагийн сургалтад 75, ЗГ-ын ХЭГ-ын 1 удаагийн сургалтад 93, НАГ-ын 3 удаагийн сургалтад 5, ТАЗ-ийн 1 удаагийн сургалтад 2, Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, чиглүүлэх богино хугацааны сургалтад 9, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 2, дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулсан. Нийт давхардсан тоогоор 462 албан хаагч сургалтад хамрагдсан байна. | | | | | | | | |
| 121 | | "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 500,000.00 | Дүүргийн төсөв | Албан хаагчдыг 40 хувь хамруулсан байна. | Хувь | 20 хувь | 30 хувьд хүрсэн байна. | ТЗУХ | 100% |
| 121 | | Засаг даргын Тамгын газрын даргын 2021.05.11-ний өдрийн Хөтөлбөр батлах тухай А/54 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хөтөлбөр”-ийг 8 зүйлтэйгээр боловсруулж батлуулсан. Хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2021.05.12-ны өдөр батлуулж, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбогдуулан ажиллах нөхцөлийг хангах тавилга, техник хэрэгсэл шинэчлэх, шинээр авах ажлыг түр хугацаагаар зогсоосон. Байгууллагын Дотоод журмын дагуу 16 албан хаагчид 29,1 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 31 албан хаагчид нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж 183,0 сая төгрөгийн буцалтгүй тусламж, үр бүтээлтэй, идэвх санаачилгатай ажилласан 78 албан хаагчид үндсэн цалингийн 10-20 хувь, 1-3 сарын үндсэн цалингийн урамшуулал олгосон. | | | | | | | | |

<table>
<tr>
<td rowspan="2">122</td>
<td rowspan="2">4.1.9 Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлж, төрд байгаа мэдээллийн санд үндэслэн иргэндээ үйлчилнэ.</td>
<td>Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хувийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.</td>
<td></td>
<td></td>
<td>Төрийн үйлчилгээ түргэн шуурхай хүргэнэ.</td>
<td>ААН, иргэний тоо</td>
<td>2020 онд нийт 4000 гаруй ААН, иргэнд үйлчилж, худалдаа үйлчилгээ эрхлэх 1307 гэрээ байгуулан Батламж олгосон.</td>
<td>Аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний шат дамжлага багассан байна.</td>
<td>ХХҮХ</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td colspan="9">1. Ковид-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг дарга болон Улаанбаатар хотын Ерөнхий менежерээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасгаж, түргэн шуурхай үйлчлэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллах чиглэлээр дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа, үйлчилгээг Зөвлөлийн 2021.03.18-ны өдрийн хурлаар дараах шийдвэрт хүрсэн. Үүнд:<br>- Худалдаа, үйлчилгээ эрхлэх гэрээ “Батламж”-ийг 2 жилээр, Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээг 1 жилээр олгох<br>- Ажлын байрны Галын аюулгүй ажиллагааны дүгнэлтийг 2 жилээр олгох<br>- Худалдаа, үйлчилгээ эрхлэх 3-сан гэрээний сунгалтыг Ковид-19 цар тахал дуустал түр зогсоох<br>- Цагдаагийн байгууллагын камерийн тодорхойлолт олгох процессыг хялбаршуулах<br>- Бүрдүүлэх материал багасгах<br>- Батламж сунгах хүсэлтийг цахимаар авч, ажлын 1-3 хоногт шийдвэрлэх<br>- Батламж шинээр олгох хүсэлтийг цаасаар авч, ажлын 3-5 хоногт шийдвэрлэх<br>2. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулж, хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн, цахим хэрэглээг нэмэгдүүлж, худалдаа, үйлчилгээний байгууллагуудын мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP системд бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, үйлчилгээний байгууллагуудын бичиг баримтын зөрчлийг арилгуулж, хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Баримтаа цэгцэлье” аяныг 2021.10.28-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд зарлан, ААНБ-дад болон хороо, МХХ, ЦХ-дэд танилцуулга сургалтыг зохион байгуулж, бичиг баримтын загвар хавтас, гарын авлага материалаар ханган ажиллаж байна.<br>3. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг нийслэл хотын дүрмээр зохицуулж болно” гэсэн шинэ зохицуулалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хотын дүрмийн төсөлд оруулах саналыг НЗДТГ-т өгсөн.<br><br>1. Тайлангийн хугацаанд нийт 796 албан бичиг, 209 өргөдөл, 362 цахим хүсэлт хүлээн авч Худалдаа, үйлчилгээ эрхлэх гэрээ шинээр 365 байгуулж, 1193 Батламж олгоод байна.</td>
</tr>
<tr>
<td colspan="11">4.2 Архив, албан хэрэг хөтлөлт, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.</td>
</tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 123 | 4.2.1 Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж, түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэн ажиллана. | | | Нийслэлийн өргөдөл гомдлын дундаж түвшин | Хувь | | Нийслэлийн өргөдөл гомдлын дундаж түвшинд хүрсэн байна. | ТЗУХ | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар 2021 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл нийт 734 өргөдөл хүсэлт хүлээн авсан байна. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 647, судлагдаж байгаа 25 өргөдөл хүсэлт байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 6 өргөдөл хүсэлт байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 96,00 хувьтай байна.<br>Тодруулбал: E service 18, хороо бүртгэсэн 179, НҮНТ бүртгэсэн 17, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага бүртгэсэн 233, 1800-1200 дугаарын оператор бүртгэсэн 146, 11-11 төвөөс ирсэн 52, гар утасны аппликейшнээр 32, фейсбүүк хаягаар 1 өргөдөл хүсэлт тус тус хүлээн авсан байна.<br>Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл:<br>Ажлаас чөлөөлөгдөх тухай хүсэлт-46<br>Асран хамгаалагч тогтоолгох тухай -37<br>Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай-34<br>Хог цэвэрлэгээ тээвэрлэлтийн тухай-29<br>Архивын лавлагаа, мэдээллийн тухай-32<br>Бусад-500<br>2021 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 10 цаг 43 минут байна.<br>Дээрх хугацаанд явцын тэмдэглэл хөтлөөгүй, өдөрт нь багтаан хүлээж аваагүй гэх мэт 249 зөрчил бүртгэгдсэн байна.<br>Уг зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар албан хаагч бүрт өдөр тутамд сануулах болон утсаар, ERP програмаар, ажилтны гар урсаар дамжуулан мэдээлэл хүргэн ажиллаж байна.<br>UB ERP программын ашиглалтыг сайжруулах үүднээс дэргэдэх хэлтэс албадад өдөр тутамд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.Мөн албан хаагчдад өдөр тутамд ашиглах санамжийг хэвлэн гарын авлага болгон ашиглуулж хэвшээд байна.<br>2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, албан хэрэг хөтлөлт өргөдөл гомдлын системийн ашиглалт сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад төрийн өмчийн цэцэрлэг сургуулиудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчид хамрагдлаа.<br>2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хороодод шинээр томилогдсон албан хаагчдад Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, албан хэрэг хөтлөлт өргөдөл гомдлын системийн ашиглалт сэдэвт сургалтыг зохион байгууллаа. | | | | | | | | |
| 124 | | Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, нэгжүүдийн | | | Зөрчлийн тоо | Тоо | | Зөрчлийн тоон үзүүлэлт буурсан байна. | ТЗУХ | 100% |

<table>
<tr><td></td><td></td><td>өргөдөл, гомдлын нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулах, чадавхыг нэмэгдүүлнэ.</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="9">Сүхбаатар дүүргийн нийт байгууллага, хэлтэс нэгжийн хэмжээнд 2021 оны эхний 12 сарын байдлаар 3983 өргөдөл хүсэлт ирсэн байна.Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 3361, судлагдаж байгаа 156, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 60 өргөдөл хүсэлт байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 95,00 хувьтай байна.<br>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног 12 цаг 33 минут байна.<br>Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл:<br>1. Санхүү татварын тухай -1509<br>2. Архивын лавлагаа, мэдээллийн тухай-323<br>3. Ажлаас чөлөөлөгдөх тухай-92<br>4. Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай-83<br>5. Мэргэжлийн хяналтын салбарын үйл ажиллагааны тухай-72<br>6. Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүй-59<br>7. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай-47<br>8. Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн тухай-44<br>9. Газрын маргаантай асуудлыг шийдвэрлэх тухай-42<br>10. Бусад -1307 өргөдөл хүсэлт байна.<br><br>2021 оны эхний 12 сарын байдлаар өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, өдөрт нь багтаан шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон бусад 2466 зөрчил бүртгэгдсэн байна.<br>Зөрчил ихээр бүртгэгдсэн байгууллагуудыг нэрлэвэл:<br>1. Татварын хэлтэс-1127<br>2. Газар зохион байгуулалтын алба-294<br>Дээрх хэлтсүүдэд зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах Чиглэл хүргүүлэх тухай, Арга хэмжээ авч ажиллах тухай албан бичгүүдийг хүргүүлэн ажиллаж байна. Мөн өдөр тутамд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, албан хаагч бүрийн гар утас руу залган мэдээллээр ханган ажиллаж байна.<br>Зөрчил нь буурсан хэлтэс албадыг нэрлэвэл:<br>1. Улсын бүртгэлийн хэлтэс -64<br>2. Мэргэжлийн хяналтын хэлтэс-43<br>Өргөдөл гомдлын мэдээ тайланг улирал, сар болон тухай бүр гаргаж дээд шатны байгууллагад тайлагнан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажиллаж байгаа болно.</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дээрх хугацаанд 60 өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна. Тодруулбал:<br>1. Татварын хэлтэс-15<br>2. Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв-7<br>3. Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газар -7<br>4. Газар зохион байгуулалтын алба-5<br>5. Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 1-р хэлтэс-3<br>6. Сүхбаатар дэвшил ОНӨАТҮГ-1<br>7. Мэргэжлийн хяналтын хэлтэс -1<br>8. Улсын бүртгэлийн хэлтэс-1<br>9. Онцгой байдлын хэлтэс -1 өргөдөл хүсэлт байна.<br>Уг байгууллагуудад өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь бүрэн гүйцэд шийдвэрлэх мөн эдгээр албан хаагчдад хариуцлага тооцох тухай албан бичиг хүргүүлэн ажиллаж байна. | | | | | | | | |
| 125 | | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг тухай бүр гаргаж, удирдлагуудад танилцуулан шаардлагатай арга хэмжээ авч ажиллана. | | | Мэдээ, тайлан цаг хугацаандаа гарсан байна. | Чан ар | | Тоон болон чанарын үзүүлэлт сайжирсан байна. | ТЗУХ | 100% |
| | | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 1-р улирлын тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 3/382 дугаарын албан бичгээр, 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 2/786 дугаартай албан бичгээр өргөдөл гомдлын 2-р улирлын тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн, 3-р улирлын өргөдөл гомдлын тайлан мэдээг 2021.09.27-ны өдрийн 4-1349 дугаартай албан бичгээр зохих байгууллагад тус тус хүргүүлсэн болно. | | | | | | | | |
| 126 | 4.2.2 Төрийн архивын тусгай төрлийн баримтыг нэмэгдүүлэн цаасан баримтыг цахимжуулж, архивын баримтын хадгалалт, хамгаалалтын | Дүүргийн архивд хөмрөг үүсгэгч байгууллагын архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж стандартад | 5,000.00 | Дүүргийн төсөв | 1 Сургуулийн Архивын өрөөг тохижуулна. | Тоо | | Нэг ЕБС-ийн архивын өрөөг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулсан байна. | ТЗУХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нөхцөлийг сайжруулна. | нийцүүлэн, Төрийн архивын нэгдсэн системд дүүргийн архивд хөмрөг үүсгэгч байгууллагуудын захирамжлалын баримтаар цахим нөхөн бүрдүүлэлт хийнэ. | | | | | | | | |
| | | 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн дүүргийн Засаг даргын А/382, А/383 дугаар Ерөнхий боловсролын 6, 35 дугаар сургуулийн архивын хадгаламжийн санг шинэчлэн засварлах захирамжийн дагуу нийт 29,340,000 төгрөгөөр хадгаламжийн санг засварлан, нягтруулсан шүүгээ болон тоног төхөөрөмжийг авсан.<br>Засаг даргын Тамгын газрын 2020 оны Захирамжлалын баримт бичиг 11 хадгаламжийн нэгжийн 891 баримтын 2295 хуудас, Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн дагуу малын А дансны лавлагаа хуулбар их гарч байгаатай холбогдуулан 2003-2017 оны малын А данс 33 хадгаламжийн нэгжийн 2181 иргэдийн А дансыг скайнердан “Төрийн архивын нэгдсэн систем”-д цахимжуулсан. | | | | | | | | |
| 127 | 4.2.3 Дүүргийн хөмрөг үүсгэгч байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын хариуцлага бүтээмжийг нэмэгдүүлж, чадавхжуулна. | Дүүргийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сургалт, арга зүйн ажлын төлөвлөгөө гарган, мэргэшүүлэх сургалтад хамруулж, ном гарын авлагаар хангана. | 10,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна. | ТЗУХ | 100% |
| | | 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 1-20 дугаар хороодын засаг дарга нар болон шинээр томилогдсон хороодын засаг дарга нарт “Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд анхаарах зүйл” сэдэвт сургалт орсон. Мөн Засаг даргын Тамгын газрын Арга зүйч, архивч Р.Батцэцэг Архивын Ерөнхий газрын “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй” сэдэвт анхан шатны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын системийн ашиглалт” сэдэвт сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгууллаа. Дүүргийн харьяа төрийн өмчийн цэцэрлэг, сургуулиудын архив, албан хэрэг | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөтлөлт хариуцсан албан хаагчид архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын танилцуулга, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем, тоон гарын үсгийн хэрэглээ, өргөдөл гомдлын системийн ашиглалт, цахим нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлж, байгууллагын албан хаагчдыг зөвлөгөө мэдээллээр хангах юм. Сургалтыг баталсан хөтөлбөрийн дагуу 08 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулсан бөгөөд нийт 49 албан хаагч хамрагдсан. 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, MNS5140:2021 баримт бичгийн стандартаар Засаг даргын Тамгын газрын болон 1-20 дугаар хороодын албан хаагчдад сургалт зохион байгуулж нийт 65 албан хаагч хамрагдаж Тамгын газрын хэлтэс, тасаг 1-20 дугаар хороодын албан хаагчдыг “Баримт бичиг 5140-2021” стандартын 30 ширхэг номоор хангасан. Архивчдын өдрийг угтан 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр дүүргийн харьяа байгууллагуудын архив, бичиг хэрэг хариуцсан албан хаагчдад НЕБ-ын 6 дугаар сургуулийн архивыг түшиглэн үзүүлэх сургалт зохион байгуулж нийт 98 албан хаагч хамрагдсан. | | | | | | | | |
| 128 | | Дүүргийн архивын хөмрөг үүсгэгч байгууллагуудын дунд Болзолт уралдаан зохион байгуулан, “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийг дүүргийн хэмжээнд зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Ажлын үр дүн сайжирсан байна. | ТЗУХ | 100% |
| | | Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн “Төрийн архивын үйл ажиллагаанд улсын үзлэг зохион байгуулах тухай” А/173 дугаар тушаал гарсан. Төрийн архивын улсын үзлэгийн удирдамжийн дагуу бэлтгэл ажлыг хангаж ажилласан. 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/213 дугаар тушаалаар “Салбар архивын үйл ажиллагааны нийтлэг журам” батлагдсан тул дүүргүүдийн архивд улсын үзлэг ирээгүй. 2021 оны 11 дүгээр сарын 08-12-ны өдрүүдэд Нийслэлийн Архивын газарт улсын үзлэг явагдсан бөгөөд Баянгол, Налайх дүүргийн архивтай танилцсан.<br>Архивчдын өдрийг угтан 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр дүүргийн харьяа байгууллагуудын архив, бичиг хэрэг хариуцсан албан хаагчдад НЕБ-ын 6 дугаар сургуулийн архивыг түшиглэн үзүүлэх сургалт зохион байгуулж нийт 98 албан хаагч хамрагдсан байна. | | | | | | | | |
| 129 | 4.2.4 Мэдээллийн аюулгүй байдал, дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай арга | Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр windows лицензтэй үйлдлийн систем, вирусийн | 36,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Албан ёсны антивирусны програм ашигласан байна. | ТЗУХ | 100% |

<table>
<tr><td></td><td>хэмжээг авч хэрэгжүүлнэ.</td><td>лицензтэй программ, холбогдох тоног, төхөөрөмж, хэрэгслээр хангаж ажиллана.</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="9">Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43-р тогтоолд “... үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх ....” гэж заасны дагуу албан ёсны антивирусны программ, windows үйлдлийн систем худалдаж авах ажил хийгдээгүй. Одоогийн байдлаар trial хувилбараар ашиглаж байгаа болно.</td></tr>
<tr><td colspan="11">4.3 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.</td></tr>
<tr><td rowspan="2">130</td><td rowspan="2">4.3.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, ил тод байдлыг хангаж ажиллана.</td><td>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна.</td><td>5,000.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</td><td>Хувь</td><td>Хөтөлбөрийн хэрэгжилтийг 90 хувиас дээш хангуулсан.</td><td>95 хувьд хүрсэн байна.</td><td>ТЗУХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 03/726 дугаар албан бичгээр ирүүлсэн Төрийн байгууллагуудын 2021 оны Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах загварын дагуу байгууллагын “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 14 заалттайгаар боловсруулан батлуулж, холбогдох хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай А/312 дугаар захирамжаар Авлига, хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий дүүргийн Ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.<br>Дүүргийн Ажлын хэсэг “Авлига, хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулан 2021.09.28-ны өдөр баталсан.<br>Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, нэгж, Тамгын газар, сургууль, цэцэрлэгүүдэд хяналт шалгалт хийх 3 чиглэлийн Ажлын дэд хэсгийг байгуулан, удирдамж, хуваарийг боловсруулан батлуулсан. Үүнд:<br>1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх, шийдвэрлэлтэд хяналт шалгалт хийх Ажлын дэд хэсэг;<br>2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, мэдээллийн ил тод байдалд хяналт шалгалт хийх Ажлын дэд хэсэг;<br>3. Ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах Ажлын дэд хэсэг.<br>Ажлын дэд хэсгүүд батлагдсан хуваарийн дагуу дүүргийн Засаг даргын дэргэдэх 24 байгууллага, төрийн өмчийн 26 сургууль, 35 цэцэрлэгт 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хяналт шалгалтыг хийж эхэлсэн.<br>Батлагдсан хуваарийн дагуу дүүргийн 10 сургууль, цэцэрлэгт хяналт шалгалтыг хийж эхэлсэн. Хяналт шалгалтын дагуу сургууль, цэцэрлэгүүдэд илэрч буй байгууллага дээрээ ирсэн өргөдөл, гомдлыг erp.ulaanbaatar.mn нэгдсэн системд бүртгээгүй нийтлэг зөрчлийг арилгах зөвлөмж, үүрэг чиглэл өгч ажилласан.</td></tr>
</table>

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 131 | | Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана. | | | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Тоо | Мэдээлэл ил тод нээлттэй болсон. | Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт бүрэн байршуулсан байна. | ТЗУХ | 100% |
| | | Байгууллагын албан ёсны цахим хуудас болон мэдээллийн самбарт үйл ажиллагааны, төсөв санхүүгийн, хүний нөөцийн, худалдан авах ажиллагааны ил тод байдлын чиглэлээр холбогдох тайлан, мэдээ, судалгааг тухай бүр байршуулсан. Цахим хуудасны ил тод байдал цэсэд нийт 23 мэдээллийг байршуулсан байна. | | | | | | | |
| 132 | 4.3.2 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна. | "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангаж, Эрх зүйн хөтөч ажиллуулна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо, чанар, хугацаа | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах чиглэлээр тодорхой ажил хийсэн байна. | ТЗУХ | 100% |
| | | Дүүргийн Прокурорын газартай хамтран 202 оны 03 дугаар сарын 16-ны өдөр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн 20 хорооны Засаг даргад дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл өгч, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн талаар сургалт зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний хүрээлэнгээс 2021 оны 05 дугаар сард зохион байгуулсан Эрх зүйн хөтөч бэлтгэх цахим сургалтад 17 хорооны Нийгмийн ажилтан хамрагдаж, Эрх зүйн хөтчийн гэрчилгээ авсан. Одоогоор 20 хорооны Нийгмийн ажилтан 10000 гаруй иргэнд эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгсөн. 2021 оны хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, багш нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр 18 сургуулийн 60 багш, 30 цэцэрлэгийн арга зүйчийг “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах нь” сургалтад хамруулав. Дүүргийн Прокурорын газар, Цагдаагийн газартай хамтран сургууль, хорооны Нийгмийн ажилтан нарыг мэргэшүүлэх зорилгоор 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдөр “Өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, хүүхэд гэмт, хэрэг зөрчлийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад 29 Нийгмийн ажилтанг хамрууллаа. 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хороодын Засаг дарга болон зохион байгуулагч, нийгмийн ажилтнуудад МУЗЗНДН-ийн тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн талаар цахим болон танхимын сургалт хийсэн. | | | | | | | |
| 133 | | “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | 5 сургуулийн 400 сурагчдад сургалт зохион байгуулсан. | Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх иргэдийн | ТЗУХ, ЦГ, Сургалтын төв | 100% |

<table>
<tr><td></td><td></td><td>тэмцэх” үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангаж ажиллах хүрээнд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна.</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>мэдлэг дээшилсэн байна.</td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="9">Дүүргийн Прокурорын газартай хамтран 202 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр дүүргийн Ерөнхий боловсролын 45, 2 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад “Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодистой холбоотой зөрчил, гэмт хэргийн тухай ойлголт” сэдэвт сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулав. Сургалтад дунд, ахлах ангийн 90 хүүхэд хамрагдаж мэдээлэл авсан. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны Түр журам батлах тухай А/292, А/525 дугаар тушаалаар Коронавируст цар тахлын халдвартай холбогдуулан танхимын сургалт зохион байгуулах боломжгүй болсон учир дүүргийн бүх төрийн өмчийн ЕБ-ын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх хүүхдийн эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тайлан ирүүлэх тухай 1/1587 дугаар албан бичгийг сургуулийн удирдлагад хүргүүлсэн.<br>Цагдаагийн газар:<br>Цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт мансууруулах болон донтуулах үйлчилгээ бүхий ургамлын тархац байгаа эсэхэд мэргэжлийн хяналтын хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран тандалт судалгааг хийхэд 2021 оны 8-9 дүгээр сард Сүхбаатар дүүргийн 15, 18, 19, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Мансууруулах үйлчилгээтэй зэрлэг ургамлын тархац, байршил тогтоогдоогүй.<br>Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр иргэд олон нийтэд мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хуулийн хариуцлагын талаар тайлбарласан 550 ширхэг зурагт хуудсыг иргэд ихээр цуглардаг газруудад байршуулан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.<br>Дэлхий нийтэд нүүрлээд буй цар тахал Ковид-19 өвчний улмаас иргэд олон нийтэд биечлэн яриа таниулга зохион байгуулах боломжгүй тул урьдчилан сэргийлэх ажлыг цахимаар зохион байгуулж 6 төрлийн мэдээллийг тогтмол олон нийтэд хүргэж ажилласан.<br>Дүүргийн 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Эмийн сан” болон эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хяналт тавих чиглэлээр судалгааг нэгтгэж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 61 эмийн сан болон томоохон эм ханган нийлүүлэх байгууллагууд болох Ази-Фарм, Евро-Фарм зэрэг байгууллагуудад хяналт тогтоож ажиллахад зөрчил, дутагдал илрээгүй.<br>Тайлант хугацаанд Дүүргийн засаг даргын Тамгын газар, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн байж болзошгүй сэжигтэй этгээд 28, сэжигтэй байр байгууламж 4-ийг тогтоож судалгаа бүртгэлд авч зөрчлийн тухай хуульд зааснаар шүүхэд санал хүргүүлж хариуцлага тооцуулсан.<br>Хяналт шалгалтаар залуучууд, өсвөр насны хүмүүсээс сэтгэцэд нөлөөлөх бодис болох газ, цавуу, гутлын тос, будаг зэргийг үнэртэж мансуурах, хорт зуршлаас болж амь нас, эрүүл мэндээрээ хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт өсвөр насны хүүхэд ихээр цуглардаг Өргөө-2 кинотеатр, Соёлын төв өргөө, Үндэсний соёл амралтын</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүрээлэн зэрэг үзвэр үйлчилгээний газар, интернет тоглоомын газар 32, гудамж талбай, орц, хонгил зэрэг 53 цэгт тогтмол эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулсан.<br>Хараа хяналтгүй, орон гэргүй, тодорхой оршин суух хаяггүй зорилтод бүлгийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдож болзошгүй насанд хүрээгүй 12 иргэний судалгааг шинэчлэн гаргаж Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газарт 2021 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлсэн.<br>Мөн насанд хүрээгүй иргэдэд ахуйн хэрэглээний хийн газ худалдан борлуулахгүй байх талаар албан мэдэгдлийг 162 аж ахуйн нэгжид хүргүүлж хариуг бүрэн авсан.<br>Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ИТХ-ын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг илрүүлэх түргэвчилсэн 500 ширхэг сорилыг шийдвэрлүүлэн цагдаагийн хэлтсүүдийн жижүүрийн шуурхай удирдлагын тасагт байршуулснаар энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд дэмжлэг болсон. | | | | | | | | |
| 134 | | "Хүн худалдаалахтай тэмцэх" үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангаж ажиллах хүрээнд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Тоо | 5 сургуулийн 400 сурагчдад нарт сургалт зохион байгуулсан. | Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх иргэдийн мэдлэг дээшилсэн байна. | ТЗУХ, ЦГ, Сургалтын төв | 100% |
| | | Дүүргийн Прокурорын газартай хамтран 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр дүүргийн Ерөнхий боловсролын 45, 2 дугаар сургуулийн ахлах, дунд ангийн 98 хүүхдэд "Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт" сэдэвт сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх түүнээс урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл өгсөн. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны Түр журам батлах тухай А/292, А/525 дугаар тушаалаар Коронавируст цар тахлын халдвартай холбогдуулан танхимын сургалт зохион байгуулах боломжгүй болсон учир дүүргийн бүх төрийн өмчийн ЕБ-ын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх хүүхдийн эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тайлан ирүүлэх тухай 1/1587 дугаар албан бичгийг сургуулийн удирдлагад хүргүүлсэн. | | | | | | | | |
| 135 | | "Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангаж ажиллана. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | 79 иргэн, 30 албан хаагч нарт сургалт зохион байгуулсан. | Жэндерийн хэвшмэл ойлголтын талаар албан хаагч, иргэдэд мэдээлэл хүргэсэн байна. | ТЗУХ, ЦГ, Сургалтын төв | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 136 | | 2021 оны хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан 08 дугаар сард “Сургууль, цэцэрлэгийн орчин дэх хүүхдийн Эрхийг хамгаалах нь” сургалтад танхимаар 18 сургуулийн 60 гаруй багш, цахимаар 30 цэцэрлэгийн арга зүйч нарын хамруулав. Сургалтаар Хууль зүйн тасгийн дарга П.Булганмаа жендэрт суурилсан ялгаварлан гадуурхал чиглэлээр мэдээлэл өгсөн. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Жендэрийн дэд хөтөлбөрт үнэлгээ хийх ажил зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын А/288 дугаар захирамж гаргаж, Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуультай хамтран Жендэрийн хөтөлбөрт үнэлгээ хийхээр 4 сая төгрөгний төсөвтэй гэрээг 08 дугаар сарын 24-ны өдөр байгуулсан. Гэрээгээр Жендэрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн, тулгамдаад байгаа асуудал, цаашид анхаарвал зохих зүйлсийг тодруулж, гэрээний гүйцэтгэлийн тайланг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авч, 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Жендэрийн салбар хороог хуралдуулан дүүргийн Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлсэн. Хөндлөнгийн байгууллагын үнэлгээгээр Дэд хөтөлбөрийн биелэлт 90 хувьтай хэрэгжсэн бөгөөд цаашид нэг ажил 2022 онд үргэлжлэн хэрэгжинэ. 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дэд хөтөлбөрийн хугацаа дуусч байгаа бөгөөд нийслэл дэх дэд хөтөлбөрийн гүйцэтгэлийг үнэлэх хөндлөнгийн үнэлгээний тайлан нэгтгэгдсэнээр 2022 оны төлөвлөгөөнд өөрчлөлт орох болно. | | | | | | | | |
| 136 | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрх зүйн соёл түгээх чиглэлээр 2021-2024 онд шинээр батлагдсан үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | 2021-2024 онд шинээр батлагдсан хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн байна. | ТЗУХ | 0% |
| | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрх зүйн соёл түгээх чиглэлээр 2021-2024 онд шинээр үндэсний болон дэд хөтөлбөр батлагдаагүй. | | | | | | | | |
| 137 | 4.3.3 Нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд холбогдох хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, нэгж хоорондын уялдааг хангуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний тайлангийн | | | ЗГХЭГ-ын даргын 47 дугаар тушаалаар батлагдсан загвар хүснэгтийн дагуу байгууллагын гүйцэтгэлийн | Чан ар | | Төлөвлөгөө боловсруулагдаж, тайлан баталгаажсан байна. | ТЗУХ, Бүх хэлтэс нэгж | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангуулж, нэгтгэн тайлагнана. | хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | | | төлөвлөгөө боловсруулагдсан байна. | | | | | |
| | | Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтэс, нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулж, төсвийн шууд захирагчаар батлуулсан. Байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө жилээр батлагдаж, тайлан хагас жил, жилийн эцсээр гаргах тухай ЗГ-ын 100 дугаар тогтоолд тусгагдсаны дагуу хагас жилээр гүйцэтгэлийн тайланг нэгтгэн гаргаж ТГХШХ-т хяналт, шинжилгээ хийлгүүлсэн. Жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг хэлтэс, нэгжүүдээс авч нэгтгэж байна. | | | | | | | | |
| 138 | 4.3.4 Татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар хураалтыг нэмэгдүүлнэ. | Улс болон орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллана. | 6,500.00 | Дүүргийн төсөв | Гүйцэтгэлээр | Хувь | 77.7% | 100 хувийн гүйцэтгэлд хүргэж ажилласан байна. | ТХ | 100% |
| | | 2021 онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр<br>Улсын төсөвт 109,891,787 мянган төгрөг төвлөрүүлэхээс 106,797,152.0 мянган төгрөг төвлөрүүлж 97.2 хувь,<br>Нийслэлийн төсөвт 85,062,353.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 72,142,921.1 мянган төгрөг төвлөрүүлж 84.8 хувь,<br>Дүүргийн төсөвт 79,406,442.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 75,484,413.3 мянган төгрөг төвлөрүүлж 95.1 хувь,<br>3 төсвийн нийлбэр дүнгээр 274,360,582.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 254,424,486.3 мянган төгрөг төвлөрүүлж 92.7 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. | | | | | | | | |
| 139 | | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар болон галт зэвсгийн албан татварыг төсөвт төвлөрүүлэх, Бүртгэлтэй хөрөнгийг татварт бүрэн хамруулах, өр барагдуулах ажлыг зохион байгуулна. | 2,000.00 | Дүүргийн төсөв | Гүйцэтгэлээр | Хувь | 52.7% | Татвар төлөгчийн тоо нэмэгдэж, төлөвлөгөөг 100 хувьд хүргэнэ. | ТХ | 100% |
| | | 2021 оны жилийн эцсийн байдлаар аж ахуйн нэгж иргэний 220 үл хөдлөх эд хөрөнгөд 1,220,339.0 мянган төгрөгийн ноггдол шинээр үүсгэн ажилласан. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хөрөнгийн бүртгэлийн өөрчлөлт болон хасалт хийлгэх иргэн аж ахуйн нэгжийн 109 хүсэлтийг хүлээн авч журмын дагуу шийдвэрлэн ажиллаж байна<br>ХЭҮХЭХАТ-ын 2021 онд 24,231,290.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 20,108,161.0 мянган төгрөг төвлөрүүлж 92 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Галт зэвсэгийн албан татварын төрлөөр 45,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 57,381.0 мянган төгрөг төвлөрүүлж 151.20% хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. /2021-11-19-ны байдлаар/<br>Иргэн, хуулийн этгээдийн ашиглагдахгүй байгаа боловч ТУНС бүртэгэлтэй бүртгэлээс хасагдаагүй урд онуудад татварын өр үүссэн **38** галт зэсвсэгийн бүртгэлийг шалган 1,546,764 /мян.төг/ төсөвт төвлөрүүлэн ажилласан байна. ТУНС-ийн тооцооллын үлдэгдэл зөрүүтэй алдаатай **12** ААНэгж байгууллага, **25** Иргэний тооцооллыг үлдэгдэлийг ТЕГ-тай хамтран засварлаж шийдвэрлэн ажилласан байна. | | | | | | | | |
| 140 | | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг барагдуулах ажлыг зохион байгуулна. | 2,000.00 | Дүүргийн төсөв | Гүйцэтгэлээр | Хувь | 34.3% | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 100 хувьд хүргэсэн байна. | ТХ | 100% |
| | | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/65 тушаалаар Короновируст халдвар /ковид 19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн Газраас айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөх хэрэглээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй жишиж, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг одоо батлагдсан тарифт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар тус тус тооцож, гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулах харилцааг зохицуулах журмыг даган мөрдөн ажиллаж байна<br>2021 онд 1,800,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр. 2,357,100.6 мянган төгрөгийг төвлөрүүлж 130.9 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. | | | | | | | | |
| 141 | | Газрын төлбөрийг хураан барагдуулах, татвар төлөгчдөд сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулна. | 4,000.00 | Дүүргийн төсөв | Гүйцэтгэлээр | Хувь | 44.5% | Татвар төлөгчдийн хуулийн мэдлэг дээшилсэн байна. | ТХ | 100% |
| | | 2021 онд газрын төлбөрөөр 29489, газрын төлбөр-дэд алба төрлөөр 28840, нийт 29498 татвар төлөгчийн 4,514,225.0 мянган төгрөгийн ногдол үүссэнээс 2021 оны 11 дүгээр сарын 19-ний байдлаар 16838 татвар төлөгчийн 3,028,818.2 мянган төгрөгийн барагдуулалттай 78,1 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Урьд оны өртэй 59 татвар төлөгчийн 25.6 сая төгрөгийн орлогыг залруулж шивсэн.<br>Газрын төлбөрийн дутуу үлдэгдлийг хураан барагдуулах зорилгоор 6197 татвар төлөгчийн 2,530,448.0 мянган төгрөгийн өрд нэхэмжлэх хүргүүлж ажилласан. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТУНС-д 184 иргэнийг газрын төлбөр-дүүргийн төвлөрсөн, газрын төлбөр-дэд алба төрлөөр тус тус давхар бүртгэсэн байсныг засварлуулсан.<br>Газрын төлбөрийн төрлөөр 1000,000 төгрөгөөс дээш өртэй 57 татвар төлөгчийн 426,458,553 төгрөгийн өрөнд нэхэмжлэх хуудас хүргүүлж 187,369,733 төгрөгийг барагдуулсан<br>Хуулийн хугацаанд төлбөрийг төлж барагдуулаагүй тохиолдолд Газрын төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Газрын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг үүгээр мэдэгдэж байна гэсэн утгатай албан бичиг хүргүүлж ажилласан.<br>Газрын төлбөрийн дутуу үлдэгдлийг хураан барагдуулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад масс мессеж хүргүүлэн ажиллаж байна. | | | | | | | | |
| 142 | | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 4,500.00 | Дүүргийн төсөв | Гүйцэтгэлээр | Хувь | 74.5% | Татвар төлөгчдийн хуулийн мэдлэг дээшилсэн байна. | ТХ | 100% |
| | | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5.2 болон 6.5-д заасны дагуу албан татвар суутган төлөгчөөр 460 хуулийн этгээдийг шинээр бүртгэсэн. Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн даргын 2021 оны 1 дүгээр сарын 29-ны А/05 тоот тушаалаар 12 сар албан татварын тайлангаар Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээнд хүрээгүй нь Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газрын тооцож ирүүлсэн жагсаалтаар 276 татвар төлөгчийг төрлөөс хассан.<br>Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой дараах чиглэлийн цахим заавар, танилцуулгыг Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн фэйсбүүк болон пэйж хуудсаар олон нийтэд хүргэж ажилласан.<br>**1.**Шинээр НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдсэн татвар төлөгчдөд зориулсан сургалт,<br>**2.**Цахим төлбөрийн баримтын системд хойшлогдсон худалдан авалтын падаан үүсгэх заавар,<br>**3.**Сугалааны хонжвор буцаагдсан бол ибаримт аппликейшнаар хэрхэн хүсэлт гаргах заавар,<br>**4**.Монголын татварын албанаас худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэгчдэд цахим төлбөрийн #ебаримт олгох хялбар шийдлийг нэвтрүүлсэн танилцуулга,<br>**5.**НӨАТ-ын хуулийн дагуу и-баримтыг үүсгэхдээ худалдан авагч болон худалдаа, үйлчилгээ эрхэлэгчиддээ чирэгдэлгүйгээр үүсгэх технологийн шийдлийг танилцуулж ажилласан.<br>**Нийслэл хотын албан татвар**<br>“*Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулах” зорилт, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/50 дугаар захирамжийн хүрээнд “Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн систем”-д нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийг бүрэн хамруулж* Нийслэл болон Дүүргийн Хүнс, | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Худалдаа үйлчилгээний хэлтсээс үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан **2569** газрыг бүртгэлд хамруулахаас **2535** газрыг бүртгэж **98.6%** гүйцэтгэлтэй ажилласан. **35** газар нь үйл ажиллагаа явуулахгүй зогссон тул бүртгэлд хамруулаагүй байна.<br>https://erp.ulaanbaatar.mn/home системд Нийслэл хотын албан татварын төрлөөр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 20 төрлийн худалдаа үйлчилгээний газрыг бүртгэлд хамруулж ажилласан.<br>Худалдаа, хоол үйлдвэрлэл, аялал жуулчлал, ахуйн үйлчилгээ, авто үйлчилгээ, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хороонуудад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг нэг бүрчлэн хороо тус бүрээр нь erp.ulaanbaatar.mn програмд бүртгэлийг үүсгэж ажиллалаа.<br>НХАТ-ын төрлөөр 74 хуулийн этгээдийг шинээр бүртгэсэн байна.<br>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна. | | | | | | | |
| 143 | | Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | 2,000.00 | Дүүргийн төсөв | Гүйцэтгэлээр | Хувь | 50% | QR код бүхий наалтыг наан байршуулах ажлыг 100 хувийн гүйцэтгэлд хүргэсэн байна. | ТХ | 100% |
| | | Татварын үйлчилгээг 100 хувь цахимд шилжүүлсэнтэй холбоотой Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн фэйсбүүк хуудсанд хандсан 3105 иргэнд татварын зөвлөгөө өгч ажилласан бөгөөд Үүнээс 166 иргэнд хувийн ибаримтын нэвтрэх нэр код, 87 иргэнд хувиараа бизнес эрхлэгчийн код, 91 татвар төлөгчийн тоон гарын үсэг нууц код, 113 татвар төлөгчид цахим төлбөрийн баримтын системд нэвтрэх кодыг олгож ажилласан байна.<br>МУ-ын шадар сайдын 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран зах худалдааны төвүүдэд хамтарсан шалгалтыг 2021 оны 04 сарын 28-ны өдрөөс 2021 оны 06 сарын 01 өдрүүдэд гүйцэтгэж ажилласан.<br>Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор 2021 оны 6 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Номын баяр-2021” үзэсгэлэн худалдаанд ТЕГ-ын НӨАТХ, НТГ, Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс, хамтран хяналт тавин ажиллаж үзэсгэлэн худалдаанд оролцсон 219 иргэн, хуулийн этгээдийн бүртгэл хийж, шинээр 17 иргэнийг татвар төлөгчөөр бүртгэж, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвөөр 195 иргэн, хуулийн этгээдийн QR код үүсгүүлж, 197 хэрэглэгчийг Ebarimt системд холбож, 153 татвар төлөгчдөд QR наалт хэвлэн татвар төлөгчдийн асарт байршуулсан. Нийт QR код үүсгэсэн тоо 803, шинээр төлбөрийн системд холбогдсон тоо 680, холболтын хувь 84.68, цахим төлбөрийн баримт олгож байгаа тоо 422, и баримт олголтын хувь 62.1. байна.<br>Татварын ерөнхий газраас ирүүлсэн 100 айлд, барилгын материалын худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн 40 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр 10 багт хуваан Сүхбаатар дүүргийн 10, 11, 12 дугаар хорооны нутаг | | | | | | | |

<table>
<tr><td>144</td><td></td><td colspan="9">дэвсгэр, 100 айлд барилгын материалын худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах, Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон татварын бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, татвар төлөгчдөд холбогдох зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангах, татварын хууль тогтоомжийн зөрчсөн үйлдлийг илрүүлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, хуульд заасан хариуцлага тооцох, хуулийн хэрэгжилтийг хангуулж, зохион байгуулж ажиллалаа. Тус ажлын хүрээнд нийт 782 татвар төлөгч хамрагдсан бөгөөд нийт татвар төлөгчийн 57 хувь нь иргэн, 43 хувь нь хуулийн этгээд байна. Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд татвар төлөгчөөр бүртгэлтэй эсэхийг шалгаж үзэхэд нийт татвар төлөгчийн 93 хувь нь бүртгэлтэй 7 хувь буюу 56 татвар төлөгч бүртгэлгүй байна. Төлбөрийн баримт олгож буй эсэхийг шалгаж үзэхэд 75.5 хувь буюу 595 татвар төлөгч олгодог гэх судалгаа гарсан байна. Гадаад иргэн ажилдаг 18 татвар төлөгч байна. Татварын улсын байцаагчийн мэдэгдлийг 149 татвар төлөгчид гардуулсан байна. Татварын улсын байцаагч татварын хуулийн хэрэгжилтэд хяналт хийх явцад зөрчлийн шинжтэй үйлдэл илрүүлж, татварын хууль зөрчсөн татвар төлөгчид Татварын ерөнхий хуульд заасан “Шаардах хуудас”-ыг 22 татвар төлөгчид гардуулан ажиллалаа.</td></tr>
<tr><td rowspan="2">144</td><td rowspan="2"></td><td>Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Авто зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөрийг холбогдох газруудтай хамтран төвлөрүүлэн ажиллана.</td><td>6,500.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Гүйцэтгэлээр</td><td>Хувь</td><td>89.5%</td><td>1. АТБӨЯХАТ, АБТөлбөр, АЗАТөлбөрийгн төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна. 2.Тээврийн хэрэгслүүдийг татварт 100 хувь хамруулсан байна.</td><td>ТХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">ТЕГ-ын даргын  2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/21 тушаалаар Улсын хэмжээнд автотээврийн хэрэгсэл эзэмшигч, татвар төлөгчийг албан татварт хамруулах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг хураах ажлыг зохион байгуулах ажлын удирдамж, Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/60 Захирамж, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/11 тушаалаар АТБӨЯХАТ, Агаарын бохирдлын төлбөр, Авто зам ашигласны төлбөр  хураах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулан Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, хуулийн хугацаанд улс, орон нутгийн төсөвт татвар, төлбөрийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын төрлөөр 5,543,040.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 5,584,738.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж 100.71 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.<br>Тээврийн хэрэгслийн албан татвар, төлбөрөө төлөөгүй хяналтын үзлэгийн хүрээнд Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн даргын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 04/2821 тоот албан бичгээр тус дүүрэгт бүртгэлтэй боловч автотээврийн хэрэгсэл, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр төлөөгүй татвар төлөгчийн судалгааг бэлтгэн Сүхбаатар дүүргийн хороодын засаг даргад хүргүүлж хамтран ажиллалаа.</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хороодод хүргүүлсэн судалгааны дагуу албан татвар, төлбөрөө төлөөгүй Хувь хүн, хуулийн этгээдийн ашиглагдахгүй байгаа, улсын бүртгэлээс хасагдаагүй урд онуудад татварын өр үүссэн **8** тээврийн хэрэгслийн 5,125.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.<br>Мөн байгалийн давтагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюул ослоос шалтгаалан эвдэрч цаашид ашиглах боломжгүй болсон тээврийн хэрэгслийн АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ-ийг хэрхэн төлөх талаар зөвлөгөө мэдээллийг өгөн ажилласан<br>Албан татвар, төлбөрөө хуулийн хугацаандаа төлөөгүй татвар төлөгчдөд чиглэсэн 3 үе шатны хяналт шалгалт хийж нийт 1441 тээврийн хэрэгслийн гэрчилгээг хураарж албан татвар, төлбөрийг төлүүлэн гэрчилгээг татвар төлөгчид буцаан олгон ажиллаж байна. АТБӨЯХАТ-ын төрлөөр 69,944.0 мянган төгрөг, Авто зам ашигласны төлбөр 29,140.7 мянган төгрөг, Агаарын бохирдлын төлбөрөөр 2,110.4 мянган төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.<br>ЦАХИМААР ТӨЛЖ ЦАГАА ХЭМНЭЕ нэртэй постерийг хэлтсийн фэйсбүүк пэйж хуудсанд 3 удаагийн давтамжтай 312 шэйр хийн байршуулж тээврийн хэрэгслийн татварын төлөх 8 төрлийн боломжоос өөрт хялбар аргаар сонгож үйлчлүүлэхийг уриалж ажилласан бөгөөд ebarimt аппликейшнд автомашины төлбөрийн мэдээлэл очихоос гадна масс мессежийг төлөгдөөгүй тээврийн хэрэгсэл бүрт хүргэж ажилласан. | | | | | | | | |
| 145 | | “Татвар төлөгчийн өдрүүд” -ийг зохион байгуулах болон татварын хууль, тогтоомжийг сурталчлах, сургалт сурталчилгаа хийх, татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна. | 18,000.00 | Дүүргийн төсөв | Гүйцэтгэлээр | Хувь | 100% | Татвар төлөгч болон шинэ татвар төлөгч нарт сегментээр, татвар төлөгчийн салбарын ангиллаар нь системтэй сургалтыг явуулсан байна. | ТХ | 100% |
| | | Татварын ерөнхий газрын даргын 2021.04.21-ний өдрийн А/43 тоот "Татвар төлөгчдийн өдрийг зохион байгуулах тухай" тушаалын дагуу хэлтсийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан. Тус өдрүүдийг угтаж ТЕГ-аас зохион байгуулсан гар зураг, зохион бичлэг, тик ток уралдааны удирдамжийг харъяа ЕБ-ын 16 сургуульд хүргүүлж, facebook хуудсанд байршуулж ажилласан.<br>"Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ" 14 дэх удаагийн оюутны цахим тэмцээний удирдамжийг 32 их дээд коллеж болон сургалтын төвүүдэд хүргүүлэн уралдаан хэлэлцүүлэгт идэвхтэй оролцуулж Сүхбаатар дүүргээс шилдгүүд тодорсон. 2021 оныг Татварын боловсрол олгох жил болгон зарласантай холбогдуулан сегмент бүрт тохирсон 17 удаагийн цахим сургалтыг /zoom meeting/ зохион байгуулж 650 татвар төлөгчдийг хамруулсан.Тус хэлтэс татвар төлөгчдийн өдрүүдээр олны танил иргэдтэй хамтран ажиллаж “Таны төлсөн татвар тахлыг давах дэм” уриатайгаар видео 3 шторк хийж facebook хуудсаар сурталчилж boost хийж 67,300 үзэлтийн хандалт авч, 215 удаагийн шэйр хийсэн байна.<br>ТЕГ-аас ирүүлсэн видео хичээлүүдийг фэйсбүүк хуудсаар түгээж 3478 хандалттайгаар татвар төлөгчидэд мэдээлэл түгээж ажилласан байна. Жижиг сегментийн татвар төлөгч нарт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчлэл | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | болон татварын хувь хэмжээ, тайлагнах хугацаа, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 22.1-д заасан хөнгөлөлт, Буцаан олголтыг татвар төлөгч талаас, татварын албанаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон анхаарах зүйлсийн талаар мэдээлэл хүргэж, татвар төлөгчөөс ирүүлсэн асуултанд хариулт өгч 3 удаагийн сургалтаар 156 татвар төлөгчдийг хамруулсан. Ирээдүйн татвар төлөгч нар болох ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан “Татвар бидний амьдралд” сэдэвт цахим сургалтыг татварын хяналт шалгалтын тасгаас дүүргийн харъяа 8 дунд сургуулийн 272 сурагчийг хамруулсан байна.<br>Мөн хотын төвд байрлах Bloombeg Tv-ийн дэлгэц, Blue sky tower-ийн хажууд байрлах Нийслэл дэлгэц, Улсын их дэлгүүрийн урд байрлах төв дэлгэцүүдэд сурталгааны самбарт 5 өдрийн турш тус тус 80 удаагийн дамтамжтай сурталчилгаа байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас /өдрийн сонин, www.in-mongolia.mn , www.times.mn ...г.м/ашиглан олон нийтэд татварын талаар сурталчлан, таниулах арга хэмжээг зохион байгуулж, Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс facebook хуудсаар 86 удаагийн мэдээ, мэдээлэл, Татвар ерөнхий газраас ирүүлсэн цахим сургалтын видео хичээлүүдийг тус тус 2 удаа буюу нийтдээ 4 удаа оруулж, 312 удаагийн шэйр, 133 сэтгэгдэлд хариу өгч, чатаар ирсэн 312 асуултад хариулт өгч ажилласан байна.<br>Мөн Сүхбаатар дүүргийн Фэйсбүүк пэйжид 199 пост оруулж, ковид-19 цар тахалтай холбоотой 52 мэдээ мэдээлэл түгээж, чатаар нийт 286 татвар төлөгчдөд зөвөлгөө өгч ажилласан байна.<br>1800-1288 тусгай дугаараар 11785 татвар төлөгчдөд, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн 7011-2092, 7011-5670 утсаар 39372 татвар төлөгчдөд зөвлөгөө мэдээлэл өгөн ажилласан. | | | | | | | | |
| 146 | | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвар төлөгч хувь хүний тайлан, татварын хөнгөлөлт эдлүүлэх тайлан, бичиг баримтыг цахим татварын системээр хүлээн авах ажлыг зохион байгуулна. | 4,000.00 | Дүүргийн төсөв | Гүйцэтгэлээр | Хувь | 100% | Хуулийн хэрэгжилтийг ханган, 100 хувь хамруулсан байна. | ТХ | 100% |
| | | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах татвар төлөгч иргэдийн тайланг цахим татварын системээр хүлээн авах албан татвар төлөгчийн татварын хөнгөлөлт эдлэхээр ирүүлсэн тайлан, бичиг баримтыг хянаж хүлээн авах буцаан олгох албан татварын хэмжээг баталгаажуулах ажлыг зохион байгуулах Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/02 тушаалаар ажлын хэсгийг 20 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажилласан. Хөнгөлөлтийн тайланг цахимаар 2375 татвар төлөгч иргэдээс хүлээн авч 2197 тайланг шалган баталгаажуулан 1,798,048.0 мянган төгрөг буцаан олгож 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Нийслэлийн татварын газраас ирүүлсэн дансны мэдээлэл зөрүүтэй 68 иргэний банк болон дансны мэдээллийг залруулж Нийслэлийн татварын газарт хугацаанд нь хүргүүлсэн. Мөн хөнгөлөлтийн тайлангаа алдаатай илгээсэн буцаан олголтын мөнгө ороогүй шалтгаантай 49 иргэний нэгтгэлтийг Нийслэлийн татварын газар хүргүүлж 52,160.7 мянган төгрөгийг Төрийн санруу хүргүүлэн ажилласан. Хувь хүний орлогын албан | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | татварын 2020 оны тайланг цахимаар хүлээж авахтай холбогдон нийт 2 удаагийн цахим сургалтыг Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн фэйсбүүк хуудсанд байршуулж олон нийтэд түгээн ажилласан. Хувь хүний орлогын албан татварын тайланг хүлээн авах хороо хариуцсан байцаагчтай холбоо барих утасны дугаар мэдээллийг фэйсбүүк болон пэйж хуудсанд байршуулан цахимаар мэдээлэл зөвлөгөө өгөн ажилласан. | | | | | | | |
| 147 | 4.3.5 Ажил олгогч, даатгуулагчдад чиглэсэн сургалт зохион байгуулна. | Ажил олгогч, даатгуулагчдад чиглэсэн нийгмийн даатгалын хууль тогтоомж дагаж гарсан заавар журмын талаар сургалт зохион байгуулна. | 6,000.00 | Дүүргийн төсөв | 400-гаас дээш ААНБ хамруулна. | Тоо, Хувиар | 2019 онд 400 ААНБ хамруулсан | Идэвхтэй 6 мянга гаруй ажил олгогч, 140 мянган даатгуулагчдад хуулийн хэрэгжилтийг сурталчлан ажилласан байна. | НДХ | 100% |
| | | Хэлтсийн харилцагч аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодогчдод зориулсан “Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ; 2021 онд мөрдөх Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, холбогдох асуудлууд; Тоон гарын үсгээр тайлан илгээх” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан. Үүнд 553 аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодогчид идэвхтэй оролцож тулгамдаж буй асуултандаа хариулт авсан болно. Мөн Ниигмиин даатгалын сангаас олгох үилдвэрлэлиин осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнии тэтгэвэр, тэтгэмж, төлбөриин тухаи хуулиин 17 дугаар зүил, НДҮЗ-н 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Үилдвэрлэлиин осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргиилэх арга хэмжээнии зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу арга хэмжээ зохион байгуулж сургалт явуулах эрх бүхий байгууллага сонгон шалгаруулан, тус сонгон шалгаруултад "Монголын ЦАХИМ институт" ТББ шалгарч, тус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулж ажилласан. | | | | | | | |
| 148 | 4.3.6 Дүүргийн иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэнэ. | Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний ойн баярын үйл ажиллагаа, генерал цолтонд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | Дүүргийн иргэд, генерал цолтнуудыг бүрэн хамааруулна. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Дүүргийн иргэдэд цэрэг эх оронч хүмүүжил олгох, Батлан хамгаалах салбарыг сурталчилсан байна. | ЦШ, ТЗУХ, НХХ, Хороод | 100% |
| | | Монгол Улсад хурандаа цол олгож эхэлсний 40 жилийн ойг тохиолдуулан Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас чөлөөнд гарсан бэлтгэл 3 хурандааг 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Дүүргийн удирдлагууд хүлээн авч хүндэтгэл үзүүлэн хурандаа нарыг “Алдаршуулж” гарын бэлэг, мөнгөн шагнал гардуулсан. Мөн Олон Улсын Аавуудын өдрийг тохиолдуулан ЗХ-ний 311 дүгээр ангийн байлдагч Н.Дашчойлонг эхнэр хүүхэдтэй нь уулзуулсан бол, 186 дугаар ангийн байлдагч Б.Тэлмэнг цахимаар ар гэрийхэнтэй нь үүлзуулж гарын бэлэг, дурсгалын зүйл гардууллаа. | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 149 | | Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, аж ахуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт явуулна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | Дүүргийн иргэд, 12 ААНБ хамруулна. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй болсон байна. | ЦШ, Хороод, ААНБ | 100% |
| | | дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Жин туул”, “Өгөөж-чихэр боов”, “ЕБ-ын 6 дугаар дунд сургууль” 3 аж ахуй нэгж байгууллагын 18-50 насны 157 иргэний цэргийн үүрэгтний нэрсийн жагсаалтаар үзлэг шалгалт явуулж, бусад байгууллагуудын 18-50 насны иргэдийг шалган Батлан хамгаалах хууль, тогтоомж, иргэний цэргийн үүргийн талаар танилцуулж, Төрийн Батлан хамгаалах үйлчилгээг иргэдэд ажлын байран дээр нь хүргэж байна. | | | | | | | | |
| 150 | | Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн мэргэжил олгох болон Бэлтгэл офицерын мэргэжил олгох сургалт зохион байгуулна. | 2,000.00 | Дүүргийн төсөв | Цэргийн бэлтгэл сургалтад бүрэн хамруулна. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | ЦШ, Хороод | 100% |
| | | Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд цэргийн мэргэжил олгох давтан сургалтыг ЗХ-ний 326 дугаар ангитай хамтран 2021.09.13-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Бэлтгэл офицерын сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 14-ны өдөр цахим хэлбэрээр явагсан. | | | | | | | | |
| 151 | | Удирдах албан тушаалтнуудын цэргийн бэлтгэл сургалт зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Сургалтад бүрэн хамруулна. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | ЦШ | 100% |
| | | Хороодын Засаг дарга нар, зохион байгуулагч нартай Төрийн болон албаны нууц хадгалалт хамгаалалтын талаар, дайчилгааны тухай хууль болон орон нутгийн хамгаалалтын тухай хууль, мөн дайчилгаагаар татан нийлүүлэх төлөвлөгөө боловсруулах, цэргийн албаны тухай хуулийн хэрэгжилт, цэрэг татлагын талаар сургалтуудыг 2021 оны 08 сарын 18-19-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газарт зохион байгууллаа. Мөн хороодын Засаг дарга нарын Цэргийн бэлтгэл сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газар, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн материаллаг бааз, техник хэрэгслийг ашиглан 100 хувийн хамралттай зохион байгууллаа. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 152 | | Цэргийн штабуудын офицер, ахлагч нарын даргын бэлтгэл сургалт зохион байгуулна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | Нийслэл дүүргүүдийн цэргийн штабын офицер,ахлагч нар оролцоно. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | ЦШ, НЗДТГ -ын ЦШ | 70% |
| | | Дээрх сургалтын нэгдүгээр шатны сургалт 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдаж явагдсан. Хоёрдугаар шатны сургалт бэлтгэлийг Сонгино хайрхан дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран 12 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна. | | | | | | | | |
| 153 | | Оюутан цэрэг-т цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулна. | 2,500.00 | Дүүргийн төсөв | Оюутнууд оролцоно. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | ЦШ, ҮБХИС | 0% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/313 дугаар захирамж ‘‘Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” болон дүүргийн ЗДТГ-ын даргын өгсөн үүргийн дагуу Ковид-19 цар тахлын улмаас тус сургалт цуцлагдсан. | | | | | | | | |
| 154 | | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын анхан болон гүнзгийрүүлсэн шатны дадлага олгох сургалт зохион байгуулна. | 6,000.00 | Дүүргийн төсөв | Цэргийн албыг биер дүйцүүлэн хаагчдыг сургалтад бүрэн хамруулна. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | ЦШ, Хороод | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2021 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалтыг зохион байгуулах тухай” А/22 дугаар тушаалаар дүүргийн дүйцүүлэх алба хаагчдыг Нийслэлийн Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн байрлалд 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 19-ний өдрийг дуустал 14 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсан. Мөн дүүргийн Засаг даргын 2021 оны А/331 дүгээр захирамжийн дагуу Хан-Уул дүүргийн Гал түймэр унтраах, аврах 14 дүгээр ангийн байрлалд “Цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт”-ыг 2021 оны 10 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. | | | | | | | | |
| 155 | | Цэргийн үүрэгтэн бэлтгэл офицеруудын бүртгэл, нэг, хоёрдугаар | 43,500.00 | Дүүргийн төсөв | Цэргийн бэлтгэл үүрэгтэн,цэргийн насны | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн бүртгэл чанартай явагдаж, хяналтын тоог бүрэн биелүүлсэн байна. | ЦШ, Хороод | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ээлжийн цэрэг татлага, халалтыг зохион байгуулна. | | | залуучууд оролцоно. | | | | |
| | | Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны “Цэргийн бүртгэл явуулах тухай” А/331 дүгээр журмыг удирдлага болгон нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1279 дүгээр захирамж, дүүргийн 2020 оны А/414 дүгээр захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд 21 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 1 дүгээр сарын 27-ны өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгууллаа. Мөн 2020 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэрэгт цэргийн албаа хааж, халагдаж ирсэн дайчдыг дүүргийн VIII хорооны иргэний танхимд 2021 оны 10 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Мөн 2021 оны II ээлжийн цэрэг татлагыг 2021 оны 10 дугаар сарын 21-24-ны өдрүүдэд нийслэлийн 31 дүгээр дунд сургуулийн байранд зохион байгуулсан. | | | | | | | |
| 156 | | Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах цэргийн албаа хааж байгаа дайчдын санал сэтгэгдлийг сонсоно. | 9,000.00 | Дүүргийн төсөв | Цэргийн алба хааж байгаа дайчид оролцоно. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | ЦШ | 100% |
| | | Дүүргээс цэргийн жинхэн албыг хилийн цэргийн ангиудад алба хааж байгаа дайчидын ар гэрт болон биеэр дүйцүүлэн алба хааж байгаа алба хаагчдад 60 ширхэг хүнсний багц, Мөн цэргийн албыг биеэр дүйцүүлэн алба хааж байгаа 4 албан хаагчдад дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2021 оны 05 сарын 26-ны өдөр хүнсний багц олгосон. | | | | | | | |
| 157 | | Дайчилгаатай команд штабын хээрийн сургууль зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Цэргийн бэлтгэл үүрэгтнүүд оролцоно. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Бэлэн байдал дээшилсэн байна. | ЦШ, Хороод | 0% |
| | | Команд штабын сургуулийг 2021 оны 02 дугаар 19-23-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсан. Дайчилгаатай хээрийн сургууль нь нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/313 дугаар захирамж ‘‘Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” болон Ковид-19 цар тахалын улмаас МУ-ын ЗГ-аас дайчилгаатай команд штабын хээрийн сургуулийг зохион байгуулаагүй. | | | | | | | |
| 158 | | Орон нутгийн хамгаалалтын хуулийг сурталчлах, Дайчилгаа | 5,000.00 | Дүүргийн төсөв | Томилгоот бүрэлдэхүүн оролцоно. | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Бэлэн байдал дээшилсэн байна. | ЦШ | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх байр, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулна. | | | | | | | | |
| | | Орон нутгийн хамгаалалтын хуулийг сурталчлах, Дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх байр, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2021 оны 12 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | | | | | | | | |
| 159 | | Нийслэл, дүүргийн Засаг даргын нэрэмжит дүүргүүдийн Ерөнхий боловсролын сургуулийн дунд зохиогдох цэрэг спортын "Дөл" тоглолтыг зохион байгуулна. | 6,000.00 | Дүүргийн төсөв | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид оролцоно | Тоо | Захирамж, тушаалын дагуу | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид эх оронч сэтгэлгээтэй болсон байна. | ЦШ, НХХ, БХ | 0% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/313 дугаар захирамж ‘‘Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” болон дүүргийн ЗДТГ-ын даргын өгсөн үүргийн дагуу Ковид-19 цар тахлын улмаас тус сургалт цуцлагдсан. | | | | | | | | |
| 160 | 4.3.7 Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу жил тутам, 5, 10 жилийн давтамжтай тооллогыг дүүргийн нутаг дэвсгэрт чанартай зохион байгуулна. | Мал, тэжээвэр амьтан, Аж ахуйн нэгж, Хөдөө аж ахуйн тооллогуудыг дүүргийн нутаг дэвсгэрт чанартай зохион байгуулна. | 15,000.0 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Тооллогыг чанартай зохион байгуулсан байна. | СХ | 100% |
| | | • Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “Тооллого явуулах тухай” А/928 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/.... дугаар захирамж гарч, дүүргийн Засаг даргын орлогчоор ахлуулсан Тооллогын комиссыг байгуулж, бүрэлдэхүүнийг баталсан. | | | | | | | | |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="9">

• Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд хороодын зохион байгуулагч болон тооллогод ажиллах тоологч нарт 12 дагаар сарын 7-ны өдөр сургалт байгуулж, тооллогын зохион байгуулалт, маягтыг хэрхэн үнэн зөв алдаагүй бөглөх, анхаарах асуудлын талаар мэдээлэл, чиглэл өгч, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа.<br>• Мөн тооллогын бэлтгэл ажил болон тоолох үе шатанд шаардагдах төсвийг батлуулан, маягт, материал, гарын авлага, бал, тээврийн зардал, холбоо барих утасны нэгж, мөн халдвар хамгааллын хэрэгслээр (1 удаагийн маск, бээлий, гар ариутгагч) боломжоороо хангаж ажиллав.<br>• Тооллоготой холбоотой лавлагаа, мэдээллийг холбоо барьж шийдвэрлүүлэх зорилгоор тооллогын хугацаанд Хариуцлагатай жижүүрийн хуваарийг баталж, мөрдөн ажиллав.<br>• Тооллогыг 12 дугаар сарын 7-ноос эхлүүлэн 7 хоногийн хугацаатай зохион байгуулан ажиллаж байна.<br><br>Тооллогын дүн мэдээ 12 дугаар сарын 25-наар эцэслэн гарна.</td></tr>
<tr><td rowspan="2">161</td><td rowspan="4">4.3.8 Статистикийн албан ёсны болон анхан шатны нэгж хороодод бүртгэгддэг “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн баяжилт, бүртгэлийг сайжруулснаар, төрийн мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.</td><td>Хороодын "Хүн ам, өрхийн мэдээллийн сан"-г бүрэн бүрдүүлэх, баяжуулан сайжруулах ажлыг зохион байгуулна.</td><td>3,000.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</td><td>Хувь</td><td></td><td>Хороодын мэдээллийн санг бүрэн бүрдүүлж, тухайн жилийн баяжилт хийгдсэн байна.</td><td>СХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">• Дүүргийн “Хүн ам, өрхийн мэдээллийн сан” (ХАӨМС)-г бүрэн бүрдүүлэх, баяжилтыг хийх зорилгоор 20 хороодыг мэргэжил аргазүйгээр хангаж ажиллав.<br>• Мөн жилийн эцсийн өрх, хүн амын (ХА-3) мэдээг ХАӨМС-гаас татахтай холбоотойгоор анхан шатны нэгж хороодын анхдагч мэдээллийг сайжруулах чиглэлээр 10 дугаар сарын 15-ны өдрийн “Албан ёсны статистикийн мэдээллийн чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх тухай” А/354 дүгээр захирамж гарч, хороодын зохион байгуулагч нарт сургалт зохион байгуулан, 11 дүгээр сарын 30-ны дотор мэдээ, тайлангаа хугацаандаа ирүүлэх, мэдээллийн чанараа сайжруулах үүрэг, чиглэлийг өгч, холбогдох ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүний үр дүнд хороодын Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн чанар, бодит байдал дээшилсэн.<br>ХАӨМС-гийн баяжилт, чанар, алдаанд онцгой анхаарч, шинэ төрсөн болон нас барсан иргэдийн мэдээллийг тухай бүр нь санд оруулах арга хэмжээг авч, сангийн алдааг засварлах ажил үргэлжлэн хийгдэж байна. 2021 онд шинээр төрсөн 2226 (100.0%) хүүхэд, нас барсан 717 (100.0%) хүний мэдээллийг санд бүрэн оруулж ажиллав.</td></tr>
<tr><td rowspan="2">162</td><td>Албан ёсны статистикийн мэдээллийг цахимжуулна.</td><td>1,500.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</td><td>Хувь</td><td></td><td>Албан ёсны мэдээ, тайлан бүрэн цахимжсан байна.</td><td>СХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">• Сар, улирал, жилийн мэдээг цахимжуулах ажлын хүрээнд ҮСХ-ноос программ хангамжийн сайжруулалт, хөгжүүлэлтийг хийсэн бөгөөд 2021 оны 2 сараас эхлэн цахимаар мэдээллийг цуглуулах ажлыг үе шаттай зохион байгуулж ажиллав.</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Оны эцсийн байдлаар Аж үйлдвэр, Барилга, Зоогийн газар, Зочид буудал, Сүм хийд, Орон сууц, нийтийн аж ахуй зэрэг 6 салбарын албан ёсны статистикийн мэдээг цахимжуулах арга хэмжээ авч ажиллалаа. | | | | | | | | |
| 163 | | Дүүргийн Нийгэм, эдийн засгийн эмхэтгэл, танилцуулга бэлтгэн хэвлэх, тархаах ажлыг зохион байгуулна. (1992-2023) | 3,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Хэрэглэгчид хэрэгцээт мэдээллээр хангагдсан байна. | Сх | 100% |
| | | • Тус хэлтсээс албан ёсны болон захиргааны статистикийн тоон мэдээлэлд үндэслэн салбарын танилцуулгуудыг бэлтгэн гаргаад байна. Харин “Дэвжин дээшлэх Сүхбаатар дүүрэг”, “Дүүргийн хөгжил-Нийслэлд эзлэх байр суурь-2020” жилийн Нийгэм, эдийн засгийн танилцуулга, эмхэтгэл нэгтгэгдэж бэлэн болоод байна. | | | | | | | | |
| 164 | 4.3.9 Албан ёсны Статистикийн мэдээ, тайланг бүрэн цахимжуулах чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Аж ахуйн нэгж, байгууллага болон дүүргийн харьяа хэлтэс, хороодын ажлын албадын ажилтан, албан хаагчид статистикийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулж, мэргэшүүлэх, чадваржуулна. | Албан ёсны Статистикийн мэдээг цахимжуулахад дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мэдээлэгч ААНБ, хороодын албан хаагчдад үе шаттай сургалт зохион байгуулна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Албан ёсны статистикийн мэдээллийн хамралт, чанар дээшилж, цахимжсан байна. | Сх | 100% |
| | | ○ Ковид-19 цар тахлын улмаас тайлант хугацаанд “Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал”-ын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус олон сургалтууд цуцлагдсан.<br>○ Статистикийн байгууллагын 97 жилийн ойг угтан ХААИС-ийн Бизнесийн сургуулийн төгсөх курсын 40 гаруй оюутанд ***“Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх нь”*** сургалтыг 11-р сард зохион байгууллаа.<br>○ Хороодын Зохион байгуулагч нарт “***Албан ёсны статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах нь”,*** нийгмийн ажилтнуудад **“Нийгмийн зарим үзүүлэлтийн (НЗҮ-1)”** мэдээг хэрхэн гаргах, анхаарах асуудал, ач холбогдлыг таниулсан сургалтыг зохион байгуулав.<br>Мөн хороодын зохион байгуулагч нарт **“ХАӨМС, Жилийн эцсийн бусад мэдээ, анхаарах асуудал-2021”, “Тэжээвэр амьтдын тооллого-2021”** сургалтыг 12 дугаар сарын 10-ны дотор зохион байгуулахаар төлөвлөөд байна. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | • Албан ёсны статистикийн мэдээнд хамрагддаг 5 Аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээний ач холбогдол, программын талаарх ажлын байран дахь сургалтыг зохион байгуулав. | | | | | | | | |
| 165 | 4.3.11 Улсын бүртгэгч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, албан хаагчийн ёс зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулж, иргэдэд хууль эрх зүйн сургалтыг бүсчлэн зохион байгуулна. | Улсын бүртгэгчийн сургалтыг зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | 2 удаагийн сургалт | Тоо | 2020 онд 51 улсын бүртгэгчид сургалт зохион байгуулсан. | Улсын бүртгэгч нарт 2 удаа сургалт зохион байгуулсан байна. | БүХ | 100% |
| | | Мэдээлэл удирдах программд хороодын улсын бүртггэч нарыг чадавхжуулах сургалт 2021.03<br>Шинээр томилогдсон албан хаагчдад бүртгэл хөтлөх, анхаарах асуудал 2021.04<br>“Төрийн албан хаагчийн ёс зүйн” талаар Улаанбаатар дээд сургуулийн багш хуульч доктор Б.Нарангаравыг урьж оролцуулан онлайн сургалтыг зохион байгуулсан. 2021.10.01<br>5, 8, 10, 11, 12, 20 дугаар хороодод иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэнтэй холбогдуулан дээрх хороодын улсын бүртгэгч нарт бүртгэл хөтлөх хууль дүрэм журам, анхаарах асуудал, оплайн программд хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулсан. 2021.05.21<br>“Койка” сангаас бүх хороодод шинэ тоног төхөөрөмж олгож суурилуулсантай холбоотойгоор шинэ программын сургалтад 20 хорооны улсын бүртгэгчид бүрэн хамрагдлаа. Сургалтыг Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийг хүн тус бүрээр бүртгэл хийлгэж дадлага олгох байдлаар амжилттай зохион байгууллаа. 2021.10.01<br>Хэлтсийн албан хаагчийг чадавхжуулах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Дүүргийн хурлын зааланд Сүхбаатар дүүргийн хяналтын улсын байцаагч Л.Энхцэцэг, Оргил нэгдсэн төвийн хяналтын улсын байцаагч Н.Ичинноров нар “Нотлох баримтыг үнэлэх арга зүй” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулж Хэлтсийн албан хаагчид 100 хувь хамрагдлаа.<br>Шинэчилсэн бүртгэлийн зураг засах дадлага ажил тасгийн сургалтаар хороодын улсын бүртгэгч нар 11 сарын 08,12-нд 2 удаа хороодын улсын бүртгэгч нарт улсын бүртгэгч Н.Дэлгэр сургалт зохион байгуулсан. | | | | | | | | |
| 166 | | Иргэдэд жил бүр сургалт зохион байгуулж, Зорилтот бүлгийн иргэдийг бичиг баримтжуулна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | Сургалтад 2000 иргэнийг хамруулж, 800 иргэнийг бичиг баримтжуулна. | Тоо | | 500 иргэнийг сургалтад хамруулж, 200 иргэнийг бичиг баримтжуулсан байна. | БүХ | 100% |
| | | 10000 иргэнийг сургалтад хамруулж, Иргэний шилжин суурьших хөдөлгөөний цахим бүртгэл” төслийн хүрээнд дүүргийн Зорилтот бүлгийн иргэдийг бичиг баримтжуулах зорилгоор Олон улсын шилжилт хөдөлгөөний байгуулагатай хамтран 2 удаагийн судалгаагаар нийт 69 иргэний цахим үнэмлэхийг хэвлэж гардуулан өглөө. Мөн дүүргийн “Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс”-тэй хамтран 24 иргэнийг бичиг баримтжуулсан.<br>-"Иргэний улсын бүртгэлийн тухай хууль журам, шинэчлэгдсэн үнэ тариф" сэдвээр 6 дугаар хорооны улсын бүртгэгч Оюунцэцэг Хорооны ажлын алба, хэсгийн ахлагч нарт танхимын сургалт зохион байгуулсан.<br>-Гэрлэх ёслолын ордонтой хамтран "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдвээр шинэ гэрлэсэн залуу хосуудад зориулсан сургалтыг зохион байгуулсан. | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 167 | 4.3.12 Сургалтын байгууллагуудад хяналт шалгалт хийнэ. | Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын чанарт хяналт хийнэ. | 300.00 | Дүүргийн төсөв | Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, зөрчил арилгуулалт, буурсан объектын тоо, хувь | Тоо | Хууль тогтоомжийн хэрэгжилт 76% хэрэгжсэн. | Хяналт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшин, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг нэмэгдүүлсэн байна. | МХХ | 100% |
| | | - МХЕГ-ын дэд даргын баталсан 01/101 дүгээр "Ерөнхий боловсролын сургуулийн давтлага зохион байгуулах үйл ажиллагаанд шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу ерөнхий боловсролын 33 сургуульд төлөвлөгөөт бус шалгалтыг 2021.08.01-08.30-ны өдрүүдэд хийлээ. ЭЕШ-т бэлтгэн давтлага зохион байгуулж байгаа 33 сургууль нь бүгд давтлага эхлэхийн өмнө мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэсэн, ковид-19-ын халдвараас сэргийлэх, зай барих, гараа тогтмол угаах, агаар сэлгэлт хийх анхааруулга, санамж, зөвлөмжийг анги танхим, бие засах газар, коридорт байршуулсан, орох гарах хөдөлгөөнийг давхцуулахгүй, нэг чигийн урсгалтай зохион байгуулсан, нэг ангид байх сурагчийн тоог 4-10, хоорондын зай 1.5-2м байхаар тэмдэг тэмдэглэгээтэй, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлсэн, түр тусгаарлах өрөөг гарган, эмчээр хариуцуулан томилсон, эмчгүй сургууль ахлахын менежер болон нярав хариуцан ажиллахаар зохион байгуулсан, сэжигтэй тохиолдлыг үзэж тэмдэглэл хөтлөх, эцэг эхэд нь мэдээллэх, эмнэлгийн байгууллагад хандуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. БШУ-ны сайдын 2021 оны А/171 дүгээр "Давтлага зохион байгуулах заавар батлах тухай" тушаал, НМХГ-ын дэд даргын баталсан 02-02/150 дугаар мэдэгдлийг төрийн болон төрийн бус өмчийн 37 сургуульд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөмж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>- Нийслэлийн Засаг даргын 2021 оны 1 дугаар сарын 25-ны өдрийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу дүүргийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Ерөнхий боловсролын сургуулиудад хяналт шалгалт хийх тухай А/390 дүгээр захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран нийт 5 сургуульд хийж, хариуцлагын гэрээний биелэлт, хүнсний чанар аюулгүй байдалд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Хяналт шалгалт үргэлжилж байна.<br>Дүүргийн Засаг даргаас 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ний дагуу 08 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн сар бүрийн 1,3 дахь долоо хоногийн Пүрэв гаригт тухайн гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хуваарийн дагуу 45 дугаар сургууль, 1, 40 дүгээр цэцэрлэгүүдэд “Хариуцлагын гэрээ”-гээр хүлээсэн үүргийн болон өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэнд үнэлгээ хийж, шалгуур үзүүлэлтийн оноог Googlesheets-р бөглөн, Нийгмийн хөгжлийн хэлтэст илтгэх хуудсаар илгээн ажиллаж байна. | | | | | | | | |
| 4.4 Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлнэ. | | | | | | | | | | |
| 168 | 4.4.1 Гадаад харилцааг өргөжүүлэн уламжлалт харилцаатай улс | Хамтын ажиллагаат нийт 3 улсын 5 хот, дүүргүүдтэй хамтын | 100,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | БНСУ-ын 2 дүүрэг, БНХАУ-ын 1 хот, 1 дүүрэг, Япон улсын 1 хот | Хамтын ажиллагаа бэхэжсэн байна. | ТЗУХ, ГХЯ, НЗДТГ | 0% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орны хот, дүүрэгтэй хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлж, шинээр улс орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтооно. | ажиллагааг салбар бүрт өргөжүүлж, 1 ба түүнээс дээш улсын хот, дүүргүүдтэй шинээр харилцаа тогтооно. | | | | | | | | |
| | | БНСУ-н Сөүл хотын Ын-Пён дүүрэгтэй харилцаа, хамтын ажиллагаа тогтоохоор дүүргийн танилцуулгыг англи хэл дээр бэлтгэн хүргүүлж, цахим уулзалтыг товлосон боловч шинэ төрлийн дельта хувилбар тархсанаас үүдэн БНСУ-ын Ын-Пён дүүрэгтэй хийх цахим уулзалт тодорхойгүй хугацаагаар хойшилсон. | | | | | | | | |
| 169 | 4.4.2 Харилцаат хот, дүүргүүд рүү албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт хамруулна. | Уламжлалт харилцаат хот, дүүргүүдээс жил бүр зохион байгуулагддаг сургалт, хурал, үзэсгэлэн яармагт оролцуулна. | 100,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | Жил бүр албан хаагчдыг сургалт, хурал, үзэсгэлэнд хамруулсан. | Албан хаагчдын ажлын идэвх сайжирсан байна. | ТЗУХ, Бүх хэлтэс, нэгж | 100% |
| | | Уламжлалт хамтын ажиллагаат БНСУ-н Сөүл хотын Жонгно дүүрэгтэй хамтран 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Солонгос хоолны өдөрлөгийг цахим хэлбэрээр зохион байгуулан ажиллаа. Тус өдөрлөгөөр Солонгосын уламжлалт 2 төрлийн хоолны сургалтыг явуулсан бөгөөд нийт 100 гаруй иргэд болон дүүргийн албан хаагчид оролцсон. | | | | | | | | |
| 170 | 4.4.3 Гадаад, дотоод хамтын ажиллагаатай хот, дүүргүүдтэй эмч, сувилагч, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг нэмэгдүүлнэ. | Уламжлалт харилцаат 2 улсын 3 дүүрэг болон шинээр хамтын ажиллагаа тогтоосон улсын хот, дүүргүүдэд эмч, сувилагч, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг нэмэгдүүлнэ. | 100,000.00 | Дүүргийн төсөв | Хамтын ажиллагаат 3 улсын 5 хот дүүргүүдтэй хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрүүд нэмэгдсэн байна. | Тоо | Харилцаат 2 улсын 3 дүүрэгтэй сурагч солилцооны хөтөлбөр хэрэгжсэн. | Хөтөлбөрт хамрагдах эмч, сувилагч, багш, сурагчдын тоо нэмэгдсэн байна. | ТЗУХ, Дүүргийн харьяа ЭМТ, ЕБС | 100% |
| | | Найрсаг хамтын ажиллагаат БНСУ-ын Сөүл хотын Жонгно дүүргийн дэмжлэгтэйгээр жил бүр зохион байгуулагддаг Солонгосын Засгийн газрын тэтгэлэгт ЛОГОДИ буюу Орон Нутгийн Хөгжлийн удирдлага хөтөлбөрийн “Орон нутгийн хөгжил, цахим засгийн | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | газар" сэдэвт сургалтад дүүргийн ЗДТГ-ын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга Г.Амгалан оролцсон. Энэ удаагийн хөтөлбөр нь 2021 оны 09 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. | | | | | | | | |
| 171 | 4.4.4 Дүүрэгт гадаадын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжиж, хамтран ажиллана. | Үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллана. | | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | | Санхүүжилт шаардлагатай салбар нэгжид төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. | ТЗУХ, ОУ-ын байгууллагууд | 100% |
| | | 1. Сүхбаатар дүүргийн 25 дугаар цэцэрлэг нь 1956 онд 150 хүүхдийн хүчин чадалтай байгуулагдан, 65 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. 2017 онд цэцэрлэгийн барилгыг дахин төлөвлөлтөд оруулж, Арабын нэгдсэн Эмират улсын 1 сая долларын буцалтгүй тусламжаар 8 бүлэг 240 хүүхдийн хүчин чадалтай болгон өргөтгөн, 2021 оны 8 дугаар сарын 25-нд улсын комисс хүлээн авч, 9 дүгээр сарын 1-нээс үйл ажиллагаагаа хэвийн явуулж эхэлсэн.<br>2. СБД-ийн 68-р цэцэрлэг нь 1973 онд 280 хүүхдийн хүчин чадалтай байгуулагдан 48 жил тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна. 2020 онд Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар бага төвөгшилтэй ангиллын 2 давхар, 120 хүүхдийн хүчин чадал бүхий өргөтгөлийн барилга баригдаж 2021 оны 09 дүгээр сарны 01-ээс ашиглалтанд орж 5 бүлэг нэмэгдэн ажиллаж эхэлсэн. | | | | | | | | |
| 4.5 Иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулна. | | | | | | | | | | |
| 172 | 4.5.1 Байгалийн гамшиг, гал түймэр, гэнэтийн гамшиг ослоос хамгаалах чиглэлээр иргэд, аж ахуй нэгж байгууллага, оюутан, сурагчдыг татан оролцуулж, анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулна. | Иргэд, ААН байгууллага,оюутан, сурагчдад гамшиг аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | Аж ахуйн нэгж байгууллага-120, иргэдэд-25 Оюутан, сурагч-40 | Тоо | Сар бүр гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулан ажилласан. | ААН байгууллага, иргэд, оюутан, сурагчдын ГХ-лах болон ГТА-аас урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилсэн байна. | ОБХ, МУЗХ, ААНБ | 100% |
| | | Аж ахуйн нэгж байгууллагын сургалтыг 62 удаа 1489 албан тушаалтад,<br>Удирдах ажилтны сургалтыг 7 удаа 82 ажилтад,<br>Зорилтот бүлгийн иргэд /өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асран хамгаалагч, бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд/-н сургалтыг 4 удаа 59 зорилтот бүлгийн иргэдэд,<br>Иргэдийн сургалтыг 6 удаа буюу 121 иргэдэд,<br>Оюутан сурагчдын сургалтыг 2 удаа 83 сурагчдад зохион байгуулсан.<br>**Нийт** Гамшгаас хамгаалах менежмент, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэг олгох сургалтыг нийт **81** удаа зохион байгуулж эдгээр сургалтанд нийт **1834** хүн хамрагдсан байна. | | | | | | | | |
| 173 | | Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг байгуулж, мэргэжлийн | 31,200.00 | Дүүргийн төсөв | Дүүргийн 1-20 дугаар хороонд 5 хүний бүрэлдэхүүнтэ | Тоо | Мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоо сайжирч, гамшгаас | Гамшгийн эрсдэл буурсан байна. | ОБХ, МУЗХ, Хороод | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагуудтай хамтран ажиллана. | | | й сайн дурын бүлэг ажиллана. | | хамгаалах мэдлэг дээшилсэн. | | | |
| 192 | | Дүүргийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчлах, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх чиглэлээр төрөл бүрийн зохион байгуулалтын арга хэмжээ авч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | 6000.0 | Дүүргийн төсөв | Ажиллагсдын ур чадвар сайжирч, үйлчилгээний чанар дээшилнэ. | Тоо | Шинэлэг технологийг олон нийтэд сурталчлах аянд 120 гаруй ААН, тэмцээн уралдаанд 30-40 ААН, иргэдийг татан оролцуулсан. | 2 удаагийн сургалт, үзүүлэх сургуульд 30-40 бизнес эрхлэгчдийг, дүүргийн уралдаан тэмцээнд 40-50 үсчин, гоо засалчдыг дэмжиж оролцуулсан байна. | ХХҮХ | 100% |
| | | Шинэчлэн батлагдсан "Үс засах үйлчилгээнд тавих шаардлага" MNS 5160:2020 стандарт, Хумс заслын үйлчилгээний стандарт MNS 6843:2020 стандартуудыг сурталчлан салбарын үйл ажиллагаанд мөрдүүлэх, цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийн үед ажиллах журмыг танилцуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор УБЗАА, МБСҮМТ, Монголын Үсчин, Гоо засалчдын холбоо, Монголын Хумс урлал, гоо сайхны нэгдсэн холбоотой хамтран "Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээний ерөнхий стандарт" сургалтыг 2021.03.10-ны өдөр болон 2021.05.17-ны өдрүүдэд 2 удаа сургалт зохион байгуулж, 160 гаруй ажиллагсдыг хамруулан үс засал, хумс заслын технологи арга ажиллагааг зааж, гарын авлагаар хангасан.<br>Инновацлаг Улаанбаатар Ай Ю Би аяны хүрээнд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд цахим хэрэглээг нэвтрүүлж, байгууллагуудын дотоод зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд ил тод, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх техник технологийн дэвшилтэд шинэчлэлийг бий болгох зорилгоор | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийслэлийн инновацын газрын инкубаторт бойжигч компаниудын хийсэн программ хангамжийг 90 ААНБ-дад танилцуулах сургалтыг 2021.09.30-ны өдөр дүүргийн хурлын танхимд зохион байгуулсан.<br>Халуун усны үйлчилгээ MNS 5163:2002 стандартын хэрэгжилт, үйлчилгээний соёл, чанарыг дээшлүүлэх, эдийн засгийн үр ашгийг сайжруулах зорилгоор УБ хотын Ерөнхий менежерийн 2021.09.06-ны өдрийн А/222 дугаар тушаалаар баталсан “Нийтийн халуун усны үйлчилгээ эрхэлдэг иргэн, ААН-ийн үйл ажиллагаанд шалгалт явуулах тухай” удирдамжийн дагуу 2021.09.08-ны өдөр УБЗАА-ны Дотоод хяналтын хэлтэстэй хамтран дүүргийн 20 халуун усны газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, холбогдох дүрэм журам, стандартыг танилцуулсан. Ковид-19 цар тахлаас шалтгаалан ажиллах хүчгүй болсон, иргэд үйлчлүүлэхээ больсон, ашиг орлого байхгүй, зардал их байгаа гэсэн шалтгаанаар 9 халуун усны газар үйл ажиллагаа зогсоосон байна.<br>Шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Ахуйн үйлчилгээний ажилтны мэдээлэл зөвлөгөөний “Чандмань” төв НҮТББ-аас хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн харилцааны чиглэлээр ахуйн үйлчилгээний салбарын ААНБ-дад сертификат олгох цахим сургалтыг хороодын Ажлын албатай хамтран зохион байгуулсан. | | | | | | | | |
| | | Тогтвортой үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудыг дэмжих, салбарын тэргүүний ААНБ, иргэдийг тодруулж урамшуулна. | 10000.0 | Дүүргийн төсөв | ААНБ-уудын үйл ажиллагаа идэвхэжсэн байна. | Тоо | Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний нийт 70 ААН, иргэнийг шагнаж урамшуулсан. | Нийт 5 ААНБ, 60 иргэнийг шагнаж урамшуулсан байна. | ХХҮХ | 100% |
| 193 | | Монгол улсад Ахуйн үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар үсчин, гоо сайхны салбарт үр бүтээлтэй ажилласан Видал салоны захирал Д.Одонгоо Монгол улсын Гавьяат ажилтан цол тэмдгээр, мөн салбарын үсчин Г.Ганбаяр, Д.Батцоож нарыг Алтан гадас одонгоор, үсчний салбарын 5 ажилтныг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “ӨРГӨМЖЛӨЛ”-өөр, СБД-ийн ИТХ, Засаг даргын хамтарсан шагнал “Хүндэт тэмдэг”-ээр Мастер түлхүүр салоны эрхлэгч С.Ижилсэгийг, “Эж Эрдэнэ” ХХК-ийн халуун усны газрын үйлчилгээний ажилтан С.Эрдэнэчимэг, Анд авто засварын захирал Ц.Сосорбарам нарыг “Хөдөлмөрийн алдар” медалиар тус тус шагнаж, урамшуулсан.<br>Монгол Улсад Худалдааны байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан салбартаа үр бүтээлтэй ажилласан 550 худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарын ажилтнуудыг “Худалдаа 100” медалиар шагнаж урамшуулсан.<br>Мөн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Заан фүүд ХХК-ийн ажилтан Х.Баяртыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Худалдаа, үйлчилгээний тэргүүний ажилтан цол тэмдэгт уламжилж шагнаж урамшуулсан.<br>Дүүргийн 20 дугаар хорооны С.Даниа “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар шалгарсан. | | | | | | | | |
| 194 | 4.6.2 Мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн, | | - | Мал, амьтны гоц халдварт өвчин гаргахгүй байх. Дүүргийн нутаг дэвсгэр малгүй байна. | Тоо | Дүүргийн нутаг дэвсгэр 2020 онд малгүй болсон. Гэр хороололд нийт 40 өрхийн 500 орчим шувуу, 4000 гаруй | Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, нохой, шувуунд вакцин хийж, ариутгал | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.<br>4.6.3 Дүүргийн иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр тогтвортой хангах, бодлого баримталж ажиллана. | зуслангийн бүсүүдэд байнгын хяналт тавьж, мал оруулахгүй байх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | | | | | өрхийн 5200 гаруй нохой байна. | халдваргүйтгэл хийсэн байна. | | |
| | | - Дүүргийн 2020 оны мал, амьтны тооллогын дүнд тулгуурлан дүүргийн Мал эмнэлгийн нэгжийн хариуцан ажиллах 4399 өрхийн 5022 нохой, 33 өрхийн 478 шувууны тоон мэдээллийг Нийслэлийн Мал эмнэлгийн газарт 2021.01.11-ний өдрийн 2/35 дугаар албан бичгээр, гэрийн тэжээвэр, бүртгэлтэй нохойн 2022 онд халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах тоо, шаардагдах эм биобэлдмэл, ариутгал халдваргүйтгэл хийх талбай, бодисын хэмжээг гаргаж, 2021.03.15-ны өдрийн 2/327 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж, дүүргийн 3400 нохойд хийгдэх галзуугийн вакцинжуулалтын ажил 2021 оны 09 дүгээр сараас эхэлж, одоогийн байдлаар 70%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>- Улаанбаатар хотын суурьшлын бүсэд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор НИТХТ-ийн 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”, 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох бүсийн хил хязгаарыг шинэчлэн батлах тухай 21/06 дугаар тогтоол, НХХААГ-аас 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 5/76 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг чиглэлийн дүүргийн МХХ, НХХААГ, ОБХ, ЦГ, ХЗДАА-ны хамтарсан Ажлын хэсэг 2021 оны 05 дугаар сарын 20, 08 дугаар сарын 24, 27, 10 дугаар сарын 21, 11 дүгээр сарын 23-ны өдрүүдэд нийт 5 удаа шалгалт явуулж, мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс /18, 19, 20 дугаар хороо/ зөвшөөрөгдсөн бүс рүү дүүргийн мал бүхий 14 өрх, БЗД-ийн 4 өрх, хөдөө орон нутгийн 1 өрхөд /хонь-477 толгой, үхэр-191 толгой, адуу-259 толгой, нийт 927 толгой/ 02-17/90 дугаартай МХХ-ийн мэдэгдлийг хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгч, малаа гаргахыг шаардаж, гүйцэтгэлийн хяналт тавин ажилласны үр дүнд 12 иргэний 612 толгой / хонь-390, үхэр-60, адуу-162/ малыг зөвшөөрөгдсөн бүс рүү гаргасан.<br>Жилийн эцсийн байдлаар 7 өрхийн 315 толгой /хонь-87, үхэр-131, адуу-97 / малыг гаргах талаар хугацаатай үүрэг өгч, 20 дугаар хорооны иргэн Н.Баяржаргалыг Зөрчлийн тухай хуулийн 15.1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн дагуу 50 нэгжээр, БЗД-ийн 2 иргэнийг тус бүр 150 нэгжээр тус тус торгож, 20 дугаар хорооны Цолмонгийн аманд зөвшөөрөлгүй буусан Төв аймгийн Баянцагаан сумын малчин О.Сүхбаатар, Р.Очирсүх нарт дүүргийн Газрын албанаас газар чөлөөлөх мэдэгдэх хуудас өгч, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. | | | | | | | | |
| 195 | | Нэгдсэн удирдамжийн дагуу худалдаа үйлчилгээний бүх газруудад стандартын шаардлага хангуулах | 3700.0 | Дүүргийн төсөв | Худалдаа, үйлчилгээний чанар, стандарт хангагдана. | Тоо | Нийт 2020 он 10 удаагийн хяналт явуулж, давхардсан тоогоор 700 ААН, иргэний үйл ажиллагааг шалгасан. | Үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйлчилгээний стандарт хангагдсан байна. /Худалдаа-100, хоол үйлдвэрлэл- | ХХҮХ | 100% |

<table>
<tr><td rowspan="2"></td><td rowspan="4"></td><td>аттестатчилал явуулах, ЕБС-ийн Үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина.</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>200,аялал жуулчлал-80, ахуйн үйлчилгээ-30, ЖДҮ-10, нийт-420/</td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="9">- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/141 дүгээр тушаалаар баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчиллын шалгалт явуулах тухай” удирдамжийн дагуу хоол үйлдвэрлэлийн 138, худалдааны 141 нийт 284 аж ахуйн нэгжийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 15, 10 дугаар сарын 01-15-ны өдрүүдэд 2 үе шаттайгаар шалгалтанд хамрууллаа. Шалгалтын бүрэлдэхүүнд дүүргийн Цагдаагийн 1, 2-р хэлтэс, дүүргийн ХХҮХ, Татварын хэлтэс ажиллаж, шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавих шаардлага MNS4946:2019” стандарт, “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS5021:1:2019” стандарт, Худалдаа, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тавих дотоод хяналтын хэрэгжилт, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, “Худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлага” -ын хэрэгжилт зэргийг шалгаж, стандарт шаардлага хангасан худалдааны 159, хоол үйлдвэрлэлийн 150 нийт 309 газрын тусгай зөвшөөрлийг сунгах, 3 газрыг түдгэлзүүлэх, 2 газрын тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг УБЗАА-нд тайлангийн хамт хүргүүлсэн.</td></tr>
<tr><td rowspan="2">196</td><td>Түргэн үйлчилгээний цэгт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.</td><td>10000.0</td><td>Дүүргийн төсөв</td><td>Түргэн үйлчилгээний цэгүүдийг олон улсын жишигт нийцүүлэн, эрүүл ахуй,хүнсний аюулгүй байдлын шаардлага хангуулна.</td><td>Тоо</td><td>2019 онд 21 ТҮЦ, 2020 онд 10 ТҮЦ-ийг нүүлгэж, 60 ТҮЦ-д нийтийн эзэмшлийн зам талбай чөлөөлөх тухай мэдэгдэх хуудас өгсөн.</td><td>ТҮЦ-үүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт, шалгалт явуулж эрүүл ахуйн шаардлага хангуулан, шинээр зөвшөөрөлгүй байрлуулсан ТҮЦ-үүдийг нүүлгэсэн байна.</td><td>ХХҮХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">1. Дүүргийн нутаг дэвсгэрт 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар хүнсний 188, хүнснээс бусад төрлийн 24 нийт 212 ТҮЦ үйл ажиллагаа явуулж байна. Цаашид ТҮЦ-ийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, журам, стандартыг боловсруулж цэгцлэх шаардлагатай байгаа талаарх саналыг УБЗАА-д хүргүүлсэн.<br>2. Дүүргийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 2/429, 2/430, 2/431 2/432 дугаар албан бичгүүдээр дүүргийн ГЗБА, ЦГ, МХХ, ЗЦХ-т дүүргийн нутаг дэвсгэрт шинээр зөвшөөрөлгүй ТҮЦ байрлуулж буй асуудлыг таслан зогсоох үүрэг чиглэлийг хүргүүлсэн.<br>3. Зөвшөөрөлгүй шинээр байрлуулсан болон явган хүний зам талбай хааж байрлуулсан ТҮЦ-үүдийг нүүлгэж газар чөлөөлүүлэх тухай иргэн, аж, ахуйн нэгж болон төрийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтүүдийн дагуу дүүргийн ГЗБА-д 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 2/532 дугаар албан бичгээр газар чөлөөлөх ажлыг зохион байгуулахыг мэдэгдсэн.</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td colspan="9">4. Дүүргийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн Нийтийн эзэмшлийн зам талбай чөлөөлөх тухай А/188 дугаар захирамжийн хүрээнд нийтийн эзэмшлийн зам, талбайд зөвшөөрөлгүй шинээр байрлуулсан болон тохижилт бүтээн байгуулалтын талбай чөлөөлөх зорилгоор нийт 9 ТҮЦ-ийг нүүлгэж нийтийн эзэмшлийн болон байгууллагын эзэмшлийн зам талбайг чөлөөлсөн.<br>Үүнд:<br>- Өглөөний гудамж тохижуулах ажлын хүрээнд 1 дүгээр хороо, Жамъян гүний гудамжинд байрлалтай 2 ТҮЦ-ийг нүүлгэсэн. Мөн тус байршилд 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зөвшөөрөлгүй шинээр ТҮЦ байрлуулсан тул “Мэдэгдэх хуудас” хүргүүлж, дүүргийн ГЗБА, ЦГ-тай хамтран албадан нүүлгэсэн.<br>- ХҮИС-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус дүүргийн 8 дугаар хороо, ХҮИС-ийн гадна талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан Пончик нэртэй зөөврийн байгууламжид дүүргийн ГЗБА-тай хамтран Мэдэгдэх хуудас хүргүүлж нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлсөн.<br>- Дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 4 дүгээр хороо, 40 дүгээр байрны баруун хойно явган хүний зам, талбай дээр, 1 дүгээр хороо, ЧӨЧ, Баянгол зочид буудлын автобусны буудлын дэргэд байрлуулсан зайрмагны 2 ТҮЦ-д Мэдэгдэх хуудас хүргүүлж, явган хүний зам талбайг чөлөөлсөн.<br>5. ШУТИС-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 8 дугаар хороо, Бага тойруу-34, тус сургуулийн хичээлийн 2 дугаар байрны зүүн хойд талд байрлаж буй ТҮЦ-т Шаардах хуудас хүргүүлэн ШУТИС-ийн эзэмшил газрыг 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр чөлөөлсөн.</td>
</tr>
<tr>
<td>197</td>
<td></td>
<td>Дүүргийн Худалдаа үйлчилгээг зохицуулах Зөвлөл болон Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж,</td>
<td>5000.0</td>
<td>Дүүргийн төсөв</td>
<td>Үйл ажиллагааны хэрэгжилт, тоо</td>
<td>Тоо</td>
<td>2020 онд Засаг даргын дэргэдэх 2 Зөвлөл 18 удаа хуралдаж холбогдох шийдвэрийг гарган, хэрэгжилтийг хангуулан ажилласан.</td>
<td>Зөвлөлийн шийдвэрийн дагуу чанар, стандартын шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүнийг устгалд оруулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна.</td>
<td>ХХҮХ</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдох арга хэмжээг авч ажиллана. | | | | | | | | |
| | | 1. Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаанаас Дэлхий нийтийг хамарсан цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилтын хүрээнд төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасгаж, түргэн шуурхай үйлчлэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллах чиглэл өгсөн, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021.03.16-ны өдрийн 01/560 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Зөвлөлийн хурлаар шийдвэрлэн хэрэгжүүлж байна.<br>2. Зөвлөл 2021 онд 4 удаа хуралдаж, хураагдсан эд, бараа, бүтээгдэхүүний үнэлгээг хийж, холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд:<br>- Хууль бусаар мод бэлтгэхэд ашигласан цахилгаан хөрөөг, үнэлэх боломжгүй, дахин ашиглаж болно гэж шийдвэрлэсэн тул Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т үнэ төлбөргүй шилжүүлсэн;<br>- Гар дээрээс согтууруулах ундаа худалдах үйлдэлдээ ашигласан 4 гар утас;<br>- Гарал үүсэл нь тодорхойгүй 35 литр болон 1,25 литр савлагаатай спирт, бүтээгдэхүүний дагалдах бичиггүй 50 кг 3 шуудай цайруулсан хуш модны самар;<br>- Бүтээгдэхүүний бүрэн, бүтэн байдал алдагдсан гэмтэлтэй, худалдан борлуулах боломжгүй согтууруулах ундаа болон утаат тамхи, хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүн;<br>- Монгол Улсын Эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, гоо сайхны тарилга;<br>- Хууль бусаар агнасан чоны арьс, мах, ондотрын мах зэрэг худалдан борлуулах хориотой эд зүйлийг үнэлэх боломжгүй гэж үзэн Устгалын комисст шилжүүлэн холбогдох хууль журмын дагуу устгалд оруулах чиглэл өгч ажилласан.<br>Устгалын комисс нь Үнэлгээний комиссын 2021.01.20-ны өдрийн хурлын шийдвэр, дүүргийн Цагдаагийн газрын 1, 2-р хэлтэс, МХХ-с ирүүлсэн албан бичгийг үндэслэн согтууруулах төрлийн шингэн, амьтны гаралтай зүйлс, эм эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлийн 17000 ширхэг орчим эд зүйл, хэрэгслийг устгаж, актаар баримтжуулсан.<br>- Худалдан борлуулах комиссоос стандарт, шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг холбогдох журмын дагуу Мастер фудс ХХК, ОЧУХ ХХК, Цэнхэр мана ХХК-д тус тус шилжүүлэн, Төрийн сангийн 100200600910 дансанд 5037150 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан. Мөн Үндэссайхан ХХК, Цэнхэр мана ХХК-с гаргасан хүсэлтийн дагуу хамтран ажиллах гэрээг цуцалсан.<br>Зөвлөл нь харъяалах нутаг дэвсгэрийн прокурорын байгууллагад тайлан мэдээг Bilguun98@gmail.com хаягаар болон 2021.09.01-ний өдрийн 3/1207 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | | | | | | | |
| 198 | | Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг дүүргийн нутаг дэвсгэрт хангуулан ажиллана. | 500.0 | Дүүргийн төсөв | Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгах мэдэгдэл, шаардлагыг хүргүүлэх, үр | Тоо | 2020 оны байдлаар тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо 253 байна. | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүнг тооцож ажиллана. | | | | | |
| | | Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2021 оны А/28, А/114, А/151, А/172, А/282, А/332, А/356 дугаар захирамжуудаар худалдааны 8 цэгт тамхи худалдах зөвшөөрлийг шинээр олгож, 26 цэгийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийн эрхийг сунгалаа. 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 137 худалдааны цэг тамхи худалдаалах тусгай зөвшөөрөлтэй ажиллаж байна. | | | | | | | | |
| 199 | | Дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг сайжруулж, төрөл бүрийн сургалт зохион байгуулж, төмс, хүнсний ногооны борлуулалтын сүлжээ цэгүүдийн тоог нэмэгдүүлнэ. | 3000.0 | Дүүргийн төсөв | Иргэдийн хүнсний хэрэглээний талаарх мэдлэг, ур чадвар дээшилж, иргэдийн орлого нэмэгдэнэ. | Тоо | Хавар, намрын сургалтад нийт 180 гаруй өрхийн тариалан эрхлэгчдийг хамруулсан. 4 борлуулалтын цэгт 12 хүнийг ажлын байраар хангасан. | 2 удаагийн сургалтад 150 иргэнийг хамруулж, 16 ногоочдыг дэмжин ажилласан байна. | ХХҮХ | 100% |
| | | Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж, өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж, хаврын тариалалтад зориулан НХХААГ-аас дүүргийн 13, 15, 16 дугаар хорооны өрхийн тариалан эрхлэгчдийн бүлгүүдэд шар лууван 4 кг, шар манжин 0,5 кг, хүрэн манжин 1 кг, урт сонгино 7 кг, бууцай 1 кг, тарвас 0,05 кг, хүлэмжийн хэмх 1 уут буюу 100 ш, чинжүү 0,5 кг, нийт 238,301 төгрөгийн үнэ бүхий 8 төрлийн үрийг 80%-ийн хөнгөлөлттэй үнээр, Тамгын газрын даргын 2021.05.12-ны өдрийн А/56 дугаар тушаалаар 150 гаруй өрхийн тариалан эрхлэгч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Итгэлийн оч гал дөл холбоонд гала элит сортын 1,2 тн үрийн төмсийг үнэ төлбөргүй олгож, үр худалдан авахад шаардагдах 540,000 төгрөгийг дүүргээс гаргуулсан.<br>Хөдөө аж ахуйг дэмжих сангаас ОХУ, БНХАУ-ын техник тоног төхөөрөмжийн үнэ, худалдан авах нөхцлийн талаарх мэдээллийг өрхийн тариалан эрхлэгчдэд хороодын ажлын албаны цахим хуудас, пейж хуудсуудаар дамжуулан хүргүүлж, холбогдох мэдээллийг сурталчлан, ХХААХҮЯ, НХХААГ, Дижитал медик ХХК-аас хамтран 2021.04.22-ны өдөр зохион байгуулсан “Хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем”” цахим сургалт, “Ургамлын гарал үүсэл, Пестицидийн бүртгэл хяналтын систем” цахим сургалтад 2021.05.26, 2021.06.03,11-ний өдрүүдэд оролцож, өрхийн тариалан эрхлэгчдэд мэдээллийг сурталчлан заавар зөвлөмж өгсөн.<br>Дүүргийн 1 ААН, 155 өрхийн тариалан эрхлэгчид 0,2467 га-д төмс, 1,566 га-д хүнсний ногоо тариалж, намрын ургац хураалтаар 3,944 тн төмс, 19,934 тн хүнсний ногоо хураан авч, хүнсний хэрэгцээгээ хангасан.<br>Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулах, хэрэгцээт хүнсээ дотоодын үйлдвэрлэлээр хангах, импортыг орлох, экспортыг дэмжих зорилтын хүрээнд зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2021” өргөтгөсөн худалдаанд 2 өрхийн тариалан эрхлэгчийг дэмжин оролцуулж, УБ хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/192 дугаар тушаалын дагуу “Алтан намар” арга хэмжээг нийт 7 цэгт зохион эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ мод бут, | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цэцгийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, Төв, Сэлэнгэ, Ховд аймаг болон дүүргийн 32 ногоочдыг ажлын байраар ханган, нийт 42,450 тн төмс, 87,961 тн хүнсний ногоо, 344 шил даршилсан ногоо, жимсний чанамал, 0,3 тн жимс, жимсгэнэ, 17,750 тн тарвас, 80 шил зөгийн бал борлуулж, иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлсэн. | | | | | | | | |
| 200 | | Хүн амын махны хэрэглээг нэмэгдүүлэх, үнэ тогтворжуулах зорилгоор нөөцийн махны жижиглэнгийн болон бөөний өргөтгөсөн худалдаа зохион байгуулна. | 2000.0 | Дүүргийн төсөв | Махны үнэ тогтворжиж, хэрэгцээ хангагдсан байна. | Тн | Нийт 28 хүнсний дэлгүүрээр 184,6 тн мах, өргөтгөсөн худалдаагаар 79.2 тн мах худалдаалагдсан. | Дүүргийн хүн амын хүнсний хангамж нэмэгдүүлж, Жижиглэнгийн худалдааг 30 дэлгүүрт, өргөтгөсөн худалдааг 4 цэгт зохион байгуулсан байна. | ХХҮХ | 100% |
| | | Хүн амын хүнсний хангамжинд махны хэрэглээг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 43 худалдааны цэгээр дамжуулан жижиглэж, савласан 401.72 тонн нөөцийн махыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, махны чанарын хяналт, НӨАТ болон ибаримтын асуудлуудаар дүүргийн МХХ, ТХ-тэй хамтран ажиллалаа.<br>Мөн нөөцөд бэлтгэгдсэн хонины махыг гулуузаар нь худалдаалах ажлыг Саруул зах, 11 хорооллын Эвт төвийн гадна, Хангай хотхон, Бэлх зах, Шарга морьтын Хүслэн дэлгүүрийн гадна талбай зэрэг байршлуудад зохион байгуулж нийт 74,38 тонн махыг худалдан борлуулж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгууллаа. Худалдаанд дүүргийн ЗДТГ-ын ХХҮХ-ийн мэргэжилтнүүд болон ТХ, МХХ, ЦХ-1,2 хэлтсүүдээс нөөцийн махны худалдаанд хяналт тавьж, хамтран ажиллалаа.Нөөцийн махны худалдаа зохион байгуулсан талаарх ажлын тайланг УБЗАА-ны ХҮХҮХ-т 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 8/789 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.<br>Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, махны үнийг тогтворжуулах зорилгоор 2022 оны хаврын улиралд зохион байгуулагдах нөөцийн мах худалдаалах асуудлын хүрээнд 64 худалдааны цэгийн судалгааг 2021 оны 10 дугаар сарын байдлаар гаргаж, УБЗАА-ны ХҮХҮХ-т хүргүүлсэн. Мөн дээрхи аж ахуйн нэгжүүдийн захирал, удирдлагуудад холбогдох хуулиудын дагуу мэдээ, мэдээллийг өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа. | | | | | | | | |
| 201 | | Дүүргийн хүн амын статистик тоон үзүүлэлтэд тулгуурлан жишсэн хүн амын хүнсний хэрэгцээ, гамшгийн үед хэрэглэх хүнсний хангамжийн тооцоог | | - | Хүнсээр хангах албатай гэрээ байгуулсан үйлчилгээний газруудаас дүүргийн хүнсний нөөцийг бүрдүүлнэ. | Тоо | Дүүргийн хүнсний хангамж бүрдүүлэх арга хэмжээнд худалдааны 10, нийтийн хоол үйлдвэрлэлийн 10, нийт 20 ААНБ-ыг татан оролцуулсан. | Дүүргийн хүнсний хангамжийн тооцоо, хүнсний нөөцийн мэдээ үнэ зөв гарсан байна. | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинэчилж, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, мэдээ тайланг тогтмол гаргаж, холбогдох газруудад хүргүүлнэ. | | | | | | | |
| | | Хүнсний тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ"-гээр жишсэн 1 хүний 1 хоногийн хүнснээс авах илчлэг, шим тэжээлийн тооцооллын дагуу Газар хөдлөлтийн гамшгийн үеийн орон нутгийн хүн амын хүнсний нөөц тооцох аргачлалыг үндэслэн дүүргийн 2020 оны хүн амын статистик тоон үзүүлэлтэд тулгуурлан жишсэн хүн ам /1117440.6/-ын хүнсний хэрэгцээ, гамшгийн үед хэрэглэх хүнсний хангамжийн тооцоог 3, 5, 7 хоногоор, болзошгүй эрсдлийн үед хэрэглэгдэх хүнсний тооцоог 50000 хүнээр 100 хоногоор, газар хөдлөлтийн үед шаардагдах хүнсний тооцоог байр хорооллын оршин суугчдын тоонд тулгуурлан тооцож, Хүнсээр хангах албаны гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийсэн.<br>Дүүргийн хүнсний нөөцийн хэмжээ болон хүнсний хангамж, хүртээмжийн тооцоолол, томоохон зах худалдааны төвүүд, мэргэжлийн ангиудын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөц, үнийн мэдээллийг УБЗАА болон дүүргийн шуурхай штабт тогтмол хүргүүлж, ДОК-ийн мэдээллийн google шит дэх эксел файлын Ковид-19 цэсэнд өдөр тутам байрлуулж, дүүргийн Онцгой комиссын гишүүдийг мэдээллээр хангаж ажилласан.<br>Коронавирус /Ковид-19/ халдварт өвчний тархалтын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зорилтот бүлгийн 200 өрхөд дүүргийн Засаг даргын 2021.02.10-ны өдрийн А/43 дугаар захирамжаар 9 688 000 төгрөгийн үнэ бүхий 11 нэр төрөл бүхий хүнсний багцыг Скай хайпермаркет ХХК-аас гэрээ хийн авч, олгосон.<br>Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Коронавируст халдвар (ковид-19) цар тахлын хариу арга хэмжээний явцын үнэлгээг 2021.10.12-ны өдөр гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн зөвлөмжийн 2.4 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам” 8.2.4, 2021 оны 70 дугаар тушаалыг тус тус үндэслэн дүүргийн Эрүүл Мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн газар, Боловсролын хэлтэс, Статистикийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Улаан загалмайн хороо, Онцгой байдлын хэлтэстэй хамтран эрсдлийн үнэлгээг хийсэн. | | | | | | | |
| 202 | 4.6.4 Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын | Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгын стандартыг хангуулна. | 1000.0 | Дүүргийн төсөв | Хоол, хүнс үйлдвэрлэгчдэд хаяг шошгын талаар 2 удаагийн сургалт, хяналт шалгалтыг | Тоо | Хоол тэжээлийн шим тэжээлийн талаарх мэдээллийг 100 ААН хоолны цэсэндээ тусгасан. | Хүнсний үйлдвэр, худалдааны газарт бараа бүтээгдэхүүний хаяг шошгын стандарт хангуулж, хоолны цэсэнд тухайн | ХХҮХ | 100% |

<table>
<tr><td rowspan="2"></td><td rowspan="4">зан үйл хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</td><td></td><td></td><td></td><td>зохион байгуулж, стандартыг хангуулна.</td><td></td><td></td><td>бүтээгдэхүүний шим тэжээлийн үзүүлэлтийг тусгаж хэвшүүлсэн байна.</td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="9">1. Хүнсний үйлдвэр шинээр эрхлэхээр хүсэлт ирүүлсэн 2 аж ахуйн нэгж байгууллагад бүтээгдэхүүний хаяг шошгын стандарт хангаж ажиллах талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.<br>2. Хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 112 аж ахуйн нэгжид “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний зохистой дадал”, “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний зохистой дадал”, шинэчлэгдэн батлагдсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019”, “Кейтеринг үйлчилгээнд тавих шаардлага MNS6885:2020” стандартуудыг сурталчлан, салбарын үйл ажиллагаанд мөрдүүлэх талаар мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгөх сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгууллаа.<br>3. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/141 дүгээр тушаалаар баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчиллын шалгалт явуулах тухай” удирдамжийн дагуу аттестатчилалд хамрагдсан худалдаа, хоол үйлдвэрлэлийн нийт 302 аж ахуйн нэгжид Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгын стандартыг хангуулан ажилласан.</td></tr>
<tr><td rowspan="2">203</td><td>Хоол үйлдвэрлэлийн салбарт стандарт шаардлага хангуулж, зохистой дадал нэвтрүүлнэ.</td><td>2000.0</td><td>Дүүргийн төсөв</td><td>500 иргэн аж ахуйн нэгжид зохистой дадал олгох сургалт зохион байгуулж мэдлэг, мэдээллийг сайжруулна.</td><td>Тоо</td><td>Хоол үйлдвэрлэлийн 250 иргэн, аж ахуйн нэгжийг сургалтад хамруулсан.</td><td>Иргэн, аж ахуйн нэгж сургалтад хамрагдсан байна.</td><td>ХХҮХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">- Тус дүүрэгт согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 112 аж ахуйн нэгжид “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний зохистой дадал”, “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний зохистой дадал”, шинэчлэгдэн батлагдсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019”, “Кейтеринг үйлчилгээнд тавих шаардлага MNS6885:2020” стандартуудыг сурталчлан, салбарын үйл ажиллагаанд мөрдүүлэх, Коронавирус цар тахлын эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрсдлийн үед дагаж мөрдөх түр журмыг танилцуулж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгөх сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналтыг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 15, 10 дугаар сарын 01-ээс 15-ны өдрүүдэд 2 үе шаттайгаар Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/141 дүгээр тушаалаар баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчиллын шалгалт явуулах тухай” удирдамжийн дагуу хоол үйлдвэрлэлийн 150 аж ахуйн нэгжид зохион байгуулж стандарт шаардлага хангуулан ажилласан.<br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран хоол үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийн тогооч, менежерүүдэд “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын тогооч, технологич нарыг мэргэжил, арга зүйгээр хангах нь” сэдэвт гэрчилгээ олгох цахим сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 09.00-17.00 цагийн хооронд цахимаар зохион байгууллаа. Сургалтанд нийт 14 аж ахуйн нэгжийн тогооч, менежерүүдийг хамруулан гэрчилгээ олгосон.</td></tr>
</table>

<table>
<tr><td colspan="11">ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО /АМЬДРАХАД ТААТАЙ ДҮҮРЭГ/</td></tr>
<tr><td colspan="11">5.1 Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг бий болгоно.</td></tr>
<tr><td rowspan="2">204</td><td rowspan="2">5.1.1 Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулна.</td><td>Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулах ажлын зураг, төсөл хийж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ.</td><td>300,000.00</td><td>Улс, Нийслэл, Дүүргийн төсөв</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт, Тоо</td><td>Тоо</td><td>Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн тохижилтын зураг, төсөл хийж байсан.</td><td>Иргэдээс ирсэн саналын дагуу жил бүр хороодод үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.</td><td>ТГХШХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан 2-р хороо, дүүргийн 2-р хороо 31-р байрны гадна ногоон байгууламж, 3-р хороо, дүүргийн 14 а байрны гадна талбайн тохижилт, 5-р хороо, дүүргийн 5-р байрны хойд, урд талд ногоон байгууламж, 7-р хороо, 10-р байрны гадна тохижилт, 7-р хороо, дүүргийн 6-р байрны баруун талд ногоон байгууламж, 17 дугаар хороо, 17 дугаар хорооны ӨЭМТ-ийн шинэ барилгын гадна тохижилт, 17-р хороо, дүүрэг ногоон нуур буюу Дамбадаржаагий н 71-н-б тоотын урд хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн 7 талбайн зураг, төслийг хийж дүүргийн 2021 оны дүүргийн төсөв болон дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийхээр баталж хэрэгжүүлсэн.</td></tr>
<tr><td rowspan="2">205</td><td rowspan="2">5.1.2 Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн нэмж байгуулна.</td><td>Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулна.</td><td>500,000.00</td><td>Улс, Нийслэл, Дүүргийн төсөв</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилт, Тоо</td><td>Тоо</td><td>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019, 2020 онд 4378м2 талбайд ногоон байгууламж хийж байсан.</td><td>ТЭЗҮ боловсруулж, Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн байна.</td><td>ТГХШХ</td><td>100%</td></tr>
<tr><td colspan="9">Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Олон улсын стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, дүүрэг, 18, 19, 20 дугаар хороо/ 500 сая, Хорооны тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 18 дугаар хороо/ 200 сая, 14-р хороо, Жишиг хороо байгуулах, тохижилт /Улаанбаатар, дүүрэг, 14 дүгээр хороо/ 200 сая, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Бүтээн</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /СБД/ 400 сая, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2, 3, 5, 7, 17 дугаар хороонд иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж бүхий тохижилт 787 сая төгрөгөөр хийсэн. | | | | | | | | |
| 5.2 Тохижилт, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | |
| 206 | | Камерын арчлалт, хамгаалалтыг хэрэгжүүлнэ. | 180,000.00 | Дүүргийн төсөв | Ашиглаж байгаа 124 байршлын 276 камер хэвийн ажиллагаатай | Тоо | 581 камер ашиглаж байна. | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орчны хяналтыг сайжруулах зорилгоор ашиглаж байгаа 629 ширхэг хяналтын камерын арчлалт хамгаалалтыг сайжруулж, ашиглагчаар Би энд Эн ХХК-тай 9 дүгээр сар хүртэл, Тэнгэр цэгцрээ ХХК-тай 10 дугаар сараас эхлэн гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. | | | | | | | | |
| 207 | 5.2.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, камержуулах хяналтын цогц шийдлийг нэмэгдүүлнэ. | Сүхбаатар дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд гэрэлтүүлэг, камержуулалт хийнэ. | 800,000.00 | Улс, Нийслэл, Дүүргийн төсөв | Гэрэлтүүлэг, камержуулалтын тоо | Тоо | Дүүргийн 13-20 дугаар хороонд 2017 онд гэрэлтүүлэг, 11-18 дугаар хороонд 2018, 2019 онд камержуулалт хийсэн. | Иргэдээс ирсэн саналын дагуу жил бүр хороодод үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна. | ТГХШХ | 100% |
| | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороонд гэрэлтүүлэг, камержуулалт хийхээр 800 сая төгрөгөөр хийсэн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2, 8, 9, 11-р хороонд 553 сая төгрөгөөр камержуулалт, 1-8, 10, 16 дугаар хороонд 560 сая төгрөгөөр гэрэлтүүлэг хийж ажилласан. | | | | | | | | |
| 208 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн арчлалт, хамгаалалтыг хэрэгжүүлнэ. | 1,199,624.10 | Дүүргийн төсөв | Гэрэлтүүлгийн асалтын хувь 95%-аас багагүй байна. | Хувь | 6444 гэрлийн арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна. | 6444 гэрлийн арчлалт хамгаалалтыг хэрэгжүүлсэн байна. | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 6444 ширхэг гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалтыг Гэрэлтүүлэг чимэглэл ХХК, Спейшл тим ап ХХК, БМЖЛ ХХК-иуд хариуцан ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалт, арчлалт хамгаалалтын ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан нөхцлийн дагуу сард 3 аас доошгүй удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу засвар үйлчилгээг тогтмол хийж байгаа бөгөөд гэрэлтүүлгийн асалт 99,1%-тай байна. | | | | | | | | |
| 209 | | Хөрөнгө оруулалтаар хийгдэх | | | Гэрэлтүүлгийн тоо хэмжээ | Тоо | 6444 гэрлийн арчлалт хамгаалалтыг | Гэрэлтүүлгийн тоо хэмжээ нэмэгдсэн байна. | ТНААХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хяналтын камер, гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэлд хяналт тавина. | | | нэмэгдсэн байна. | | хариуцан ажиллаж байна. | | | |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1-8 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж талбайд 100вт лед гэрэлтүүлгийн толгойг Повер түүл ХХК хийж гүйцэтгэсэн болно. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2-р хороонд 11 камер 8-р хороонд 40 камер 9-р хороонд 8 камер 11-р хороонд 48 камер нийт 107 камер суурилуулан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан болно. | | | | | | | | |
| 210 | 5.2.2 Иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран Сэлбэ цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. | Сэлбэ голын дагуух хийгдсэн тохижилтын ажлын засвар үйлчилгээ, арчлалт хамгаалалт хийнэ. | 450,000.00 | Дүүргийн төсөв | Тохижилт хийгдсэн талбайд засвар үйлчилгээ хийнэ. | Хувь | Сэлбэ голын тохижилт хийгдсэн талбай эвдрэл гэмтэл гарсан байна. | Засвар үйлчилгээ хийсэн байна. | ТНААХ | 30% |
| | | Сэлбэ голын дагуух засвар үйлчилгээний тооцоо, судалгааг гаргаж, дүүргийн 2022 оны төсвийн төсөлд тусгуулахаар бэлтгэж байна. | | | | | | | | |
| 211 | | Иргэд, аж ахуй нэгж байгууллагатай хамтран ногоон байгууламж нэмэгдүүлнэ. | | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | Тохижилттой талбайд гацуур, нарс, монос зэрэг гоёлын бут сөөг таригдаж байгаа болно. | Ногоон байгууламжийн тоо нэмэгдсэн байна. | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажил болох 17 дугаар хороо Өрхийн эмнэлгийн гадна тохижилт, 2 дугаар хороо 31 дүгээр байрны хойд талд тохижилт, 3 дугаар хороо 14а байрны хойд талд тохижилт, 5 дугаар хороо 6 дугаар байрны урд талд тохижилт хийгдэж байгаа ажлуудад 2500м2 ногоон байгууламж шинээр хийж хүлээлгэж өгөөд байна. Мөн бүх нийтийн мод тарих үндэсний өдөр, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн Засаг даргын тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, хороодын ажлын албатай хамтран 17 дугаар хороо Зонхва хайрханы бэлд 2800 ширхэг бут сөөг тарьсан болно. Мөн Монгол ой ТӨҮГ, Сити их сургуулийн оюутнуудтай хамтран 7 хороо сэлбэ гол дагуу 150 ширхэг мод бут сөөг тарьсан болно. | | | | | | | | |
| 212 | 5.2.3 Гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон зам, орон сууцны хороолол доторх авто замыг засварлах, хатуу | Орон сууцны хороолол доторх авто замын нөхөн сэргээлтийн ажил, гэр хороололд | 300,000.00 | Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Хувь | 2020 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9822м2 асфальтан замын нөхөөс хийгдсэн байна. | Хөрөнгө оруулалтын ажилд хяналт тавин ажилласан байна. | ТНААХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хучилттай болгож, тоосжилтыг бууруулна. | шинээр хатуу хучилттай зам тавих | | | | | | | | |
| | | Дүүргийн 12, 13, 16 дугаар хороодын нутаг дэвсгэрт тавигдаж байгаа 590 метр хатуу хучилттай болон чулуун зам шинээр хийх ажлын гүйцэтгэлд Нийслэлийн авто зам хөгжлийн газартай хамтран захиалагчийн хяналт тавьж ажилласан бөгөөд ажлын гүйцэтгэл 100 хувь гүйцэтгэж дуусаад байна. | | | | | | | | |
| 213 | | Гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон замын засварын арчлалтыг хийнэ. | 370,920.00 | Дүүргийн төсөв | 11 байршлын 5818 метр хайрган хучилттай замын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ашиглалтад оруулсан байна. | М2 | Гэр хорооллын намгархаг, ус тогтдог сул шороон хөрс бүхий иргэд зорчиход хүндрэлтэй байдал үүссэн засварлах шаардлагатай 24728 метр зам байна. | Дүүргийн 11-20 дугаар хороонд сайжруулсан шороон замыг засварлаж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн 15, 18, 20 дугаар хороодын нутаг дэвсгэрийн шавар намагтай, иргэд явганаар болон тээврийн хэрэгслээр зорчиход хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн 6 байршилд 6900 метр дайрган хучилттай замын ажилд хяналт тавьж ажилласан бөгөөд ажлын гүйцэтгэл 100 хувь гүйцэтгэж дуусаад байна. | | | | | | | | |
| 214 | 5.2.4 Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн усан оргилуурын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | 73,700.00 | Дүүргийн төсөв | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн усан оргилуурын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | Тоо | Дүүргийн хөрөнгөд бүртгэлтэй нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд 12 усан оргилуур байна. | 12 усан оргилуурын засвар үйлчилгээ, ашиглалтын зардлыг хариуцан байнгын ажиллагаатай болгосон байна. | ТНААХ | 100% |
| | | Эвдрэл гарсан 5-р хороо 39-р байрны усан оргилуурыг цэвэрлэгээ хариуцан ажилладаг Эм Зэм Эм Сийдс ХХК засвар хийж гүйцэтгэсэн болно. | | | | | | | | |
| 215 | 5.2.5 Байгаль орчныг хамгаалах, ногоон байгууламж шинээр бий болгосон иргэд, аж | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын арчлалт | 1,029,989.00 | Дүүргийн төсөв | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилтын ажлын дагуу | Тоо | 1-20 дугаар хорооны 156 байршлын 123254.34м2 талбайн сүүдрэвч, 4505м2 хүүхдийн | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилтын ажлын цэвэрлэгээ, | ТНААХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ахуйн нэгж байгууллагыг дэмжиж, тэдгээрийг арчлан хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | | | хариуцах талбай нэмэгдэнэ. | | тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбайн тохижилт бүтээн байгуулалтын ажлын засвар, цэвэрлэгээ үйлчилгээг хийнэ. | үйлчилгээ хийсэн байна. | | |
| | | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 173 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4405 м2 хүүхдийн тоглоомын талбай, 380 чийрэгжүүлэлтийг төхөөрөмж , 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786 м2 спорт талбай, засвар үйлчилгээг хийлгэхээр 12 бүс болгон аж ахуйн нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. | | | | | | | | |
| 216 | | Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулна. | 56,000.00 | Дүүргийн төсөв | Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулна | Тоо | 2019 онд бүх нийтийн мод тарих өдрөөр дүүргийн хэмжээнд нийт 229 ААН байгууллагын 2400 гаран иргэн 6885 ширхэг мод, 444м2 цэцэг, 4971,1 м2 зүлэг ногоон байгууламж шинээр нэмэгдсэн. | Ногоон байгууламжийн тоо нэмэгдсэн байна. | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын Захирамжаар ажлын хэсэг байгуулагдан тус дүүргэт таригдах 2750 ш 14 төрлийн мод бут сөөг, хар шороо, улс бууцыг гэр хорооллын 9,11,12,13,14,15,16,17,18,19,20 дугаар хороодын 920 өрхөд тараан бүх нийтийн мод тарих арга хэмжээг зохион байгуулсан болно.<br>Мөн намрын бүх нийтийн мод тарих үндэсний өдөр, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн Засаг даргын тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, хороодын ажлын албатай хамтран 17 дугаар хороо Зонхва хайрханы бэлд 2800 ширхэг бут сөөг тарьсан болно. Энэ ажлын хүрээнд дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 169 аж ахуй нэгж байгууллага, 3528 иргэн 6970 ширхэг мод бут сөөг нэмэлтээр тарьсан байна. | | | | | | | | |
| 217 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн | 68,000.00 | Дүүргийн төсөв | Дүүргийн 1-18 дугаар хорооны | Тоо | Дүүргийн 1-18 дугаар хорооны 160 байршилд 2818 | Нийтийн эзэмшлийн мод, | ТНААХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 218 | | мод бутыг хэлбэржүүлэх, шохойдож шуулт хийнэ. | | | нийтийн эзэмшлийн мод, бут сөөгөнд тайралт хийх, хэлбэржүүлэх, шохойдох ажлыг хийнэ. | | ширхэг мод, бут сөөгөнд тайралт хийх, хэлбэржүүлэх, шохойдох ажлын судалгааг боловсруулсан болно. | бут сөөгний ургалт сайжирсан байна. | | |
| | | Дүүргийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/95 дугаар захирамжаар дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хашаан доторх нийт 1452 ш мод 1217 ш бутыг хэлбэржүүлэх ажлыг 5 багц болгон мэргэжлийн аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан болно. | | | | | | | | |
| 218 | | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт хийнэ. | 50,000.00 | Дүүргийн төсөв | Дүүргийн 1-14 дүгээр хороонд орон сууцны хороолол дундах нийтийн эзэмшлийн орон сууцны гаднах орц дундын ногоон байгууламжийн зүлэгт талбай болон мод, бут сөөгний усалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, арчлалт хамгаалалтыг хийнэ. | Тоо | | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн ургалт сайжирсан байна. | ТНААХ, Хороод, СТСХ | 100% |
| | | Дүүргийн нийтийн эзэмшлийн орон сууц гэр хороолол дундах 2487ш мод бут сөөг 20850м2 орц дундын ногоон байгууламжийн усалгаа арчилгааг 3 аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан 2021.05.10-06.10 өдрийн хороонд арчилгаа тордолгоог хийлгэн гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан болно. | | | | | | | | |
| 219 | | Рашаан булгийн эх хамгаалах | 5,400.00 | Дүүргийн төсөв | Рашаан булгийн эх | Хувь | Дүүргийн 15, 16, 20 дугаар хороонд | Тохижуулсан рашаан булгийн эд | ТНААХ | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гэрээт ажилтан ажиллуулна. | | | хамгаалах гэрээт ажилтан ажиллуулна. | | байрлах Зуун модны эхэн дахь Энх мөнхийн рашаан, Гүнжийн булаг, зуун модны рашааны эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан, орчны бохирдлыг бууруулахаар 3 байгаль хамгаалагч ажиллаж байна. | хөрөнгө бүрэн бүтэн, орчин нь бохирдолгүй болсон байна. | Хороод СТСХ | |
| | | Дүүргийн 15, 16, 20 дугаар хороонд байрлах Зуун модны эхэн дахь Энх мөнхийн рашаан, Гүнжийн булаг, зуун модны рашааны эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан, орчны бохирдлыг бууруулахаар 3 байгаль хамгаалагч ажиллуулан сар бүр 150,000 төгрөгний урамшуулал олгож байгаа болно. | | | | | | | | |
